
ДАМПУУРЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааг удирдсан:

Б.Оюунжаргал	МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш Хууль зүйн ухааны доктор
--------------	---

Судалгааны багийн бусад гишүүд:

Б.Нинжин	МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш Хууль зүйн ухааны доктор
Б.Баялагмаа	МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш (LL.M)

Судалгааг захиалагч: Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)

Судалгааны тайланг хүргүүлсэн огноо: 2025.04.22

ГАРЧИГ

УДИРТГАЛ	4
I. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	5
1.1. Үнэлгээ хийх шалтгааны тодорхойлох нь:	5
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	10
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	11
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох	22
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	23
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	23
II. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	24
III. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	27
Нэг. Дампуурлын хэрэг үүсгэх ажиллагаанд хамаарах зохицуулалтад хийсэн үнэлгээ ..	27
1.1. Дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт/ нэхэмжлэл гаргах, хүсэлт хүлээн авч, хэрэг үүсгэх зохицуулалт	27
А. ХБНГУ-д Дампуурлын ажиллагаа эхлүүлэх эрх бүхий этгээдийг дараах байдлаар зохицуулсан	29
В. БНСУ-д Дампуурлын ажиллагаа эхлүүлэх эрх бүхий этгээдийг дараах байдлаар зохицуулсан.	30
1.2. Дампуурлын хэрэг үүсгэх хүсэлтийг хүлээн авахаас татгалзах үндэслэл	32
А. ХБНГУ-ын зохицуулалт	32
В. БНСУ-ын зохицуулалт	33
1.3. Хариуцагчийг төлбөрийн чадваргүйд тооцох зохицуулалт	34
А. ХБНГУ-ын хуульд заасан үүрэг гүйцэтгэгчийн төлбөрийн чадваргүйг тодорхойлох аргууд	35
В. БНСУ-ын хуульд заасан хариуцагчийн төлбөрийн чадваргүйг тодорхойлох аргууд 37	
С. Оросын Холбооны Улсын зохицуулалт	37
1.4. Төлбөрийн чадваргүйд тооцсон шүүгчийн захирамжийн үр дагавар, гомдол гаргах үндэслэл	39
А. ХБНГУ-ын зохицуулалт	42
В. БНСУ-ын зохицуулалт	43
Хоёр. Хэрэг гүйцэтгэгчийн статус, чиг үүрэг	45
2.1. Дампуурлын тухай хууль дахь хэрэг гүйцэтгэгчийн статус, чиг үүрэг, түүний хэрэгжилт	45
2.2. Хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлт, түүний ач холбогдол	46

Гурав. Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа	57
3.1. Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх шүүхийн шийдвэрийн зохицуулалт дутмаг	57
3.2. Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах эрх бүхий субъект	58
3.3. Дахин хөрөнгөжүүлэх хүсэлтэд тавигдах шаардлага.....	60
3.4. Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт хүлээн авсан шүүхийн ажиллагаа	64
А. ХБНГУ-ын хуулийн этгээдийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, сэргээхэд чиглэсэн зохицуулалт.....	64
В. БНСУ-ын хуулийн этгээдийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, сэргээхэд чиглэсэн зохицуулалт	68
Дөрөв. Дампуурлын ажиллагаа дуусгавар болох үндэслэл.....	70
А. ХБНГУ-ын зохицуулалт	71
В. БНСУ-ын зохицуулалт	72

УДИРТГАЛ

Дампуурлын тухай хууль нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 155¹ дугаар зүйлээр заасан хуулийн этгээдийг дампуурсанд тооцох тухай хүсэлт гаргах, түүнийг хянан шийдвэрлэх маргааныг шийдвэрлэх ажиллагааны тусгайлсан хуульд хамаардаг. Иргэний хэргийн шүүх нь Дампуурлын тухай хуулийг баримталж, хуулийн этгээдийг дампуурсанд тооцох хүсэлтийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэж ирсэн. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар хуулийн этгээдийг дампуурсанд тооцох хүсэлтийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэхээр зохицуулсан хэдий ч онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэдэг бусад хэргүүдээс¹ ялгаатай нь тусгайлсан процессоор тухайн маргааныг шийдвэрлэдэг онцлогтой. Тухайн онцлогт үндэслэн дампуурлын хэрэг маргааныг шийдвэрлэх процесс ойлгомжтой, тодорхой байх, шүүхээс хуулийн зорилгод нийцүүлэн зохицуулалтыг нэг мөр тайлбарлаж, хэрэглэх явдал нь чухал ач холбогдолтой.

Хуулийн этгээдийг дампуурсанд тооцох хүсэлтийг хүлээн авч иргэний хэрэг үүсгэх, маргааныг хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгахтай холбогдолтой харилцааг 1997 онд батлагдсан Дампуурлын тухай хуулиар зохицуулж байна. Тус хууль хэрэгжиж эхэлснээс хойш Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2002 онд батлагдсантай холбоотойгоор хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1.6 дах заалт, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэгт өөрчлөлт орсноос бусад тохиолдолд дампуурлын маргааныг хянан шийдвэрлэх процессын зохицуулалтад өөрчлөлт ороогүй байгаа нь дампуурлын маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн хийдэл практикт үүсэж буй эсэх, зохицуулалтын орчин үеийн чиг хандлагатай нийцүүлэх шаардлага үүссэн эсэх судлах судалгааг зайлшгүй хийх шаардлага үүсжээ.

Үүнээс гадна, Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дах хэсэгт заасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх зохицуулалтын хүрээнд Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг тогтмол хийж, шинэчлэл, сайжруулалтыг хийгээгүй байна.

Иймд дампуурлын маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд Дампуурлын тухай хуулийг хэрэглэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг үнэлэх, цаашид зохицуулалтын хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах анхаарах зүйлсийг тодорхойлох зорилгоор тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааг хийсэн болно.

¹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйл.

I. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” (“Аргачлал” гэх)-ын дагуу төлөвлөж, үнэлгээ хэрэгжүүлэх арга замын тодорхойлон үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

Дээрх журамд зааснаар төлөвлөх үе шатанд дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

- 1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- 1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- 1.3. Шалгуур үзүүлэлтийг тогтоох;
- 1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
- 1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
- 1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох;

1.1. Үнэлгээ хийх шалтгааны тодорхойлох нь:

Хууль тогтоомжийн тухай хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болохоор журамласан. Тус хууль нь 2017 оноос хэрэгжиж эхэлснээс хойш энэ хууль, түүнд үндэслэн батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Дампуурлын тухай хуульд 5 жил тутамд хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг үнэлсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулаагүй байгаа нь үнэлгээ хийх хэрэгцээ, шаардлагыг үүсгэж байна.

Дампуурлын хэрэг маргааны хянан шийдвэрлэх ажиллагааг зөвхөн Дампуурлын тухай хуулиар зохицуулахгүй бөгөөд тус хуулийн зохицуулалт нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн онцгой ажиллагааны журамтай уялдаа холбоотой. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 онд батлагдаж, түүнээс хойш нийт 37 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон² бөгөөд маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оруулсан өөрчлөлт нь Дампуурлын тухай хуулийн зохицуулалттай хэрхэн уялдаатай хэрэгжиж буйг судалж, үнэлгээ хийсэн судалгаа байхгүй байна. Харин хуульч, судлаачдаас Монгол Улсын дампуурлын эрх зүйн зохицуулалт, дампуурлын хэрэг маргааныг шийдвэрлэх процессын тулгамдсан асуудлуудыг өөрсдийн судалгааны ажил болон бие даасан эрдэм шинжилгээний өгүүлэл хэлбэрээр гаргаж, нийтэд нийтэлжээ. Тухайлбал, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны баг нь 2022 онд “Хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалт: олон улсын чиг хандлага, зарим улсын туршлага” судалгааг хийж, судалгаагаар Монгол Улсад хувь хүний төлбөрийн чадваргүйдлийг эрх зүйгээр зохицуулах хэрэгцээ, шаардлагыг тандан судлах ажилд дэмжлэг үзүүлэх хүрээнд дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулсан байна. Мөн тус хүрээлэнгээс хийж гүйцэтгэсэн “Аж ахуйн нэгжийн дампуурал ба дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа: харьцуулсан судалгаа”-гаар³ дампуурлын

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=302>

³ <https://nli.gov.mn/pdf/aj-ahuin.pdf>

эрх зүйн орчныг сайжруулах боломжийг тодорхойлох, хуулийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах зөвлөмжүүдийг өгсөн байна. Үүнд:

1. Дампуурлын тухай хуулийн төслийг боловсруулахдаа “Дампуурал ба дахин хөрөнгөжүүлэх тухай” гэсэн агуулгаар хуулийн нэрийг нэрлэх, дампуурлын тухай хуулийн төслийн зорилго, зарчим, агуулгад анхаарч ААН-ийг дахин хөрөнгөжүүлэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үзэл баримтлалыг батлах, Дампуурлын тухай хуулийн төсөлд дахин хөрөнгөжүүлэх арга, хэлбэрийг дэлхийн улс орнуудын хууль тогтоомжийг судлах замаар тусгах;
2. Хэрэг гүйцэтгэгчийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэн, өрсөлдөөнт орчныг бий болгох, тэдний санхүүгийн баталгаа, болон тэдэнд тавигдах шаардлага, оногдуулах хариуцлагыг хуульд тусгах;
3. Хариуцагчийн эсрэг гаргасан нэхэмжлэлийг нэгдсэн байдлаар шийдвэрлэх, төрийн байгууллагуудын харилцан уялдааг хангах, дахин хөрөнгөжүүлэх бодлогын хүрээнд татварын эрх зүйн орчныг сайжруулах болон дахин хөрөнгөжүүлэх бодлогын хүрээнд давж заалдах бодлогыг үр дүнтэй тодорхойлох;
4. Дампуурал, тэр дундаа дахин хөрөнгөжүүлэх асуудлыг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг тусгах;
5. Дампуурах эрсдэлтэй болсон үед шүүхэд даруй мэдэгдэх эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Үүний улмаас аж ахуйн нэгжийн дампуурлын ажиллагаа хугацаа алдах, тухайн аж ахуйн нэгжийг дампуурахаас сэргийлэх, дахин хөрөнгөжүүлэхэд хүндрэл гарч байна. Иймд хууль зөрчигчид оногдуулах хариуцлагыг чангаруулах, торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх мөн дампуурах эрсдэл үүссэн тохиолдолд хэдий хугацааны дотор шүүхэд мэдэгдэх талаар нарийвчилсан зохицуулалт тусгах;
6. Шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх талаар судалж, холбогдох хууль тогтоомжийг боловсруулах шаардлагатай.

Мөн Хууль зүйн доктор, шүүгч Н.Баярмаа нь “Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгагдах онцлог”⁴, “Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, онцлог: гадаадын зарим орны туршлагаас”⁵ сэдэвт өгүүллүүд, “Дампуурлын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа” сэдэвт 2017 оны судалгааны тайлангуудад дараах ач холбогдол бүхий дүгнэлт, санал, зөвлөмжүүдийг гаргажээ. Үүнд:

1. Дампуурлын хуулийн гүйцэтгэж буй процессын эрх зүйн үүрэг тун хангалтгүй байна. Монгол Улсад 21 жилийн турш хүчин төгөлдөр үйлчилсэн Дампуурлын тухай хууль нь олон талаар хоцрогдож нийгмийн хэрэгцээ шаардлага хангахгүй болсон нь илэрхий бөгөөд энэ нь бизнесийн салбарын тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж, үнэнч шударгаар ажиллах, татвараа төлөх үүргээ ухамсарлах, бизнесээ дахин сэргээх боломжтой гэдгийг ойлгох, энэ талаар мэдлэгтэй байх нөхцөл орчин бүрдэхгүй, хуурах, зугтах, нуун далдлах бизнесийн сэтгэл зүй бий болоход нөлөөлөх томоохон хүчин зүйл болж байна.⁶

⁴ <https://legaldata.mn/b/884>

⁵ <https://legaldata.mn/b/368>

⁶ Н.Баярмаа “Дампуурлын хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа: иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгагдах онцлог” өгүүлэл, <https://legaldata.mn/buteel/pdf?id=884>

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтаас Дампуурлын хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа өөрийн гэсэн өвөрмөц шинжтэй бөгөөд бие даасан материаллаг болон процессын эрх зүйн олон талт цогц эрх зүйн орчныг зохих ёсоор шаардах юм.⁷
3. Дампуурлын ажиллагааг эхлүүлэх эрх бүхий этгээд; дамбуурлын ажиллагааг эхлүүлэх процесс; дамбуурлын хэргийн хуваарилагдах хөрөнгөтэй холбоотой харилцаа; үүрэг гүйцэтгэгчийн байгуулсан гэрээ хэлцлүүдийн талаар дамбуурлын хэрэг үүсгэснээс хойш авах арга хэмжээ; дамбуурлын ажиллагаанаас зайлсхийх нөхцөл байдал; үүргийг тооцож дуусгавар болгох; үүрэг гүйцэтгэгч буюу хариуцагчийн эрх, үүрэг, хариуцлага; хэрэг гүйцэтгэгчийн шалгуур, сонсгох, томилох журам, түүнд тавих хяналт, эрх, үүрэг, нууцлалын журам, цалин хөлс, хариуцлага, түүний ажилтнууд, солих, чөлөөлөх журам; нэхэмжлэгч шийдвэр журам, оролцооны механизм, нэхэмжлэгчдийн хурал, санал өгөх журам, нэхэмжлэгчдийн зөвлөл, нууцлал, барьцаат нэхэмжлэгчид; дахин хөрөнгөжүүлэлт; түргэвчилсэн дахин хөрөнгөжүүлэлт; нэхэмжлэл гаргах үйл явц; нэхэмжлэгчдийн дараалал, хөрөнгийг хуваарилах; групп компанийн дамбуурлын ажиллагааны онцлог; дамбуурлын ажиллагааны үр дүнд хамаарах асуудлууд нь дамбуурлын эрх зүйн хүрээнд зайлшгүй анхаарвал зохих чухал асуудлууд байна.⁸

Дээрхээс гадна, Дамбуурлын тухай хуулийг практикт тайлбарлан хэрэглэж, хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийсэн судалгаанаас⁹ үзвэл, дараах дүгнэлт, саналуудыг нь хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажилд анхаарах нь зүйтэй байна. Үүнд:

1. Дамбуурлын үе шатыг зохистойгоор томьёолж, татан буулгах ажиллагааг эхлүүлэх үе шатыг тодорхойлсон хуулийн системчлэл байх нь зүйтэй.
2. Дамбуурлын хэргийг хянан шийдвэрлэх хуулийн тогтоосон хугацаа нь бодит байдалд нийцэхгүй байх тул хуульд заасан хугацааг 2-6 сар хүртэлх хугацаагаар нэмэгдүүлэх шаардлагатай.
3. Шүүгчээс мөрдөн шалгах зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэх тохиолдолд шүүгч өөрийн санаачилгаар нотлох баримтыг цуглуулах, бүрдүүлэх бүрэн эрхийг тодорхой зохицуулах үүрэгтэй.
4. Дамбуурлын хэрэг үүсгэснээс хойш хүсэлт хүсэлт гаргагч нь Дамбуурлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан хүсэлтэд хавсаргах баримтыг хавсаргаагүй буюу бүрдүүлбэр дутуу байх нөхцөл байдал үүссэн нөхцөлд шүүгчээс мөрдөн шалгах зарчмыг хэрэгжүүлж, талуудаас нотлох баримтыг гаргуулах ажиллагааг явуулах, хэргийг удирдах бүрэн эрхээ хэрэгжүүлэх нь зүйтэй. Харин энэ бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйн улмаас үндэслэлгүй шийдвэр гаргасан тохиолдолд дээд шатны шүүхээс шийдвэрийг хүчингүй болгож, дахин шийдвэрлүүлэхээр буцаах арга хэмжээг авах нь зүйтэй.

⁷ Н.Баярмаа “Дамбуурлын хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, онцлог: гадаадын зарим орны туршлагаас”, <https://legalddata.mn/buteel/pdf?id=368>

⁸ Н.Баярмаа “Дамбуурлын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа” <https://legalddata.mn/buteel/pdf?id=324>

⁹ Шүүхийн шийдвэрийн судалгаа, Цуврал 17, 2024 он https://forum.mn/uploads/users/3092/files/Web_SSS_17.pdf

5. Хариуцагч компанийг төлбөрийн чадваргүй болсонтой холбоотойгоор тухай компанид хохирол нөхөн төлөх үүрэг бүхий компанийн эрх бүхий албан тушаалтан байгаа эсэх асуудал болон Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 болон 6.6-д заасны дагуу өрийг давхар болон хамтран хариуцах этгээдүүд байгаа эсэх асуудлыг шүүхийн өөрийн санаачилгаа болон хэрэг гүйцэтгэгчийн хүсэлтээр хянан шийдвэрлэх талаар Дампуурлын тухай хуульд тусгаж өгөх шаардлагатай.
6. Дампуурсанд тооцох хүсэлтийг хэрэгсэхгүй болгох үндэслэлийг хуульчлаагүйн улмаас шүүх бүр өөр өөр үндэслэлээр хэрэгсэхгүй болгож байгааг анхаарах шаардлагатай. Ялангуяа, дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагааг урвуугаар ашиглах боломжийг хаах нь чухал ач холбогдолтой.
7. Хариуцагч компанийг төлбөрийн чадвартай эсэхийг зөвхөн анхан шатны шүүх тогтоох зохицуулалттай байх бөгөөд санхүүгийн байдлын үнэлгээ, үйл ажиллагааны үнэлгээг хийх шаардлагатай.¹⁰

Дээрх судалгааны тайлангуудад дурдсан дүгнэлт, санал, зөвлөмжийг нэгтгэн дүгнэвэл, Дампуурлын тухай хууль аливаа дампуурлын эрх зүйн харилцааг зохицуулахад хангалтгүй, зарим маргааныг шийдвэрлэхэд зохицуулалтыг нэг мөр хэрэглэгддэггүй, дампуурлын хэрэг үүсгэх, татан буулгах ажиллагааг үүсгэх зохицуулалт ойлгомжгүй буюу дампуурлын маргааныг шийдвэрлэх гол эх сурвалж болсон хууль нь тухайн харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байна. Үүнээс гадна, Дампуурлын тухай хуулийг хэрэгжүүлэх явцад шүүхээс хуулиар тогтоосон хугацаанд тухайн маргааныг шийдвэрлэх боломжгүй, дампуурлын маргааныг шийдвэрлэхэд Дампуурлын хуулиас гадна шүүхийн тогтоосон хууль зүйн практик тухайн маргааныг шийдвэрлэх голлох эх сурвалж болжээ.

Түүнчлэн Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас үүдэн жижиг, дунд бизнес эрхлэгчдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, жижиг, дунд үйлдвэрийг дампуурах эрсдэлд хүргэсэн шалтгаан нөхцөлд дампуурлын маргааныг хянан шийдвэрлэх зохицуулалтыг хүртээмжтэй тодорхойлох дараах үндэслэлээр судлах шаардлага үүсэж байна.

Засгийн газрын хэрэгжүүлэх, агентлаг, Жижиг, дунд үйлдвэрлэлийн газраас 2020 онд хийсэн судалгаагаар цар тахал гарч хатуу хөл хорионы дэглэм тогтоосноор нийт судалгаанд оролцогсдын 98% нь үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна гэсэн байна. Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд ямар хүндрэлүүд гарч байгаа талаар асуухад 26 хувь нь зээлийн эргэн төлөлт хийх мөнгөгүй болсон, 24.7 хувь нь ажилчдын цалингийн эх үүсвэргүй, 22.6 хувь нь эргэлтийн хөрөнгөгүй болсон гэх зэрэг санхүүгийн хүндрэлүүд тулгарч байна гэж хариулсан байна. Үүсээд буй хүндрэлийг давахад хэдэн төгрөгийн нэмэлт санхүүжилт шаардлагатай эсэхэд 40.8 хувь нь 100.0 сая төгрөг хүртэл, 29.6 хувь 50.0 сая төгрөг хүртэл, 19.6 хувь 300.0 сая төгрөг хүртэл гэсэн байна. Мөн нэмэлт санхүүжилт авахад ямар бэрхшээл байгаа тулгарч буй талаарх асуултад 35 хувь нь зээлтэй учир зээл олгогдох боломжгүй гэсэн ба 22.9 нь барьцаа хөрөнгө хангалтгүй гэж¹¹ үзэж байсан байна.

¹⁰ Мөн тэнд.

¹¹ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Жижиг, дунд үйлдвэрийн газраас 2020 оны 11 дүгээр сарын 28-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 01-ний хооронд Улаанбаатар хот, орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн дунд коронавирусын цар тахал хэрхэн нөлөөлж буй талаарх судалгаа

Цар тахлын улмаас 2021 оны 2 дугаар улирлын байдлаар үйлчилгээний салбарт нийт 149,546 бүртгэлтэй ААН байсан ба тэдгээрийн 45.1хувь нь үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж 30.2 хувь нь үйл ажиллагаагаа эхлээгүй, 21.6 хувь нь үйл ажиллагаагаа түр зогсоосон, 2.1 хувь нь үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон байна. Харин үйлчилгээний салбарт бүртгэлтэй ААН-ийн тоо 7.6 хувиар буюу 42100 ААН-ээр нэмэгдсэн хэдий ч эдгээрээс үйл ажиллагаа явуулах нөхцөл боломж нь өмнөх үетэй харьцуулахад харьцангуй буурсан байжээ.¹²

Дээрх судалгаануудад тусгагдаж байсан жижиг, дунд бизнес эрхлэгчдийн тулгамдсан асуудал нь 2022 оноос хойш аж ахуйн нэгжийн дампуурал хэлбэрээр илэрч байна. 2022 оноос хойш нийт 31 дампуурлын хэрэг шийдэгдсэн байгаа нь Дампуурлын тухай хууль батлагдсанаас хойш буюу 1997 оноос хойш шийдвэрлэгдсэн нийт 134 хэргээс 23 хувь буюу өндөр хувийг эзэлж байна.¹³ Үүнээс гадна, 2022 оноос хойш шийдвэрлэгдсэн 31 дампуурлыг хэрэгт хариуцагч нь төлбөрийн чадваргүй болсон үндэслэлээр коронавирус цар тахалтай холбон тайлбарлаж буй тохиолдол 45 хувьд нь буюу 14 дампуурлын хэрэгт байна.

Дампуурлын хэрэг үүсгэсэн аж ахуйн нэгжүүдийн дунд дараах үндэслэлээр төлбөрийн чадваргүйдэлд хүрсэн үндэслэлээр тайлбарлаж байна.

- Ажилчдаа цомхотгон сул зогсолт хийсэн буюу шүүхийн шийдвэрээс үзвэл *“Дэлхий нийтэд учирсан аюулт цар тахал Ковид 19 өвчний улмаас давагдашгүй хүчин зүйл үүссэн тул 2020 оны 4 дүгээр сараас манай компанийн үйл ажиллагаа доголдон, ажилчдаа цомхотгож, 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хүртэл 2 жил 8 сар сул зогсолт хийсэн”*¹⁴
- Материалын үнэ өссөн буюу шүүхийн шийдвэрээс үзвэл *“цар тахал, үүнээс үүдэлтэй эдийн засгийн хямрал, хүнсний бүтээгдэхүүн, барилгын материалын үнийн огцом өсөлт зэргээс шалтгаалж компанийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн явуулах боломжгүй нөхцөл үүсэн бий болсон”*¹⁵
- Олон улсын худалдаа, тээвэр зогссон буюу шүүхийн шийдвэрээс үзвэл *“олон улсын худалдаа, тээвэр зуучийн зогсонги байдал, тээврийн хөлсний үнийн өсөлт зэргээс шалтгаалж компанийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн явуулах боломжгүй нөхцөл үүсэн бий болсон”*¹⁶
- Материалын хомсдолд орсон буюу шүүхийн шийдвэрээс үзвэл *“цар тахлын үед барилгын засвар хийлгэх үйл ажиллагаа бүрэн зогссон бөгөөд Монгол улсын хил хааснаас шалтгаалан барилгын материал хилээр орж ирэх боломжгүй болж, дотооддоо материалын бүрэн хомсдолд орсон.”*¹⁷
- Үйл ажиллагааг зогсоосон шийдвэр буюу шүүхийн шийдвэрээс үзвэл *“Нийслэлийн Засаг даргын 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн ***** дугаартай захирамж*

¹² Н.Ариунцэцэг нар “Цар тахал ба үйлчилгээний сектор” илтгэл, 2021

¹³ 2025.04.18 хүртэлх Shuukh.mn веб сайтад нийтлэгдсэн шүүхийн шийдвэрийн хүрээнд дүгнэв.

¹⁴ https://shuukh.mn/single_case/175244?daterange=1997-01-01%20-%202025-03-21&id=1&court_cat=1&bb=1

¹⁵ https://shuukh.mn/single_case/169731?daterange=1997-01-01%20-%202025-03-21&id=1&court_cat=1&bb=1

¹⁶ https://shuukh.mn/single_case/170041?daterange=1997-01-01%20-%202025-03-21&id=1&court_cat=1&bb=1

¹⁷ https://shuukh.mn/single_case/129207?daterange=2023-01-01%20-%202025-03-22&id=1&court_cat=1&bb=1

болон Улсын Онцгой комиссын шийдвэрээр улсын хэмжээнд үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг зогсоосон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл тус компанийн үйл ажиллагаа зогсох, төлбөрийн чадваргүй болох гол эрсдэл болсон байна”¹⁸

Орлого багассан буюу шүүхийн шийдвэрээс үзвэл “2020 оноос үүдэлтэй ковид цар тахлаас шалтгаалан хил гааль хаагдсаны улмаас бараа, бүтээгдэхүүний түүхий эдийн үнийн өсөлт, хомсдолоос шалтгаалан орлого эрс багассан. Компанийн үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагаа алдагдаж эхэлснээс хойш татварын өр төлбөр, зээлээ төлж чадахгүй болоод байна.”

Тийнхүү дээр дурдсан асуудлуудад үндэслэн Дампуурлын тухай хуулийн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааг хийж гүйцэтгэсэн болно.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-т заасны дагуу Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Энэ нь үнэлгээ хийх болсон шалтгаан (өмнө тодорхойлсон)-тай харилцан уялдаа, хамааралтайгаар хийгдэх ажиллагаа бөгөөд тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг илрүүлнэ. Үнэлгээний хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөц, цаг хугацаа, гарах зардлыг заавал харгалзан үзэж, зөвхөн тухайн хуулийн зорилго, үнэлгээний шалгуурт хамгийн ихээр нөлөөлж болохуйц хуулийн зохицуулалтыг сонгохыг зорьсон болно.

Дээр дурдагдсан үнэлгээ хийх шалтгаанд тулгуурлан 1997 онд батлагдсан Дампуурлын тухай хуулийн дараах агуулга бүхий зохицуулалтуудад хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийнэ.

Үнэлгээний хийх хүрээ

Нэг. Дампуурлын хэрэг үүсгэх ажиллагаанд хамаарах зохицуулалт

- Дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт/ нэхэмжлэл гаргах, хүсэлтийг хүлээн авч, хэрэг үүсгэх зохицуулалт
- Дампуурлын хэрэг үүсгэх хүсэлтийг хүлээн авахаас татгалзах үндэслэл
- Хариуцагчийг төлбөрийн чадваргүйд тооцох зохицуулалт
- Төлбөрийн чадваргүйд тооцсон шүүгчийн захирамжийн үр дагавар, гомдол гаргах үндэслэл

Хоёр. Хэрэг гүйцэтгэгчийн эрх зүйн байдал

¹⁸ https://shuukh.mn/single_case/130730?daterange=2023-01-01%20-%202025-03-22&id=1&court_cat=1&bb=1

- Дампуурлын тухай хууль дах хэрэг гүйцэтгэгчийн статус, чиг үүрэг, түүний хэрэгжилт
- Хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлт, түүний ач холбогдол

Гурав. Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа

- Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх зохицуулалт
- Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах субъект
- Дахин хөрөнгөжүүлэх хүсэлтэд тавигдах шаардлага
- Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт хүлээн авсан шүүхийн ажиллагаа

Дөрөв. Дампуурлын ажиллагаа дуусгавар болох үндэслэл

- Нэхэмжлэл, хүсэлтийг хангах, үндэслэл
- Нэхэмжлэл, хүсэлтийг хэрэгсэхгүй болгох үндэслэл

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход Аргачлалын 3.4-т заасан дараах шалгуур үзүүлэлтээс сонгоно. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Зардлын өсөлт, бууралт;
3. Зардал-үр өгөөжийн харьцаа;
4. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал;
5. Практикт нийцэж байгаа байдал;
6. Бусад үр дагавар (урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй үр дагавар);

Судалгааны баг нь Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд бодит нөхцөл байдалд нийцсэн, хэрэгжилтийг үнэлэхэд зохистой, оновчтой байдлаар хэмжигдэхүйц байдлыг удирдамж болгож, дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал;

Нэг. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Дампуурлын тухай хууль нь батлагдаж, хэрэгжиж эхэлсэн цагаас эхлэн хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно. Дампуурлын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “... Дампуурлын хэрэг үүсгэх, хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж тус хуулийн зорилтыг тодорхойлсон. Дампуурлын тухай хуулийн дараах зохицуулалтуудыг тухайн шалгуур үзүүлэлтийн түвшинд судална.

Хүснэгт 1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

Дампуурлын тухай хуулийн зохицуулалт	Сонгосон үндэслэл
4.1.Өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүйд тооцно. 5.1.Шүүх дараах үндэслэлээр дампуурлын хэрэг үүсгэнэ: 5.1.1.үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагч тал дампуурлын хэрэг үүсгэх тухай нэхэмжлэл гаргасан; 5.1.2.хариуцагч үүргээ биелүүлж чадахгүй болсныг өөрөө мэдэгдэж, дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргасан. 5.2.Нэхэмжлэл, хүсэлт нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж шүүгч үзвэл түүнийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор дампуурлын хэрэг үүсгэх тухай захирамж гаргана. 5.3.Дампуурлын хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор шүүх нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулж, 30 хоногийн дотор хариуцагчийг төлбөрийн чадвартай болох эсэхийг тогтооно. 8.1.Хариуцагчийг төлбөрийн чадваргүй болсонд тооцсон тухай нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн дотор шүүх нэхэмжлэгчдийн анхны хурлыг зохион байгуулна.	Дампуурлын хэрэг үүсгэх ажиллагаанд хамаарах зохицуулалтууд нь хуулийн зорилтдоо нийцэж буй эсэх судлах шаардлага үүсэж байна.
5.7.Шүүх дампуурлын хэрэг үүсгэхдээ хэрэг гүйцэтгэгчийг түр томилж болно. Түр хэрэг гүйцэтгэгч нь энэ хуулийн 12.1.1, 12.1.2, 12.1.3, 12.1.4, 12.1.5, 12.1.9-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. 11.1.Шүүх энэ хуулийн 8.2-т заасны дагуу нэхэмжлэгчдийн анхны хурлаас санал болгосон этгээдийг 5 хоногийн дотор хэрэг гүйцэтгэгчээр томилох эсэхийг шийдвэрлэнэ. 11.2.Хэрэг гүйцэтгэгч нь хариуцагчийн үйл ажиллагаанд хувийн санхүү, эдийн засгийн сонирхолгүй, хууль, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой хувь хүн, эсхүл хууль зүй, эдийн засаг, санхүүгийн чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх эрх, үүрэг бүхий хуулийн этгээд байна. 13 дугаар зүйл. Хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлт 13.1.Хэрэг гүйцэтгэгч нь шүүхээр батлагдсанаасаа хойш 20 хоногийн дотор хариуцагчийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, энэ	Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг журамласан байдал нь хуулийн зорилтдоо нийцэж буй эсэхийг судлах нь шаардлагатай.

тухайгаа шүүх, хариуцагч, нэхэмжлэгчид танилцуулна. Дүгнэлтэд дараах зүйлийг тусгана: 13.1.1.хариуцагчийн санхүү, эдийн засгийн тооцоо, түүний дүгнэлт; 13.1.2.хариуцагчийн төлбөрийн чадваргүй болсон шалтгаан, онцлог; 13.1.3.удирдлагын үйл ажиллагааны талаарх дүгнэлт; 13.1.4.нэхэмжлэгчдийн хэсэг болон нэхэмжлэл тус бүрийн дүн; 13.1.5.хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл дампуурсанд тооцож татан буулгах талаарх санал; 13.1.6.шаардлагатай гэж үзсэн бусад мэдээ, баримт. 13.2.Дүгнэлт гаргах явцад хэрэг гүйцэтгэгчийн хүсэлтээр шүүх шинжээч томилж болно. 13.3.Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө гаргах эрх бүхий этгээдүүдэд дүгнэлттэй танилцах боломжийг хэрэг гүйцэтгэгч хангана.	
23.1.Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлж, үйл ажиллагааг нь цаашид үргэлжлүүлэх нь татан буулгаснаас нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг илүү хэмжээгээр хангах боломжтой гэж үзвэл дараах этгээд хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх тухай хүсэлтийг түүнийг төлбөрийн чадваргүйд тооцсон өдрөөс хойш 60 хоногийн дотор шүүхэд гаргаж болно: 23.1.1.хариуцагч өөрөө; 23.1.2.хариуцагчаас нэхэмжилсэн нийт төлбөрийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг нэхэмжилж байгаа нэхэмжлэгчид; 23.1.3.хэрэг гүйцэтгэгч. 23.2.Дахин хөрөнгөжүүлэх хүсэлтэд хариуцагчийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх санхүү, удирдлагын болон бусад боломж, тэдгээрийн тооцоо, өөрчлөн байгуулагдсан аж ахуйн нэгжийн хэтийн төлөвийн талаар тусгана. 24.1.Энэ хуулийн 23.1-д заасан этгээд хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлттэй танилцсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дахин	Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа нь зорилтдоо нийцэж буй эсэхийг үнэлэх шаардлагатай байна.

хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг /цаашид "төлөвлөгөө" гэх/ шүүхэд гаргаж өгнө.

24.2.Төлөвлөгөөнд дараах үйл ажиллагааг тодорхой тусгана:

24.2.1.хариуцагчийг үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах эсэх, хэрэв оруулбал түүнд оруулах өөрчлөлт;

24.2.2.хариуцагчийн удирдлагад өөрчлөлт оруулах эсэх, түүнд ажиллах хүмүүсийн нэр, хаяг;

24.2.3.нэхэмжлэлийн шаардлагын оронд үнэт цаас гаргах эсэх;

24.2.4.хариуцагчийн гаргасан үнэт цаасны төлбөрийн хугацааг сунгах, түүний хүүгийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах эсэх, оруулбал ямар хэмжээнд;

24.2.5.шинээр хийх гэрээ, хэлцлийн тухай;

24.2.6.хариуцагчийн эд хөрөнгөөс худалдах бол түүний хэмжээ;

24.2.7.хариуцагчаас бусдад шилжүүлэх эд хөрөнгө;

24.2.8.хариуцагчид үлдэх эд хөрөнгө;

24.2.9.энэ хуулийн 35.4-т заасан нэхэмжлэгчдийн хэсэг;

24.2.10.энэ хуулийн 35.4-т заасан дараалал тус бүрээр нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга, хэлбэр, хэмжээ, хугацаа;

24.2.11.хариуцагчийг дампуурсанд тооцож татан буулгах, эсхүл дахин хөрөнгөжүүлснээр нэхэмжлэгчдэд хуваарилагдах төлбөрийн хэмжээний зөрүүг харьцуулсан тооцоо;

24.2.12.ажиллагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах буюу түүнд өөрчлөлт оруулах бол тэдгээрт хууль тогтоомжийн зохих актын дагуу тэтгэмж олгох, шинээр мэргэжил эзэмшүүлэх, мэргэшүүлэх арга хэмжээ;

24.2.13.төлөвлөгөөг биелүүлж дүгнэх хугацаа;

24.2.14.хэрэг гүйцэтгэгч болон холбогдох бусад этгээдэд олгох урамшуулал, ажлын хөлсний хэмжээ, түүнийг олгох журам;

24.2.15.хариуцагчийг төлбөрийн чадвартай болгох талаар энэ хуулийн дагуу явуулах бусад үйл ажиллагаа.

28.1.Нэхэмжлэгчдийн хурлаар төлөвлөгөөг хэлэлцсэнээс хойш 20 хоногийн дотор түүнийг батлах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

28.2.Шүүх дараах үндэслэлийн аль нэг нь байвал төлөвлөгөөг батална:

28.2.1.төлөвлөгөөг нэхэмжлэгчдийн 2-оос доошгүй хэсэг дэмжсэн бол;

28.2.2.нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч татан буугдсанаас илүү хангаж чадахаар байвал.

28.3.Нэхэмжлэгчдийн хурлаас хэд хэдэн төлөвлөгөөг зөвшөөрч дэмжсэн бол шүүх хариуцагчийн санал болгосон төлөвлөгөөг батална.

28.4.Шүүх хариуцагчийн санал болгосон төлөвлөгөөг энэ хуулийн 28.2-т заасан үндэслэлд тохирохгүй гэж үзвэл хамгийн тохиромжгүй нөхцөлд хамаарч байгаа нэхэмжлэгчдийн хэсгийн зөвшөөрсөн төлөвлөгөөг батална. Төлөвлөгөөний дагуу тухайн нэхэмжлэгчид түүний нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангахгүй хэмжээний хөрөнгө хуваарилагдахыг тохиромжгүй нөхцөлд хамаарагдах гэнэ.

28.5.Төлөвлөгөөг шүүх батлаагүй бол хариуцагчийг дампуурсанд тооцож татан буулгах тухай шийдвэр гаргана.

29.1.Төлөвлөгөөний биелэлтийг шүүхийн шийдвэрийн дагуу хэрэг гүйцэтгэгчийн хяналтын дор хариуцагч өөрөө, эсхүл хэрэг гүйцэтгэгч зохион байгуулж хангана.

29.2.Хариуцагч өөрөө дампуурлын хэрэг үүсгэх тухай хүсэлт гаргасан болон хариуцагчийн гаргаж өгсөн төлөвлөгөөг баталсан бол төлөвлөгөөний биелэлтийг хангах үүргийг шүүх хариуцагчид даалгаж болно. Энэ тохиолдолд хариуцагч хэрэг гүйцэтгэгчийн тогтоосон нөхцөл, хязгаарлалтын хүрээнд эд хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй.

29.3.Хэрэг гүйцэтгэгч буюу хариуцагч төлөвлөгөөг хэрэгжүүлж чадахгүй гэж хэрэг гүйцэтгэгч, хариуцагч,

нэхэмжлэгчдийн хурал /зөвлөл/-аас үзвэл түүнийг өөрчлөх хүсэлтийг шүүхэд гаргаж болно. 29.4.Хэрэг гүйцэтгэгч төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих талаар энэ хуулийн 12.1-д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй: 29.4.1.хариуцагчийн санхүүгийн байдал, орлого, зарлагын тайлан тэнцэлд сард нэг удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр шалгалт хийх; 29.4.2.төлөвлөгөөний биелэлтийн явцад төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт орох шаардлагатай болсон, хариуцагчийг уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй болсон гэж үзвэл нэхэмжлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах. 29.5.Хэрэв төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй болсон гэж үзвэл хариуцагч, хэрэг гүйцэтгэгч буюу нэхэмжлэгчдийн хурал /зөвлөл/ хариуцагчийг дампуурсанд тооцож татан буулгах тухай хүсэлтийг шүүхэд тавих эрхтэй. 29.6.Энэ хуулийн 29.5-д заасан хүсэлтийг шүүх үндэслэлтэй гэж үзвэл хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах тухай шийдвэр гаргана.	
33.1.Шүүх дараах үндэслэлээр хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргана: 33.1.1.энэ хуулийн 23.1-д заасан этгээд дахин хөрөнгөжүүлэх тухай хүсэлтийг шүүхэд ирүүлээгүй; 33.1.2.шүүх төлөвлөгөөг батлаагүй, эсхүл төлөвлөгөөг шүүхэд ирүүлээгүй; 33.1.3.төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй болсон. 33.2.Хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 хоногийн дотор шүүх энэ тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.	Дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагаа нь хуулийн зорилтод нийцэж буй эсэхийг үнэлэх шаардлагатай байна.

Хоёр. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4.5-д зааснаар практикт нийцэж буй байдал нь хууль тогтоомжийн зохицуулалтын хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг.

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд (1) Дампуурлын тухай хууль нь дампуурлын эрх зүйн харилцааг хангалттай зохицуулж чадаж байгаа эсэх, (2) хуулийн зохицуулалтыг тайлбарлан хэрэглэж бүрэн эрх бүхий этгээдээс нэг мөр хэрэглэж буй эсэх, (3) хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор нийгмийн харилцаанд гарч буй эерэг, сөрөг үр дагавруудыг тодорхойлно.

Дампуурлын тухай хуулиар зохицуулах шаардлагатай харилцааг зохицуулж чадаж буй эсэх, хуулийн заалт зүйл, заалт нэг мөр хэрэглэхэд ойлгомжтой эсэх, түүнийг нэгдмэл байдлаар хэрэглэх практикт тогтсон эсэхийг судлах нь чухал ач холбогдолтой.

Дампуурлын тухай хуулийн дараах зохицуулалтуудыг тухайн шалгуур үзүүлэлтийн түвшинд судална.

Хүснэгт 2. "Практикт нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

Дампуурлын тухай хуулийн зохицуулалт	Сонгосон үндэслэл
4.1.Өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүйд тооцно. 5.1.Шүүх дараах үндэслэлээр дампуурлын хэрэг үүсгэнэ: 5.1.1.үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагч тал дампуурлын хэрэг үүсгэх тухай нэхэмжлэл гаргасан; 5.1.2.хариуцагч үүргээ биелүүлж чадахгүй болсныг өөрөө мэдэгдэж, дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргасан. 5.2.Нэхэмжлэл, хүсэлт нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж шүүгч үзвэл түүнийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор дампуурлын хэрэг үүсгэх тухай захирамж гаргана. 5.3.Дампуурлын хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор шүүх нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулж, 30 хоногийн дотор хариуцагчийг төлбөрийн чадвартай болох эсэхийг тогтооно. 8.1.Хариуцагчийг төлбөрийн чадваргүй болсонд тооцсон тухай нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн	Дампуурлын хэрэг үүсгэх ажиллагаанд хамаарах зохицуулалтууд нь практикт гарч буй тохиолдлыг бүрэн зохицуулж чадаж буй эсэхийг үнэлэх шаардлагатай гэж үзэв.

дотор шүүх нэхэмжлэгчдийн анхны хурлыг зохион байгуулна.	
5.7.Шүүх дампуурлын хэрэг үүсгэхдээ хэрэг гүйцэтгэгчийг түр томилж болно. Түр хэрэг гүйцэтгэгч нь энэ хуулийн 12.1.1, 12.1.2, 12.1.3, 12.1.4, 12.1.5, 12.1.9-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. 11.1.Шүүх энэ хуулийн 8.2-т заасны дагуу нэхэмжлэгчдийн анхны хурлаас санал болгосон этгээдийг 5 хоногийн дотор хэрэг гүйцэтгэгчээр томилох эсэхийг шийдвэрлэнэ. 11.2.Хэрэг гүйцэтгэгч нь хариуцагчийн үйл ажиллагаанд хувийн санхүү, эдийн засгийн сонирхолгүй, хууль, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой хувь хүн, эсхүл хууль зүй, эдийн засаг, санхүүгийн чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх эрх, үүрэг бүхий хуулийн этгээд байна. 13 дугаар зүйл. Хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлт 13.1.Хэрэг гүйцэтгэгч нь шүүхээр батлагдсанаасаа хойш 20 хоногийн дотор хариуцагчийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, энэ тухайгаа шүүх, хариуцагч, нэхэмжлэгчид танилцуулна. Дүгнэлтэд дараах зүйлийг тусгана: 13.1.1.хариуцагчийн санхүү, эдийн засгийн тооцоо, түүний дүгнэлт; 13.1.2.хариуцагчийн төлбөрийн чадваргүй болсон шалтгаан, онцлог; 13.1.3.удирдлагын үйл ажиллагааны талаарх дүгнэлт; 13.1.4.нэхэмжлэгчдийн хэсэг болон нэхэмжлэл тус бүрийн дүн; 13.1.5.хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл дампуурсанд тооцож татан буулгах талаарх санал; 13.1.6.шаардлагатай гэж үзсэн бусад мэдээ, баримт. 13.2.Дүгнэлт гаргах явцад хэрэг гүйцэтгэгчийн хүсэлтээр шүүх шинжээч томилж болно.	Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг журамласан байдал нь дампуурлын маргааныг шүүхээр хянан хянан шийдвэрлэх процессын харилцааг хангалттай зохицуулж буй эсэхийг судлан шаардлагатай гэж үзэв.

13.3.Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө гаргах эрх бүхий этгээдүүдэд дүгнэлттэй танилцах боломжийг хэрэг гүйцэтгэгч хангана.	
23.1.Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлж, үйл ажиллагааг нь цаашид үргэлжлүүлэх нь татан буулгаснаас нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг илүү хэмжээгээр хангах боломжтой гэж үзвэл дараах этгээд хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх тухай хүсэлтийг түүнийг төлбөрийн чадваргүйд тооцсон өдрөөс хойш 60 хоногийн дотор шүүхэд гаргаж болно: 23.1.1.хариуцагч өөрөө; 23.1.2.хариуцагчаас нэхэмжилсэн нийт төлбөрийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг нэхэмжилж байгаа нэхэмжлэгчид; 23.1.3.хэрэг гүйцэтгэгч. 23.2.Дахин хөрөнгөжүүлэх хүсэлтэд хариуцагчийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх санхүү, удирдлагын болон бусад боломж, тэдгээрийн тооцоо, өөрчлөн байгуулагдсан аж ахуйн нэгжийн хэтийн төлөвийн талаар тусгана. 24.1.Энэ хуулийн 23.1-д заасан этгээд хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлттэй танилцсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг /цаашид "төлөвлөгөө" гэх/ шүүхэд гаргаж өгнө. 24.2.Төлөвлөгөөнд дараах үйл ажиллагааг тодорхой тусгана: 24.2.1.хариуцагчийг үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах эсэх, хэрэв оруулбал түүнд оруулах өөрчлөлт; 24.2.2.хариуцагчийн удирдлагад өөрчлөлт оруулах эсэх, түүнд ажиллах хүмүүсийн нэр, хаяг; 24.2.3.нэхэмжлэлийн шаардлагын оронд үнэт цаас гаргах эсэх;	Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны зохицуулалт практикт үүсэж буй тохиолдолд хэрэглэгдэх боломжтой, бодит нөхцөл байдалд үүсэж буй харилцааг зохицуулж чадаж буй эсэхийг судлан тогтоох шаардлагатай гэж үзэж сонгов.

24.2.4.хариуцагчийн гаргасан үнэт цаасны төлбөрийн хугацааг сунгах, түүний хүүгийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах эсэх, оруулбал ямар хэмжээнд;

24.2.5.шинээр хийх гэрээ, хэлцлийн тухай;

24.2.6.хариуцагчийн эд хөрөнгөөс худалдах бол түүний хэмжээ;

24.2.7.хариуцагчаас бусдад шилжүүлэх эд хөрөнгө;

24.2.8.хариуцагчид үлдэх эд хөрөнгө;

24.2.9.энэ хуулийн 35.4-т заасан нэхэмжлэгчдийн хэсэг;

24.2.10.энэ хуулийн 35.4-т заасан дараалал тус бүрээр нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга, хэлбэр, хэмжээ, хугацаа;

24.2.11.хариуцагчийг дампуурсанд тооцож татан буулгах, эсхүл дахин хөрөнгөжүүлснээр нэхэмжлэгчдэд хуваарилагдах төлбөрийн хэмжээний зөрүүг харьцуулсан тооцоо;

24.2.12.ажиллагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах буюу түүнд өөрчлөлт оруулах бол тэдгээрт хууль тогтоомжийн зохих актын дагуу тэтгэмж олгох, шинээр мэргэжил эзэмшүүлэх, мэргэшүүлэх арга хэмжээ;

24.2.13.төлөвлөгөөг биелүүлж дүгнэх хугацаа;

24.2.14.хэрэг гүйцэтгэгч болон холбогдох бусад этгээдэд олгох урамшуулал, ажлын хөлсний хэмжээ, түүнийг олгох журам;

24.2.15.хариуцагчийг төлбөрийн чадвартай болгох талаар энэ хуулийн дагуу явуулах бусад үйл ажиллагаа.

28.1.Нэхэмжлэгчдийн хурлаар төлөвлөгөөг хэлэлцсэнээс хойш 20 хоногийн дотор түүнийг батлах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

28.2.Шүүх дараахь үндэслэлийн аль нэг нь байвал төлөвлөгөөг батална:

28.2.1.төлөвлөгөөг нэхэмжлэгчдийн 2-оос доошгүй хэсэг дэмжсэн бол;

28.2.2.нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч татан буугдсанаас илүү хангаж чадахаар байвал.

28.3.Нэхэмжлэгчдийн хурлаас хэд хэдэн төлөвлөгөөг зөвшөөрч дэмжсэн бол шүүх хариуцагчийн санал болгосон төлөвлөгөөг батална.

28.4.Шүүх хариуцагчийн санал болгосон төлөвлөгөөг энэ хуулийн 28.2-т заасан үндэслэлд тохирохгүй гэж үзвэл хамгийн тохиромжгүй нөхцөлд хамаарч байгаа нэхэмжлэгчдийн хэсгийн зөвшөөрсөн төлөвлөгөөг батална. Төлөвлөгөөний дагуу тухайн нэхэмжлэгчид түүний нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангахгүй хэмжээний хөрөнгө хуваарилагдахыг тохиромжгүй нөхцөлд хамаарагдах гэнэ.

28.5.Төлөвлөгөөг шүүх батлаагүй бол хариуцагчийг дампуурсанд тооцож татан буулгах тухай шийдвэр гаргана.

29.1.Төлөвлөгөөний биелэлтийг шүүхийн шийдвэрийн дагуу хэрэг гүйцэтгэгчийн хяналтын дор хариуцагч өөрөө, эсхүл хэрэг гүйцэтгэгч зохион байгуулж хангана.

29.2.Хариуцагч өөрөө дампуурлын хэрэг үүсгэх тухай хүсэлт гаргасан болон хариуцагчийн гаргаж өгсөн төлөвлөгөөг баталсан бол төлөвлөгөөний биелэлтийг хангах үүргийг шүүх хариуцагчид даалгаж болно. Энэ тохиолдолд хариуцагч хэрэг гүйцэтгэгчийн тогтоосон нөхцөл, хязгаарлалтын хүрээнд эд хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй.

29.3.Хэрэг гүйцэтгэгч буюу хариуцагч төлөвлөгөөг хэрэгжүүлж чадахгүй гэж хэрэг гүйцэтгэгч, хариуцагч, нэхэмжлэгчдийн хурал /зөвлөл/-аас үзвэл түүнийг өөрчлөх хүсэлтийг шүүхэд гаргаж болно.

29.4.Хэрэг гүйцэтгэгч төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих талаар энэ хуулийн 12.1-д зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй: 29.4.1.хариуцагчийн санхүүгийн байдал, орлого, зарлагын тайлан тэнцэлд сард нэг удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр шалгалт хийх; 29.4.2.төлөвлөгөөний биелэлтийн явцад төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт орох шаардлагатай болсон, хариуцагчийг уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй болсон гэж үзвэл нэхэмжлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах. 29.5.Хэрэв төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй болсон гэж үзвэл хариуцагч, хэрэг гүйцэтгэгч буюу нэхэмжлэгчдийн хурал /зөвлөл/ хариуцагчийг дампуурсанд тооцож татан буулгах тухай хүсэлтийг шүүхэд тавих эрхтэй. 29.6.Энэ хуулийн 29.5-д заасан хүсэлтийг шүүх үндэслэлтэй гэж үзвэл хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах тухай шийдвэр гаргана.	
33.1.Шүүх дараах үндэслэлээр хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргана: 33.1.1.энэ хуулийн 23.1-д заасан этгээд дахин хөрөнгөжүүлэх тухай хүсэлтийг шүүхэд ирүүлээгүй; 33.1.2.шүүх төлөвлөгөөг батлаагүй, эсхүл төлөвлөгөөг шүүхэд ирүүлээгүй; 33.1.3.төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй болсон. 33.2.Хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 хоногийн дотор шүүх энэ тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.	Дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагааны зохицуулалтыг практикт нэгдмэл байдлаар ойлгож, хэрэглэж буй эсэхийг судлан тогтоох шаардлагатай гэж үзэв.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдийг сонгож, хэрэглэнэ. Үүнд:

- 1) **Байх ёстой болон одоо байгаа** - хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар (одоо байгаа нөхцөл байдал)-ыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно.
- 2) **Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших**- хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооно.
- 3) **Тохиолдол судлах** - хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийнэ.

Тухайлбал, судалгааны хийж гүйцэтгэхдээ Дампуурлын тухай хуулийн дээрх зүйл, заалтад хамаарах агуулга тус бүр дээр байх ёстой болон одоо байгаа, хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших зохицуулалтад дүн шинжилгээ хийж, тухайн хуулийн зохицуулалтыг тайлбарлан, шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүд дээх хуулийн хэрэглээг харьцуулан судалж, дампуурлын маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг бусад улс орнууд болон Дампуурлын тухай хуульд өгч буй олон улсын зөвлөмжид хэрхэн зохицуулсныг харьцуулан судална.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

“Шалгуур үзүүлэлтийг томъёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьдаг бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтад *“зорилгод хүрсэн түвшин ямар байна вэ?”*, *“практикт хэрхэн нийцэж байна вэ?”*, *“дампуурлын хэрэг маргааныг хянан шийдвэрлэх хуулийг нэгдмэл байдлаар тайлбарлан, хэрэглэж байгаа эсэх”* *“хуулийн зохицуулалт нь олон улсын чиг хандлагад нийцэж байгаа эсэх”* гэсэн асуултын хүрээнд гүйцэтгэсэн болно.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдөх байдал, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор тухайн сэдвээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл уншиж судлах, түүхчилсэн судалгаа хийх, харьцуулсан судалгаа хийх, судалгааны тайлан унших, харьцуулалт хийх, холбогдох байгууллагаас судалгааг гаргуулах, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх зэрэг аргыг ашиглана.

- Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;
- Холбогдох субъектээс судалгаа авах аргыг тус тус сонгосон болно.

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд Дампуурлын тухай хууль, холбогдох гарын авлага, эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, шүүхийн шийдвэр, гадаад орнуудын дампуурлын хууль тогтоомжийг цуглуулж үнэлгээ хийхэд ашиглав.

II. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Судлаачдын баг нь Дампуурлын тухай хуулийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны ажлын мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгаа, шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ хийх аргад тулгуурлан гүйцэтгэсэн.

Баримт бичгийн судалгаа: Дампуурлын эрх зүйд холбогдох хууль тогтоомж, журам, судлаач нарын эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэл, судалгааны тайланг ашигласан болно.

Судалгаанд дараах эх сурвалжийг ашиглаж байна. Үүнд:

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан (Legalinfo.mn)-аас дампуурлын эрх зүйд холбогдох хууль тогтоомж;
2. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан (Shuukh.mn)-ээс дампуурлын хэрэг маргааныг анхан, давж заалдах, хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүд;
3. УДШ, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн онолын тайлбар, 2014
4. Б.Оюунжаргал, Б.Баялагмаа, “Хариуцагч компанийг “дампуурсанд тооцох тухай хүсэлт”-ийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ”, ННФ Шүүхийн шийдвэрийн судалгаа, цуврал 17, 2024.
5. Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Аж ахуйн нэгжийн дампуурал ба дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа”,
6. Н.Баярмаа “Дампуурлын хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа: иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгагдах онцлог” өгүүлэл, <https://legalddata.mn/buteel/pdf?id=884>
7. Н.Баярмаа “Дампуурлын хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, онцлог: гадаадын зарим орны туршлагаас”, <https://legalddata.mn/buteel/pdf?id=368>
8. Н.Баярмаа “Дампуурлын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа” <https://legalddata.mn/buteel/pdf?id=324>
9. ОХУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль. https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39331/a7a4a813672c6255bd00b9323a768b1892c97cda/
10. 박승두 and 안청현. "기업회생제도에 관한 한국과 미국의 비교연구" 법학논총 35, no.3 (2018).
11. 이연갑. "기업회생절차에서 법원의 역할에 대한 입법론적 검토" 법학연구 28, no.1 (2017).
12. 이상영. "유럽 기업회생법제의 특색과 시사점" 비교사법 14, no.2 (2007).
13. <https://nli.gov.mn/pdf/aj-ahuin.pdf>
14. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Жижиг, дунд үйлдвэрийн газраас 2020 оны 11 дүгээр сарын 28-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 01-ний хооронд Улаанбаатар хот, орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн дунд коронавирусын цар тахал хэрхэн нөлөөлж буй талаарх судалгаа
15. Н.Ариунцэцэг нар “Цар тахал ба үйлчилгээний сектор” илтгэл, 2021

16. ХБНГУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 15-р зүйл. Insolvency Code (Insolvenzordnung – InsO) https://www.gesetze-im-internet.de/englisch_inso/englisch_inso.html#p0142
17. БНСУ-ын Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хууль. Korean Debtor rehabilitation and bankruptcy act. <https://www.law.go.kr/engLsSc.do?menuId=1&subMenuId=21&tabMenuId=117&query=회생#>
18. The Ordinance on Publication on the Internet in Insolvency Proceedings (Verordnung zu öffentlichen Bekanntmachungen in Insolvenzverfahren im Internet) of 12 February 2002 (Federal Law Gazette I, p. 677), as last amended by Article 2 of the Act of 13 April 2007 (Federal Law Gazette I, p. 509).
19. 이상영. "유럽 기업회생법제의 특색과 시사점" 비교사법 14, no.2 (2007), 381 면.
20. Шүүхийн шийдвэрийн жагсаалт

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангаас 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2025 оны 03 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл “Дампуурлын хуулиар” анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэргийн шийдвэрийг шүүж үзэх, нийт 11 дампуурлын хэргийн шийдвэрийн илэрц гарч ирсэн бөгөөд анхан шатны шүүхийн 11 шийдвэр, давж заалдах шатны шүүхээс гарсан 3 магадлал, хяналтын журмаар шийдвэрлэсэн 1 тогтоолыг судалж, хууль зүйн практикт судалсан болно.

№	Шүүх	Анхан шатны шийдвэр	Давахын магадлал	Хяналтын тогтоол
1.	Орхон аймаг дах сум дундын анхан шатны шүүх	https://shuukh.mn/single_case/169731?daterange=2023-01-01%20-%202025-03-22&id=1&court_cat=1&bb=1		
2.	Орхон аймаг дах сум дундын анхан шатны шүүх	https://shuukh.mn/single_case/170041?daterange=2023-01-01%20-%202025-03-22&id=1&court_cat=1&bb=1		
3.	СХДИХАШШ	https://shuukh.mn/single_case/166055?daterange=2023-01-01%20-%202025-03-22&id=1&court_cat=1&bb=1		
4.	БГДИХАШШ	https://shuukh.mn/single_case/146648?daterange=2023-01-01%20-%202025-03-22&id=1&court_cat=1&bb=1	https://shuukh.mn/single_case/146648?daterange=2023-01-01%20-%202025-03-22&id=1&court_cat=1&bb=1	https://shuukh.mn/single_case/10618?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1
5.	СБДИХАШШ	https://shuukh.mn/single_case/147884?daterange=2023-01-01%20-%202025-03-22&id=1&court_cat=1&bb=1		

		3-01-01%20-%202025-03-22&id=1&court_cat=1&bb=1		
6.	ХУДИХАШШ	https://shuukh.mn/single_case/130730?daterange=2023-01-01%20-%202025-03-22&id=1&court_cat=1&bb=1		
7.	СХДИХАШШ	https://shuukh.mn/single_case/129056?daterange=2023-01-01%20-%202025-03-22&id=1&court_cat=1&bb=1		
8.	БГДИХАШШ	https://shuukh.mn/single_case/129731?daterange=2023-01-01%20-%202025-03-22&id=1&court_cat=1&bb=1		
9.	БГДИХАШШ	https://shuukh.mn/single_case/129207?daterange=2023-01-01%20-%202025-03-22&id=1&court_cat=1&bb=1		
10.	Орхон аймаг дах сум дундын анхан шатны шүүх	https://shuukh.mn/single_case/151121?daterange=2023-01-01%20-%202025-03-22&id=1&court_cat=1&bb=1 буцаасны дараа шийдвэрлэсэн анхан шатны шүүх байхгүй	https://shuukh.mn/single_case/27824?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1 буцаасан дахин хянасны дараа гарсан магадлал https://shuukh.mn/single_case/29734?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1	
11.	ХУДИХАШШ	https://shuukh.mn/single_case/125931?daterange=2023-01-01%20-%202025-03-22&id=1&court_cat=1&bb=1	https://shuukh.mn/single_case/27292?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1	

III. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Нэг. Дампуурлын хэрэг үүсгэх ажиллагаанд хамаарах зохицуулалтад хийсэн үнэлгээ

- | |
|--|
| <ol style="list-style-type: none">1.1. Дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт/ нэхэмжлэл гаргах, хүсэлтийг хүлээн авч, хэрэг үүсгэх зохицуулалт1.2. Дампуурлын хэрэг үүсгэх хүсэлтийг хүлээн авахаас татгалзах үндэслэл1.3. Хариуцагчийг төлбөрийн чадваргүйд тооцох зохицуулалт1.4. Төлбөрийн чадваргүйд тооцсон шүүгчийн захирамжийн үр дагавар, гомдол гаргах үндэслэл |
|--|

Дампуурлын тухай хуулийн 1-р зүйл болон 2-р зүйлд хуулийн зорилтыг тусгасан байх бөгөөд үүнд (1) дампуурлын хэрэг үүсгэх, хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулах; (2) ингэхдээ хэргийг үүсгэх, хянан шийдвэрлэхтэй холбогдсон дампуурлын хуулиар зохицуулагдаагүй харилцааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу зохицуулах хэмээн хуульчилжээ. Үүнээс үүдэн, тус хуулиар дампуурлын хэрэг үүсгэх, хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай нийцүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нийцсэн байх шаардлага нь дампуурлын ажиллагаа дахь шүүхийн оролцоотой шууд хамааралтай. Тодруулбал, Дампуурлын тухай хуулийн 4-р зүйлийн 4.1-р хэсэгт зааснаар *өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүйд тооцдог*. Тус үндэслэлийн хүрээнд шүүхээс дампуурлын хэргийг хянан шийдвэрлэхтэй холбоотой харилцаанд дампуурсанд тооцож, татан буулгах хүсэлтийг дараах байдлаар зохицуулдаг:

1.1. Дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт/ нэхэмжлэл гаргах, хүсэлт хүлээн авч, хэрэг үүсгэх зохицуулалт

Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т зааснаар дараах үндэслэлээр дампуурлын хэргийг дараах үндэслэлээр үүсгэнэ:

- i. Үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагч тал дампуурлын хэрэг үүсгэх тухай нэхэмжлэл гаргасан;¹⁹
- ii. Хариуцагч үүргээ биелүүлж чадахгүй болсныг өөрөө мэдэгдэж, дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргасан.²⁰

¹⁹ Дампуурлын тухай хуулийн 5.1.1.

²⁰ Дампуурлын тухай хуулийн 5.1.2.

Дампуурлын тухай хуулийн 7.1-т зааснаар Хариуцагч нь дампуурлын хэрэг үүсгэх тухай хүсэлтийг гаргах тохиолдолд хүсэлт дараах зүйлсийг тусгаж, хавсгах шаардлагатай:

- Төлбөрийн чадваргүй болсон гэх үндэслэл;
- Дахин хөрөнгөжүүлэх, эсхүл дампуурсанд тооцож татан буулгах тухай санал;
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангагдсан байна;
- Сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан тэнцэл;
- Өмчлөлдөө байгаа, эсхүл итгэмжлэн өмчилсөн эд хөрөнгийн жагсаалт, тэдгээрийн үнэлгээний талаарх санал;
- Нэхэмжлэгчдийн нэр, хаяг, нэхэмжлэгч тус бүрийн авлага буюу гаргуулах төлбөрийн хэмжээ;
- Хариуцагчид төлбөртэй этгээдийн нэр, хаяг, төлбөрийн хэмжээ;
- Хоршооны хувьд гишүүд, нөхөрлөлийн тухайд бүрэн хариуцлагатай гишүүдийн нэр, хаягийг хавсаргана.⁴

Харин Харилцагч талаас гаргаж буй нэхэмжлэл дараах агуулгыг тусгасан байна:²¹

- Тухайн этгээдийг төлбөрийн чадваргүйд тооцуулах, төлбөрийн чадваргүй болсон гэж үзэх үндэслэл;
- Хариуцагчийн хүлээсэн үүрэг, төлбөрийн хэмжээ, үүрэг гүйцэтгэх хугацаа;
- Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл дампуурсанд тооцож татан буулгах тухай саналыг тус тус тусгаж, холбогдох нотлох баримтыг хавсарган.

Хуулийн хэрэглээнд нийтлэг байдлаар үүсэж буй асуудлууд.

1. Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлд шүүхэд харилцагчийн гаргасан хүсэлтийг “нэхэмжлэл”, компаниас гаргасан хүсэлтийг “хүсэлт” гэж томъёолсон. Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 155¹-р зүйлд зааснаар хуулийн этгээдийг дампуурсанд тооцох тухай хүсэлт гаргах, түүнийг хянан шийдвэрлэх нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны төрөл хамаарч байна.

Дээрх хоёр хуулийн ялгаатай нэр томъёо нь дараах төөрөгдлийг үүсгэх эрсдэлтэй:

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тодорхойлсон хэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хүсэлтэд Дампуурлын тухай хуулийн 5-р зүйлд заасан “нэхэмжлэл”, “хүсэлт” аль аль нь хамаарах бөгөөд “ижил” агуулгатай ойлголт гэж үзэж, төөрөгдөхүйц тайлбар бий болгох;
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд “Нэхэмжлэл”, эсхүл “Хүсэлт”-ийг хянан шийдвэрлэх ажиллагааг ялгаатай байдлаар тайлбарласан тул дампуурлын маргааныг шийдвэрлэхэд баримтлах журмыг хэрэглэж буй нэр томъёонд үндэслэн өөрчлөх, ялгаатай байдлаар хуулийг хэрэглэх эрсдэл үүсэж байна.

²¹ Дампуурлын тухай хуулийн 7.2.

Улмаар энэ нь Дампуурлын тухай хууль Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалттай уялдаагүй байгааг илтгэх тул зорилгодоо хүрээгүй гэж үнэлэх нэг үндэслэл болно.

2. Хуулийн этгээдийг дампууруулахтай холбоотой үйл ажиллагаа нь үндсэндээ төлбөрийн чадваргүйг эсэхээс хамааран дампуурах эсхүл дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны зохицуулалтыг хэрэглэх шаардлага үүснэ. Монгол Улсын Дампуурлын тухай хуулийн дагуу хуулийн этгээдийг (1) төлбөрийн чадваргүй болсонд тооцох, (2) төлбөрийн чадваргүй болсны улмаас дампуурлын ажиллагааг эхлүүлэх эсэхийг шүүх шийднэ. Энэ нь дараах үе шатаас бүрдэнэ:

- Дампуурлын хэрэг үүсгэх ажиллагаа нь үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагч болон үүргээ биелүүлж чадахгүй болсон компанийн гаргасан нэхэмжлэл, хүсэлт нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62-р зүйл болон Дампуурлын тухай хуулийн 7-р зүйлд заасан шаардлагыг хангаж байна гэж үзвэл шүүгч захирамжаар дампуурлын ажиллагааг эхлүүлэх тухай шийдвэрлэнэ.²²
- Үүний дараагаар, шүүгч хуулийн этгээдийг төлбөрийг чадваргүйд тооцох ажиллагаа явуулж, дампуурлын ажиллагааг эхлүүлнэ. Энэ нь төлбөрийн чадваргүй болохыг тогтоож, дампуурлын ажиллагааг эхлүүлэх шийдвэр гаргаснаас эсхүл тус шийдвэр хүчин төгөлдөр болсноор эхэлж, нэхэмжлэгчдийн анхны хурлыг товлосноор дуусгавар болно.²³
- Төгсгөлд нь татан буугдах эсхүл дампуурлын ажиллагааг дуусгавар болгох ажиллагаа явагдах бөгөөд тогтоосон хугацаанд гаргасан нэхэмжлэгчдийн шаардлагыг хариуцагчийн хөрөнгийг худалдан борлуулах замаар хуваарилах болон дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөгөөр эсхүл нэхэмжлэгчдийн хурлаар шийдвэрлэсний дагуу ажиллагааг түдгэлзүүлэх эсхүл дуусгавар болгож болно.²⁴

Дээрхээс үзвэл, шүүх нь Хариуцагчийг төлбөрийн чадваргүй болохыг богино хугацаанд тогтоож, дампуурлын ажиллагааг шууд эхлүүлж, дампуурлын ажиллагааг нэгдмэл байдлаар үргэлжлүүлэн гүйцэтгэж, дуусгавар болгох боловч хяналтын шатны шүүхүүдийн хяналтаар “төлбөрийн чадваргүй”-д тооцож, дампуурлын ажиллагааг эхлүүлсэн нь үндэслэлгүй болсноор дампууруулахтай холбоотой анхан шатны шүүх дээр хийгдсэн бүх ажиллагаа үр дүнгүй болох, хүсэлт гаргагч, нэхэмжлэгч нар, шүүгчийн үйл ажиллагаа удаашрах, нөхцөлийг үүсгэж байна.²⁵

А. ХБНГУ-д Дампуурлын ажиллагаа эхлүүлэх эрх бүхий этгээдийг дараах байдлаар зохицуулсан

²² Дампуурлын тухай хуулийн 5.2.

²³ Б.Оюунжаргал, Б.Баялагмаа, “Хариуцагч компанийг “дампуурсанд тооцох тухай хүсэлт”-ийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ”, ННФ Шүүхийн шийдвэрийн судалгаа, цуврал 17, 2024.

²⁴ Дампуурлын тухай хуулийн 18.1, 32, 33, 36-р зүйлүүд

²⁵ Б.Оюунжаргал, Б.Баялагмаа, “Хариуцагч компанийг “дампуурсанд тооцох тухай хүсэлт”-ийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ”, ННФ Шүүхийн шийдвэрийн судалгаа, цуврал 17, 2024.

ХБНГУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуульд хуулийн этгээд болон хуулийн этгээдийн эрхгүй этгээд төлбөрийн чадваргүй болох ажиллагааг нээх хүсэлт гаргах эрхтэйг зохицуулсан.²⁶ Ингэхдээ төлбөрийн чадваргүй болох хүсэлт гаргах эрх бүхий этгээдэд нэхэмжлэгчид, хариуцагчийн холбогдох этгээд (*удирдах байгууллагын гишүүд, ерөнхий үүссэн байгуулагч, татан буулгагчид гэх мэт*) багтана. Хэрэв тухайн аж ахуйн нэгжид удирдлага байхгүй бол хувьцаа эзэмшигчид, хяналтын зөвлөлийн гишүүд болон бусад эрх бүхий гишүүд хүсэлт гаргаж болно.²⁷ Хэрэв ажиллагаа эхлүүлэх эрх бүхий бүх гишүүд (төлөөлөн удирдах зөвлөл, ерөнхий түншүүд, хяналтын зөвлөлийн гишүүд гэх мэт) хүсэлт гаргаагүй бол төлбөрийн чадваргүй байдлын шүүх хэргийг хянан шийдвэрлэх үндэслэл хангалттай нотлогдсон тохиолдолд хүсэлтийг хүлээн авах боломжтой. Өөрөөр хэлбэл, хариуцагчийн удирдлага болон бусад холбогдох этгээдүүд бүгд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргаагүй буюу тодорхой гишүүд нь гаргасан тохиолдолд шүүх хангалттай нотлох баримт байгаа гэж үзвэл төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлж болно. Гэхдээ энэхүү ажиллагааг эхлүүлэхээс өмнө бусад холбогдох талуудтай (жишээлбэл, ТУЗ-ийн бусад гишүүд, ерөнхий түншүүд гэх мэт) зөвлөлдөх шаардлагатай. Хуулийн этгээдийн эрхгүй этгээдийн хуулийн этгээдэд үйлчлэх журам ижил үйлчилнэ.

Хариуцагчийн төлбөрийн чадваргүйдлийн хүсэлт гаргах үүргийг хуульд тухайлан тодорхойлдог онцлогтой. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх эрхтэй этгээд нь хуульд тодорхойлсон нөхцөл байдал үүссэн нөхцөлд ажиллагааг эхлүүлэх хүсэлтийг шүүхэд гаргах үүрэг байхаар зохицуулах чухал ач холбогдолтой. Монгол Улсын Дампуурлын тухай хуульд дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх үүрэг бүхий нөхцөлийг тодорхойлоогүй. Үүнээс улбаалан хариуцагч өр төлбөрөө барагдуулах тодорхой хөрөнгөтэй байх хугацаандаа буюу зээлдүүлэгчийн эрхийг хангах боломжтой үедээ төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэхгүй байх нь шударга ёсны зарчимд харш үйлдэл хийх нөхцөлийг үүсгэдэг. Иймд, хариуцагчийг тодорхой нөхцөлд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэхийг үүрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал, ХБНГУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 15-р зүйлийн 15а хэсэгт, хуулийн этгээд төлбөрийн чадваргүй болсон буюу хэт өртэй болсон тохиолдолд төлөөлөх эрх бүхий гишүүд, татан буулгагчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх хүсэлтийг цаг алдалгүй гаргах үүрэгтэйг зохицуулсан. Энэхүү хүсэлтийг төлбөрийн чадваргүй болсноос хойш гурван долоо хоногийн дараа, хэт өр үүссэнээс хойш зургаан долоо хоногийн дараа гаргах ёстой.²⁸ Ийнхүү хүсэлт гаргах үүргээ биелүүлээгүй эсхүл хүсэлтээ үнэн зөв гаргаагүй этгээдийг гурван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл торгох ялын шийтгэл оногдуулдаг байна.²⁹

В. БНСУ-д Дампуурлын ажиллагаа эхлүүлэх эрх бүхий этгээдийг дараах байдлаар зохицуулсан.

Тус улсын “*Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хууль*”-ийн 294-296 дугаар зүйлд дампуурлын хэрэг үүсгэж болох эрх бүхий этгээдийг болон хэрэг

²⁶ ХБНГУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 15-р зүйл. Insolvency Code (Insolvenzordnung – InsO) https://www.gesetze-im-internet.de/englisch_inso/englisch_inso.html#p0142

²⁷ Мөн тэнд.

²⁸ ХБНГУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 15.а.1.-р зүйл. Insolvency Code (Insolvenzordnung – InsO) https://www.gesetze-im-internet.de/englisch_inso/englisch_inso.html#p0142

²⁹ ХБНГУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 15а.(4).1-р зүйл. Insolvency Code (Insolvenzordnung – InsO) https://www.gesetze-im-internet.de/englisch_inso/englisch_inso.html#p0142

үүсгэх нөхцөлийг тодорхойлсон. Хуулийн 294-р зүйлд нэхэмжлэгч болон хариуцагчийн аль аль нь дампуурлын ажиллагааг эхлүүлэх хүсэлт гаргах эрхтэй гэж заасан. Ингэхдээ хүсэлт гаргагч нь хариуцагчийг төлбөрийн чадваргүй болоход хүргэсэн үйл явдлын талаар тайлбар өгөх үүрэгтэй. Мөн хуулийн 295-р зүйлд аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн дампуурлын өргөдөл гаргах эрхийг нарийвчлан тодорхойлсон. Энэ нь корпорацын захирал, хязгааргүй эсвэл хязгаарлагдмал нөхөрлөлийн ерөнхий түнш, хувьцаат эсвэл хязгаарлагдмал компанийн захирал тухайн аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс дампуурлын өргөдөл гаргах боломжийг олгодог. Хуулийн 295 болон 297 дугаар зүйлүүдэд дампуурлын хэрэг үүсгэх эрх бүхий этгээдийг дурдсан байна. Тухайлбал, мөн хуулийн 295-р зүйлд корпорац, ХХК болон нөхөрлөлийн хувьд холбогдох ерөнхий захирал, үүсгэн байгуулагч, партнер нь дампуурлын хэрэг үүсгэх хүсэлтийг гаргах эрхтэй. Цаашлаад, дампуурлын хэрэг үүсгэх хүсэлтийг аливаа “татан буулгагч” мөн гаргах эрхтэй (§295.2). Ингэхдээ, дампуурлын хэрэг үүсгэх шалтгаан буюу үндэслэл бий эсэхийг тайлбарлах шаардлага хэвээрээ байна.³⁰ Тус хуулийн 297-р зүйлд дампуурлын хэрэг үүсгэх эрх бүхий этгээд нь дээр дурдсан зүйл заалтыг хүрэн дэх этгээдүүдээр хязгаарлагдахгүй бөгөөд иргэний хуульд заасан холбогдох хуулийн этгээдийн төлөөлөх этгээдүүд байж болно хэмээн зохицуулжээ. Энэ нь дампуурлын хэрэг үүсгэх эрх бүхий этгээдийг тусгайлсан хуулийн хүрээгээр хязгаарлахгүй гэсэн зорилготой. Мөн “Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хуулийн” хуулийн 298-р зүйлд заасны дагуу компани татан буугдаж байгаа бөгөөд дампуурлын хэрэг үүсгэх тохиолдолд хариуцагчийн хөрөнгийг тараан байрлуулах ажиллагаа нь дуусаагүй байх ёстой.

БНСУ-ын “Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хууль”-д дампуурах ажиллагаа болон дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг ялган зохицуулсан байх бөгөөд аль аль ажиллагаанд хамаарах талуудын эрх үүрэг болон гарах үр дагавар ч ялгаатай байна.³¹ Тус хуульд (1) дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны явцад татан буулгах ажиллагааг хэрэгжүүлэгч нь дампуурлын ажиллагааг эхэлсэн эсэхээс үл хамааран дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлж болно хэмээн зохицуулжээ;³² (2) харин дампуурлын ажиллагаанд ийнхүү дампуурлын хэрэг үүсгэх этгээд нь хариуцагч эсхүл зээлдэгчийн аль аль нь байж болох боловч хэрэг үүсгэх үүргийн тусгайлан зохицуулаагүй байна.

Дүн шинжилгээ.

Монгол Улсын Дампуурлын тухай хуулиар дампуурсанд тооцож, татан буулгах тухай хүсэлтийг Хариуцагч, нэхэмжлэлийг Үүрэг гүйцэтгүүлэгч гаргах эрхийг зохицуулсан. Хуульд хоёр тусдаа нэр томъёо ашигласан нь “нэхэмжлэл”, “хүсэлт”-ийн аль хэлбэрээр шүүхэд мэдүүлснээсээ хамаарч дампуурлын маргааныг ердийн журмаар эсхүл онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх мэт зөрүүтэй ойлголтыг бий болгожээ.

Нөгөөтээгүүр, хуульд заасан төлбөрийн чадваргүй байдал бий болсноос хойш багадаа 3 жил, ихдээ 7-8 жилийн дараа шүүхэд хандах практик тогтсон байх бөгөөд энэ тохиолдолд аль хэдийнээ өр төлбөр нь хураагдсаны улмаас нэхэмжлэгчдийн хохирлыг барагдуулахгүй байх бодит нөхцөл үүсэж байна. Гэтэл бусад улс орнуудын хувьд,

³⁰ Хуулийн 296-р зүйлд захирал, ерөнхий түнш, татан буулгагчаас ямар нэгэн өргөдөл гаргаагүй тохиолдолд өргөдөлд аж ахуйн нэгжийг дампуурахад хүргэсэн баримтуудын тайлбарыг оруулах ёстой гэж заасан.

³¹ БНСУ-ын Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хууль. Korean Debtor rehabilitation and bankruptcy act. <https://www.law.go.kr/engLsSc.do?menuId=1&subMenuId=21&tabMenuId=117&query=회생#>

³² БНСУ-ын Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хуулийн 35-р зүйл.

Хариуцагч нь төлбөрийн чадваргүй болсон даруйдаа шүүхэд хандаж, дампуурлын маргааныг шийдвэрлүүлэх үүргийг тодорхойлж, нэхэмжлэгчдийн эрхийг хамгаалах механизмыг бүрдүүлсэн байгааг анхаарах шаардлагатай. Манай улсын хувьд Хариуцагчид ногдуулсан үүргийн зохицуулалт байхгүй учраас дампуурлын хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүн зорилгодоо хүрэхгүй байна.

1.2. Дампуурлын хэрэг үүсгэх хүсэлтийг хүлээн авахаас татгалзах үндэслэл

Монгол Улсын Дампуурлын тухай хуульд дампуурлын хүсэлтийг хүлээн авахаас татгалзах зохицуулалт байхгүй. Тиймээс шүүхээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1-т заасан татгалзах үндэслэл байгаа эсэхийг хянаж, үндэслэл байхгүй тохиолдолд хэрэг үүсгэдэг.

Хүсэлтийг хүлээн авахаас татгалзах зохицуулалт нь Дампуурлын тухай хууль тогтоомжид байх шаардлагатай заалт бөгөөд хуулийн зохицуулалтыг урвуулан ашиглахаас сэргийлэх зорилготой. Иймд, бусад орны жишээ дээр хэрхэн зохицуулсныг харгалзан үзэх нь зүйтэй.

А. ХБНГУ-ын зохицуулалт.

ХБНГУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуульд (Insolvenzordnung) дампуурлын ажиллагааг эхлүүлэхээс шүүх татгалзах боломжтой хэд хэдэн үндэслэлийг тусгажээ. Үүнд, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардлыг нөхөхөд хөрөнгө хүрэлцэхгүй байх;³⁸ дампуурлын ажиллагаа эхлүүлэх хүсэлт нь хуулийн шаардлагыг хангаагүй буюу үндэслэлгүй байх; урьдчилан шалгах хугацаанд хариуцагч нь бодитой төлбөрийн чадваргүй нь нотлогдоогүй зэрэг багтана. Тус хуульд заасан дампуурлын ажиллагаа эхлүүлэх хүсэлтийг шүүх хүлээн авахаас татгалзаж болох үндэслэлүүдийг дэлгэрүүлэн авч, үзвэл:

- *Дампуурлын ажиллагааны зардал нөхөхөд хөрөнгө хүрэлцэхгүй байх* - Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 26 дугаар зүйлд зааснаар, хэрэв хариуцагчийн хөрөнгө нь дампуурлын ажиллагаанд шаардагдах зардлыг нөхөхөд хүрэлцэхгүй, мөн энэ зардлыг урьдчилан санхүүжүүлэх гуравдагч этгээд байхгүй тохиолдолд шүүх дампуурлын ажиллагаа эхлүүлэхээс татгалзах эрхтэй.
- *Дампуурлын ажиллагаа эхлүүлэх өргөдөл нь хуулийн шаардлагад нийцсэн хэлбэр, агуулгатай байх* – өргөдлийг гаргаж буй этгээд нь хууль ёсны бүрэн эрх бүхий этгээд байх, өргөдөл нь төлбөрийн чадваргүй байдлын шалтгаануудыг нотолсон байх шаардлагатай. Хэрэв эдгээр шаардлагууд хангагдаагүй тохиолдолд шүүх өргөдлийг хэрэгсэхгүй болгох буюу дампуурлын ажиллагаа эхлүүлэхээс татгалзаж болно.
- *Шударга бус зорилго бүхий өргөдөл* – хуулийн дагуу дампуурлын ажиллагааг өрсөлдөгч байгууллагаа зах зээлээс шахах зорилгоор ашигласан; өр төлбөрөөс зугтаах, хуулийн цоорхойг ашиглахыг оролдсон; үнэн мэдээлэл зориуд нуусан зэрэг тохиолдол багтана. Эдгээр тохиолдолд шүүх өргөдлийг хэрэгсэхгүй болгох буюу ажиллагааг эхлүүлэхээс татгалздаг.

- *Хуулийн 270-р зүйлийн дагуу дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны явцад шүүх дампуурлын ажиллагааг эхлүүлэхээс түр хугацаагаар татгалзах буюу хойшлуулах боломжтойгоор зохицуулсан.*

В. БНСУ-ын зохицуулалт

Бүгд Найрамдах Солонгос Улсын дампуурлын эрх зүйн зохицуулалт нь хариуцагчийн санхүүгийн нөхцөл байдалд нийцүүлэн зөвхөн дампуурлын хэрэг үүсгэх бус, шаардлагатай тохиолдолд дахин хөрөнгөжүүлэх боломжийг ч авч үздэг онцлогтой. Тус улсын Дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хуулийн (Rehabilitation and Bankruptcy Act) 309 дүгээр зүйлд шүүхээс дампуурлын хэрэг үүсгэхээс татгалзах боломжтой нөхцөл, үндэслэлүүдийг нарийвчлан тусгасан. Тус хуулийн дагуу дампуурлын ажиллагаа эхлүүлэх хүсэлтийг шүүх хүлээн авахаас татгалзаж болох үндэслэлүүд дараах байдлаар зохицуулсан:

- *Дампуурлын ажиллагаанд шаардагдах зардлыг урьдчилан төлөөгүй тохиолдолд* – Хуулийн 309(1)-ийн дагуу дампуурлын ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах зардлыг хүсэлт гаргагч урьдчилан төлөөгүй бол шүүх уг хүсэлтийг хэрэгсэхгүй болгож болно.
- *Дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа хийгдэх эсэх талаар шүүхийн шийдвэр хүлээгдэж байгаа бөгөөд дахин хөрөнгөжүүлэх нь зээлдүүлэгчийн ашиг сонирхолд нийцэж байгаа тохиолдолд* – Энэ тохиолдолд шүүх хариуцагчийн дампуурал нь бизнесийн хувьд эргэж сэргэх боломжтой эсэхийг харгалзан үзэж, дампуурлын бус харин дахин зохион байгуулалтын замаар шийдвэрлэх боломжийг эрэмбэлдэг. Энэ нь зээлдүүлэгчдийн хохирлыг хамгийн бага байлгах механизмын нэгт тооцогдоно.
- *Дампуурал нь хариуцагчийн шууд буруугаас үүдэлтэй биш тохиолдолд* – тухайлбал, эдийн засгийн уналт, байгалийн гамшиг зэрэг этгээдийн хяналтаас гадуур хүчин зүйлс нөлөөлсөн бол шүүх дампуурлын хэрэг үүсгэхээс татгалзаж болох бөгөөд энэ нь шударга ёсны зарчимд нийцэж буй зохицуулалт гэж судлаачид үздэг.
- *Хүсэлт гаргагчийг тогтоох боломжгүй буюу хууль ёсны этгээд эсэх нь тодорхойгүй тохиолдолд* – Энэ нь хуулийн этгээдийн эрх зүйн тодорхой байдал, хүсэлт гаргах эрх зүйн чадамжийг хамгаалах, зүй бус хэрэгслээр дампуурлын ажиллагаа ашиглагдахаас сэргийлэх үүднээс заагдсан нөхцөл юм.
- *Дампуурлын ажиллагаа эхлүүлэх хүсэлт шударга бус зорилго агуулсан тохиолдолд* – Хуулийн 309(2)-т зааснаар, хэрэв дампуурлын ажиллагаа нь хариуцагчийн буруугаас үүдэлтэй боловч уг хүсэлт шударга бус буюу гутаан доромжлох, өр төлбөрөөс хууль бус аргаар зайлсхийх, эсвэл өрсөлдөгч байгууллагыг зах зээлээс шахах зэргээр хууль зүйн зорилготой нийцэхгүй шалтгаантай байвал шүүх үүнийг хүлээн зөвшөөрөхгүй байж болно. Энэ нь дампуурлын ажиллагааг хууль бус зорилгоор ашиглах эрсдэлээс сэргийлэх чухал механизм юм.

Мөн хэдий хариуцагчийн буруутай үйлдлээс үүдэн дампуурах шалтгаан бий болсон боловч дампуурах хүсэлт гаргаж буй нь шударга бус зорилго агуулж байна гэж үзэх тохиолдолд шүүгч дампуурлын хэрэг үүсгэхээс татгалзаж болно.

Дүн шинжилгээ.

Монгол Улсын Дампуурлын тухай хуулиар дампуурлын маргааныг хянан шийдвэрлэх онцлогтой уялдуулан хүсэлтийг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг тухайлан зааж өгөөгүй байгаа нь эргээд дампуурлын маргааныг хянан шийдвэрлэх зорилго биелэгдэхгүй үлдэх, дахин хөрөнгөжүүлэх боломжийг үгүйсгэх, хэрэг гүйцэтгэгчийн зардалтай холбоотой маргаан дахин шүүхийн журмаар шийдвэрлүүлэх, шударга бус зорилгоор дампуурлын ажиллагааг эхлүүлэх үйлдэл буурахгүй байх сөрөг үр дагаврыг үүсгэж байна.

Харин БНСУ, ХБНГУ зэрэг улс орнуудын хууль тогтоомжид дампуурлын ажиллагаа эхлүүлэхээс татгалзах үндэслэлийг тодорхой заасан байна. Тухайлбал, дампуурлын ажиллагаанд шаардагдах зардлыг төлөөгүй байх, хүсэлт хуулийн шаардлагыг хангаагүй байх, шударга бус зорилготой байх, дахин хөрөнгөжүүлэх боломжтой байхад дампуурал зарлах нь зээлдүүлэгчид болон эдийн засагт илүү хохиролтой байх зэргийг үндэслэн шүүх ажиллагааг эхлүүлэхээс татгалзах боломжтой байдаг.

1.3. Хариуцагчийг төлбөрийн чадваргүйд тооцох зохицуулалт

Монгол Улсын Дампуурлын тухай хуулийн 4.1-т заасны дагуу *“Өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүйд тооцно”* буюу төлбөрийн чадваргүйг тодорхойлох арга нь үүрэг, хөрөнгийн харьцаа болон төлбөр төлөөгүй хугацаа хоёроор тодорхойлогдсон байна.

Харин бусад орнууд харилцан адилгүй зохицуулсан байх бөгөөд дараах аргуудыг түгээмэл ашигладаг. Үүнд:

1. Cash flow insolvency буюу “бэлэн мөнгөний урсгал”-ын тест.

Энэхүү аргын дагуу хариуцагч төлбөрөө төлөхөө зогсоосон байх, үйл ажиллагаа хэвийн явуулахад шаардлагатай бэлэн мөнгөгүй болсон байхыг шаарддаг.³³ Бэлэн мөнгөний урсгалгүй болсныг илтгэх гол үзүүлэлт нь түрээсийн төлбөр, татвар, ажилчдын цалин зэрэг үйл ажиллагааны суурь зардлуудыг төлөх боломжгүй болсон нөхцөл байдлууд байна. Тус аргын хүрээнд хариуцагчийг төлбөрийн чадваргүй болсныг хялбархан нотлох боломжтой байх бөгөөд улмаар дампуурлын ажиллагааг түргэн шуурхай эхлүүлэх боломжтой болох юм. Дампуурлын ажиллагаа түргэн шуурхай эхлэх нь хариуцагчийн хөрөнгө устаж үгүй болохоос өмнө зээлдүүлэгч төлбөрөө гаргуулах, дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг түргэн шуурхай эхлүүлэх зэрэгт ач холбогдолтой. Гэвч энэхүү арга нь хариуцагчийн бэлэн мөнгөний түр зуурын хүндрэлд орсон тохиолдолд мөн ашиглагдах боломжтой тул шаардлагагүй үед процесс ажиллагаа эхлүүлэх эрсдэлтэй.

Манай орны зохицуулалтад “үүргээ биелүүлээгүй” хэмээн заасан боловч хэд хэдэн зүйлийг тодорхойлоогүй орхисон нь эргэлзээ төрүүлэхүйц байна. Тухайлбал, “өөрийн хөрөнгө”-ийн 10 хувиас доошгүй “үүрэг” гэдэгт юуг ойлгох буюу төлбөрийн үүрэгт зээлдэгчийн төлбөрөөр хязгаарлагдах эсхүл татвар болон бусад төлбөр орох эсэх багтана.

2. Balance sheet буюу “балансын тайлан”-гийн тест

³³ Н.Баярмаа, Дампуурлын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа. Legaldatal.mn

Балансын тайлангийн тест нь дэлхийн нийтэд түгээмэл ашиглагддаг арга бөгөөд хариуцагчийн өр төлбөр өөрийн хөрөнгийн хэмжээнээс хэтэрсэн байхыг хэлнэ. Хэрэв дахин хөрөнгөжүүлэх процессыг тусад нь авч үзэх бол, мөн дахин хөрөнгөжүүлэх процессын урьдчилсан нөхцөл нь “төлбөрийн чадваргүй” байдал бол дампуурлын ажиллагааны төлбөрийн чадваргүй байдалд тавигдах шаардлага дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны төлбөрийн чадваргүй байдлаас ялгаатай байх боломжтой. Үндсэндээ, энэ аргыг хэрэглэхэд өр төлбөр нь өөрийн хөрөнгөнөөс даваагүй байх үед дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх боломжтой байх явдал юм.

ХБНГУ-д 2021 оны “Бизнесийн тогтворжилт, бүтцийн өөрчлөлтийн тогтолцооны тухай хууль”³⁴ хэрэгждэг бөгөөд төлбөрийн чадваргүй болохоос урьдчилан сэргийлэх зорилготой. Аливаа этгээдийг төлбөрийн чадваргүй болохоос өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь угтаа дахин хөрөнгөжүүлэх, бүтцийн өөрчлөлт оруулах зэрэг үйл ажиллагаа байна. Энэхүү тогтолцоо нь ХБНГУ-ын “Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль”-д заасан төлбөрийн чадваргүйд тооцох үндэслэлд хүрээгүй хуулийн этгээд өөрийн хүсэлтээр дахин санхүүжүүлэх, бүтцийн өөрчлөлт хийх зэргийн төлөвлөгөө гаргах бөгөөд энэхүү төлөвлөгөөг шүүхээр баталгуулан хэрэгжилтийг хянана. Мөн “Бизнесийн тогтворжилт, бүтцийн өөрчлөлтийн тогтолцооны тухай хууль”-д тусгагдсан зохицуулалт нь төлбөрийн чадваргүйдэл болон дампуурлын ажиллагаанаас **тусдаа байна.**

Энэхүү шалгуурын хүрээнд хариуцагч өөрийн төлбөрийн чадваргүйдлийг зөвхөн өөрөө тодорхойлох боломжтой тул явцуу гэж үзэх нь бий. Цаашлаад, энэ нөхцөл байдалд зээлдүүлэгч нар дампуурлын ажиллагааг эхлүүлэх боломж нь хязгаарлагдмал болох юм. Цаашлаад, хариуцагч өөрийн тайлангийн хуудас зэргийг үйлдэх тул нэг талын, үнэ зөв бус, найдваргүй мэдээлэл байх эрсдэлтэй. Иймд, бүрдүүлбэр материал, нягтлан бодох бүртгэлийн тайланг шинжээч, мэргэжилтэн шалгах нь ажиллагаа нэмэгдэх тул процесс удаашрах боломжтой.

А. ХБНГУ-ын хуульд заасан үүрэг гүйцэтгэгчийн төлбөрийн чадваргүйг тодорхойлох аргууд

ХБНГУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 1-р бүлэгт дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх нөхцөл, журмыг тусгасан байна. Тус хуулийн 11-р зүйлд заасны дагуу *“Аливаа хувь хүн, хуулийн этгээд, тэр дундаа хуулийн этгээдийн эрхгүй нэгдлүүдийг төлбөрийн чадваргүйд тооцох ажиллагааг эхлүүлж болно. Төлбөрийн чадваргүй байдлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь ерөнхий нөхөрлөл, хязгаарлагдмал нөхөрлөл, мэргэжлийн нөхөрлөл, тээврийн компани болон бусад аж ахуйн нэгжийн хөрөнгө, түүнчлэн нас барсан хүний хөрөнгө, тодорхой нөхцөлийн дагуу гэр бүлийн өмчид хамаарах боломжтой. Хуулийн этгээд, компанийг татан буулгасны дараа ч эд хөрөнгө тараагдаагүй л бол төлбөрийн чадваргүй байдлын хэрэг үүсгэж болно.”* Мөн хуулийн 12-р зүйлд, нийтийн эрх зүйн этгээдүүдийн дампуурлын процесс эхлүүлэх

³⁴ German Act on the Stabilisation and Restructuring Framework for Businesses, 2021.

ажиллагааг зохицуулсан. Үүнд, Холбооны болон орон нутгийн өмчлөлийн эд хөрөнгө, нутгийн хяналтад байдаг нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хувьд, хэрэв хуулиар тэднийг төлбөрийн чадваргүй байдлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас чөлөөлсөн бол төлбөрийн чадваргүй байдлын хэрэг үүсгэх боломжгүй хэмээн заажээ.

Аливаа этгээдийг хөрөнгийн чадваргүйг тогтоох ажиллагааг эхлүүлэх журмыг ХБНГУ хууль дараах байдлаар зохицуулсан байна. Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 16-р зүйлд төлбөрийн чадваргүйдлийг тогтоох ажиллагааг эхлүүлэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нээх үндэслэлтэй байхыг шаардлагыг тусгажээ. Энэхүү заалтад тусгасан үндэслэлүүд нь төлбөрийн чадваргүйг тодорхойлох нөхцөлүүд юм. Ерөнхий дүрмийн дагуу өр төлбөр төлөх хугацаандаа үүргээ биелүүлэх боломжгүй бол төлбөрийн чадваргүйд тооцогдоно.³⁵ Төлбөрийн чадваргүйд тооцох үндэслэлд дараах нөхцөлүүд багтана:

1. Төлбөрийн чадваргүй байдал нь төлбөрийн чадваргүй байдлын хэрэг үүсгэх үндсэн шалтгаан юм. Энэ нь өр төлбөр төлөх хугацаандаа үүргээ биелүүлэх боломжгүй бол төлбөрийн чадваргүйд тооцогдох механизм бөгөөд ерөнхий дүрмийн дагуу хариуцагч төлбөрөө зогсоосон тохиолдолд төлбөрийн чадваргүй гэж үзнэ.³⁶
2. Төлбөрийн чадваргүй болох нь илт, тодорхой³⁷ байх нь хариуцагч хүсэлт гарган төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох ажиллагааг нээх шалтгаан болох бөгөөд өр төлбөрөө төлөх хугацаандаа төлж чадахгүй байх нь илт, тодорхой болсон тохиолд төлбөрийн чадваргүй болох эрсдэлтэй гэж үзнэ. Энэ нөхцөл байдлыг 24 сарын өмнөөс урьдчилан таамаглах боломжтойг хуульчилсан байна.³⁸
 - а. *Хэрэв зээлдэгч ойрын хугацаанд буюу 24 сарын дотор өр төлбөрөө төлөх боломжгүй болох эрсдэлтэй бол төлбөрийн чадваргүй нь тогтоох үндэслэл үүсэх тул төлбөрийн чадваргүй болох процессыг нээх хүсэлт гаргаж болно. Түүнчлэн, хүсэлтийг хариуцагч этгээдийг төлөөлөх эрх бүхий хүмүүс гаргаж болно.*
3. Хэт их өр³⁹ нь хуулийн этгээдийн төлбөрийн чадваргүй байдлын хэрэг үүсгэх үндэслэл болно. Хариуцагч нь өр төлбөрөө барагдуулах хөрөнгө нь хүрэлцэхгүй бол түүнийг хэт өртэй гэж үзнэ. Гэхдээ ойрын 12 сарын хугацаанд бизнесээ үргэлжлүүлэх магадлал өндөр байгаа бол хэт их өртэй гэж үзэхгүй байх боломжтой. Өөрөөр хэлбэл, өр төлбөр нь хөрөнгөөс давсан ч тодорхой хугацаанд буюу ХБНГУ-ын хуулийн заасанчлан 12 сарын дотор төлөх боломжтой гэж үзэхээр бол “хэт их өртэй” үндэслэлд багтахгүй байх боломжтой.⁴⁰
 - а. *Компанийн өр нь хөрөнгөөсөө давсан тохиолдолд хэт их өр үүсдэг бөгөөд энэ нь төлбөрийн чадваргүй болоход үндэслэл болно. Гэсэн хэдий ч тухайн компани ирэх 12 сарын хугацаанд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх магадлалтай бол хэт их өртэй гэж үзэхгүй байж болно.*

³⁵ ХБНГУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 17-р зүйл.

³⁶ ХБНГУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 17-р зүйл.

³⁷ ХБНГУ-ын хуульд “imminent insolvency” гэдэг нэр томъёо ашигласан байна. Европын Холбооны холбогдох удирдамжуудад “likelihood of insolvency” хэмээн орчуулсан байна. (Directive on preventive restructuring frameworks, on discharge of debt and disqualifications, and on measures to increase the efficiency of procedures concerning restructuring, insolvency and discharge of debt).

³⁸ ХБНГУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 18-р зүйл.

³⁹ ХБНГУ-ын хуульд “overindebtedness” хэмээн тодорхойлсон.

⁴⁰ ХБНГУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 19-р зүйл.

В. БНСУ-ын хуульд заасан хариуцагчийн төлбөрийн чадваргүйг тодорхойлох аргууд

Бүгд Найрамдах Солонгос Улсын Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хууль” (Rehabilitation and Bankruptcy Act)-аар төлбөрийн чадваргүй болсон этгээдэд хуулийн дагуу зохион байгуулалттайгаар дампуурлын ажиллагаа явуулах, эсвэл боломжит тохиолдолд бизнесийг нь сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой.

Тус хуулийн 305 дугаар зүйлд зааснаар, хариуцагч нь өөрийн төлбөрийг биелүүлэх чадваргүй болсон буюу төлбөрөө төлөхөө зогсоосон тохиолдолд дампуурлын ажиллагаа эхлүүлэх үндэслэл болно.⁴¹ Үүнийг “бэлэн мөнгөний урсгалын арга” (cash-flow test) буюу тухайн этгээд богино хугацаанд өр төлбөрөө барагдуулах чадваргүй байгаа эсэхэд тулгуурласан аргачлалаар тодорхойлдог. Харин 306 дугаар зүйлд хуулийн этгээдийн нийт өр төлбөр нь нийт хөрөнгийн хэмжээнээс давсан тохиолдолд төлбөрийн чадваргүйд тооцох зохицуулалт багтсан бөгөөд энэ нь “балансын арга” (balance-sheet test)-д суурилсан төлбөрийн чадварын үнэлгээ юм.⁴²

Иймээс Солонгосын дампуурлын эрх зүйн тогтолцоонд төлбөрийн чадваргүйдлийг тогтоохдоо дээрх хоёр шалгуурыг хослуулан ашигладаг бөгөөд энэ нь дампуурлын ажиллагааг эхлүүлэх үндэслэлийг илүү уян хатан, бодитой тогтооход чиглэсэн ач холбогдолтой. Энэхүү зохицуулалт нь зөвхөн хариуцагчийг зохих журмаар дампууралд оруулах төдийгүй, боломжтой тохиолдолд тухайн этгээдийн санхүүгийн байдлыг дахин зохион байгуулах, бизнесийг нь сэргээх боломжийг судлах суурь нөхцөлийг бүрдүүлдэг. Цаашилбал, шүүх байгууллага дампуурлын ажиллагааг эхлүүлэх эсэхийг шийдэхдээ зөвхөн эдийн засгийн үзүүлэлт төдийгүй, хариуцагчийн бизнесийн үр ашиг, нэхэмжлэгчдийн эрх ашиг, дахин хөрөнгөжүүлэх боломж зэрэг цогц хүчин зүйлсийг харгалзан үздэг нь дампуурлын ажиллагааг илүү прагматик, эдийн засгийн үр нөлөөтэй байдлаар хэрэгжүүлэх боломжийг олгодог.

С. Оросын Холбооны Улсын зохицуулалт

ОХУ-ын төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд хуулийн этгээдийг дампуурсанд тооцох үндсэн шинжийг тусгасан байх бөгөөд хуулийн этгээд нь мөнгөн төлбөрийн үүрэг, тэтгэмжийн болон (эсвэл) хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа буюу ажиллаж байсан хүмүүсийн цалин хөлсийг төлөх, (эсвэл) заавал төлөх төлбөрийг төлөх үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд эдгээр үүрэг, хариуцлагыг биелүүлэх ёстой өдрөөс хойш гурван сарын хугацаанд биелүүлээгүй бол дампуурсанд тооцох нөхцөл байдал үүснэ.⁴³ Цаашлаад, дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь үүргээ биелүүлэх

⁴¹ Бүгд Найрамдах Солонгос Улсын Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хуулийн 305-р зүйл. <https://www.law.go.kr/engLsSc.do?menuId=1&subMenuId=21&tabMenuId=117&query=회생#>

⁴² Бүгд Найрамдах Солонгос Улсын Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хуулийн 306-р зүйл. <https://www.law.go.kr/engLsSc.do?menuId=1&subMenuId=21&tabMenuId=117&query=회생#>

⁴³ ОХУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль. https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39331/a7a4a813672c6255bd00b9323a768b1892c97cda/

чадваргүй болсон хуулийн этгээдийн хувьд нийт үүргийн хэмжээ нь хамгийн багадаа хоёр сая рубль, харин хувиараа арилжаа эрхлэгчийн хувьд таван зуун мянган рубль байхаар зохицуулжээ.⁴⁴ Мөн дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэхдээ татварын эсхүл гаалийг байгууллага гаргасан шаардлагыг харгалзан үзнэ. Ийнхүү шаардлагыг харгалзан үзэх нь өрийг барагдуулах дараалалд ач холбогдол бүхий зохицуулалт юм.

ОХУ-ын төлбөрийн чадваргүйдлийн хуулийн дагуу хариуцагч дараах тохиолдлуудад дампуурлын ажиллагааг эхлүүлэх үүрэгтэй. Үүнд:

- Нэг эсхүл хэд хэдэн зээлдэгчийн үүргийн хангах нь бусад зээлдэгчийн үүргийг биелүүлэх боломжгүй байдалд хүргэх,
- Хуулийн этгээдийн дүрмийн дагуу хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэр гаргах эрх бүхий этгээд дампуурлын ажиллагааг эхлүүлэх тухай шийдвэр гарах,
- Нэгдмэл сонирхолтой аж ахуйн нэгжийн хувьд, эцсийн өмчлөгчийн шийдвэрээр томилогдсон эрх бүхий этгээд дампуурлын ажиллагааг эхлүүлэх тухай шийдвэр гарах,
- Хариуцагч төлбөрийн чадваргүй болох болон (эсхүл) хөрөнгийн хангалтгүй байдлыг илэрхийлэх шаардлагын хангах,
- Мөнгөн хөрөнгийн хүрэлцээгүй байдлын улмаас гурван сараас дээш хугацаанд төлөгдөөгүй тэтгэмж, цалин хөлс, ажилчин болон хуучин ажилчдад хамаарах бусад төлбөрийг хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан хэмжээгээр болон журмаар олгоогүй байх болон хуульд заасан бусад үндэслэлийг дурджээ.⁴⁵

Дүн шинжилгээ.

Монгол Улсын хувьд Дампуурлын тухай хуульд “өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ биелүүлээгүй” этгээдийг төлбөрийн чадваргүйд тооцно хэмээн заасан боловч энэ нь хангалттай тодорхойгүй, олон талаас тайлбарлагдах боломжтой байна.

Хуулийн этгээдийг дампууруулах ажиллагааг эхлүүлэхэд хариуцагчийг “төлбөрийн чадваргүй” гэж тооцох үндэслэл нь улс орон бүрийн хууль тогтоомжоор харилцан адилгүй зохицуулагддаг бөгөөд гол төлөв бэлэн мөнгөний урсгалын тест (cash-flow test) болон балансын тайлангийн тест (balance-sheet test) гэсэн хоёр үндсэн аргыг хэрэглэж байна.

ХБНГУ-ын хуульд төлбөрийн чадваргүйд тооцох нөхцөлийг олон талаас нарийвчлан заасан бөгөөд зөвхөн өр төлбөр нь хөрөнгөөс хэтэрсэн тохиолдлоор хязгаарлахгүй, ойрын ирээдүйд (12–24 сарын хугацаанд) үүргээ биелүүлж чадахгүй болох магадлалыг харгалздаг. Мөн урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгосон нь дампуурлаас зайлсхийх, бизнесийг аврах боломжийг нэмэгдүүлдэг.

БНСУ нь cash-flow ба balance-sheet аргыг хослуулан ашигладаг ба дампуурлын болон дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг ялган зохицуулсан нь уян хатан, бодит нөхцөлд нийцсэн шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлдэг. Эдгээр туршлагаас харвал, төлбөрийн чадваргүйд тооцох шалгуур нь зөвхөн өр төлбөрийн харьцаанд тулгуурлах бус, тухайн этгээдийн

⁴⁴ ОХУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 6-р зүйл, 213.3-р зүйл.

⁴⁵ ОХУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 9-р зүйл.

санхүүгийн байдал, бизнесийн ирээдүй, хөрөнгө дахин бий болгох боломж, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг хамтад нь харгалзан үзэх шаардлагатайг харуулж байна.

1.4. Төлбөрийн чадваргүйд тооцсон шүүгчийн захирамжийн үр дагавар, гомдол гаргах үндэслэл


Дампуурлын тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар тус хууль нь дампуурлын хэрэг үүсгэх, хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой. Тус хууль нь Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг бусад актаас бүрдэх бөгөөд энэ хуулиар зохицуулагдаагүй дампуурлын хэргийг үүсгэх, хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцаанд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтална.

Дампуурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүйд тооцно.

Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т зааснаар Дампуурлын хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор шүүх нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулж, 30 хоногийн дотор хариуцагчийг төлбөрийн чадвартай болох эсэхийг тогтооно. Шүүхээс тус хуулийн заалт болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлд заасныг үндэслэн “Төлбөрийн чадваргүй болсныг тогтоосон” захирамж гаргадаг. Хэрэв шүүхээс Дампуурлын хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т зааснаар хариуцагч төлбөрийн чадвартай болох нь тогтоогдвол дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгож, зохигчдын өр төлбөрийн асуудлыг зохих хуулийн дагуу хянан шийдвэрлэх журамтай.

Зураг 1. Шүүхээс хуулийн этгээдийг төлбөрийн чадваргүй болсныг тогтоосон захирамж гарсныг нийтэд зарласан байдал⁴⁶

⁴⁶ БГД, ХУД, СХД Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн фейсбүүк пэйж, www.facebook.com/photo.php?fbid=920098593481936&set=pb.100064454121431.-2207520000&type=3



Дээрх зургаас, Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д заасан хариуцагчийг төлбөрийн чадваргүй болсныг тогтоосноос хойш 7 хоногийн дотор шүүх энэ тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зохицуулалтыг хэрэгжүүлж буйг байдлыг харж болно.

Уг мэдээлэлд нэхэмжлэгчдийн анхны хурал хийх он, сар, өдөр, газар, нэхэмжлэгчдээс нэхэмжлэл гаргах журам, хугацаа, нэхэмжлэлийг хуульд заасан хугацаанд гаргаагүйгээр үүсэх үр дагавар зэргийг заана.

Дүн шинжилгээ

Анхан шатны шүүхэд дампуурлын хэрэг үүсгүүлэхээр гаргасан хүсэлт, нэхэмжлэлийг хүлээн авснаас 5 хоногийн дотор хэрэг үүсгэх эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамж гаргадаг. Нэхэмжлэлээр үүссэн дампуурлын хэргийн хувьд, хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор хариуцагчид нэхэмжлэлийг гардуулдаг.

Хүсэлтээр дампуурлын хэрэг үүсгэснээс хойш 30 хоног, эсхүл нэхэмжлэлээр дампуурлын хэрэг үүсгэж, хариуцагчид нэхэмжлэлийг гардуулснаас хойш 30 хоногийн дотор хариуцагчийг төлбөрийн чадвартай болох эсэхийг тогтоох зохицуулалтын хүрээнд анхан шатны шүүх нь дампуурлын хэрэг үүсгэсний дараа түр хэрэг гүйцэтгэгчийн томилж, түүний дүгнэлт болон хэрэгт цугларсан нотлох баримтад үндэслэн шууд “Төлбөрийн чадваргүйг тогтоосон” захирамж гаргаж, олон нийтэд мэдэгдэж, дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шууд эхлүүлж байгаа нь дараах сөрөг үр дагаврыг үүсгэж байна.

Төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох ажиллагааг анхан шатны шүүгч бие даан хариуцаж, богино хугацаанд, хялбар байдлаар төлбөрийн чадвартай эсэхийг тогтоон, захирамж гаргах бөгөөд тус захирамжийг дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дундын шүүгчийн захирамж гэж ойлгож, хэрэглэдэг практикт тогтсон.

Анхан шатны шүүгч “Төлбөрийн чадваргүйг тогтоосон” захирамж гаргаж, олон нийтийн сүлжээнд тухайн хуулийн этгээдийг төлбөрийн чадваргүй болохыг зарлаж, цаашлаад дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явагдаж дуусаад, анхан шатны шүүхээс

дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гарсан тохиолдолд тухайн шийдвэрт гомдол гаргах эрхийг хэрэгжүүлнэ.

Тийнхүү анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах болон хяналтын журмаар хянасны үндсэн дээр “Хариуцагч төлбөрийн чадваргүй болох нь тогтоогдохгүй байна.” гэсэн үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй, хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаах тохиолдол гардаг.⁴⁷ Улмаар давж заалдах болон хяналтын шатны шүүхээс гарсан шийдвэрийн агуулга нь анхан шатны шүүгчийн гаргасан “Төлбөрийн чадваргүйг тогтоосон” захирамжийн эсрэг буюу шүүгч нь хариуцагчийн төлбөрийн чадвартай эсэхийг буруу тогтоосон, цаашлаад олон нийтэд хариуцагч компанийг төлбөрийн чадваргүй болохыг зарласан нь үндэслэлгүй, буруу ташаа мэдээлэл болж үлдэж байна.

Тиймээс дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхан шатны шүүхээс “Төлбөрийн чадвартай эсэх”-ийг тогтоох ажиллагааг ойлгомжтой, тодорхой болгож, зохицуулалтын хувьд хэргийн оролцогчдын оролцуулахгүйгээр, шүүгч бие даан “хариуцагчийг төлбөрийн чадвартай эсэхийг тогтоож”, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дундын захирамж мэтээр гаргах нь оновчтой эсэхийг тодорхойлох шаардлага үүсэж байна.

Анхан шатны шүүхийн шүүгчийн “Төлбөрийн чадваргүйг тогтоосон” шүүгчийн захирамжид Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлд заасныг үндэслэн гомдол гаргах боломжгүй.

Харин Дампуурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т зааснаар оролцогч этгээдүүд дампуурлын хэргийг хянан шийдвэрлэхтэй холбогдуулан гарсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг эс зөвшөөрвөл түүнийг гарсан өдрөөс хойш 5 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй. Тус зохицуулалтын дагуу шүүхээс оролцогчдын гаргасан гомдлыг 15 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

Дүн шинжилгээ

Дампуурлын тухай хуулийн 6.1-т заасны дагуу оролцогчдоос гомдол гаргасан тохиолдолд тухайн гомдлыг шийдвэрлэх процесс тус хуулиар зохицуулагдаагүй.

Түүнчлэн, ирүүлсэн гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 171 дүгээр зүйлд заасан процессын дагуу шийдвэрлэж, шийдвэр гаргах эсэх нь ойлгомжгүй. Улмаар хэргийн оролцогчдоос “Төлбөрийн чадваргүйг тогтоосон шүүгчийн захирамж”-д гомдол гаргасан нөхцөлд, түүнийг хэрхэн хянаж, ямар агуулга бүхий шийдвэр гаргах нь зохицуулагдаагүй байгаа нь өөр өөр практик үүсгэх сөрөг нөлөөллийг бий болгожээ.

⁴⁷ Б.Оюунжаргал, Б.Баялагмаа “Хариуцагч компанийг дампуурсанд тооцох хүсэлт”-ийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ”, ННФ, Шүүхийн шийдвэрийн судалгаа, Цуврал 17, 2024, 12-84-р тал

А. ХБНГУ-ын зохицуулалт⁴⁸

Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх талаар ХБНГУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн хуулийн 2 дугаар бүлэгт зохицуулсан. Тус хуулийн 11 дугаар зүйлд зааснаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг хувь хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын хөрөнгийн байдалд үндэслэн эхлүүлж болно. Мөн хуулийн 13 дугаар зүйлд зааснаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг нэхэмжлэгч эсхүл хариуцагчийн бичгээр гаргасан хүсэлтийн үндсэн дээр эхлүүлнэ. Мөн зүйлд зааснаар Хариуцагч нь хүсэлт гаргахдаа нийт нэхэмжлэгчдийн нэрс, нэхэмжлэлийн шаардлагын жагсаалтыг хавсаргах үүрэгтэй. Тус зүйлд тодорхойлсноор хэрэв Хариуцагчийн бизнесийн үйл ажиллагаа үргэлжилж байгаа бол хүсэлтдээ дараах мэдээллийг тодорхой заана:

1. Хамгийн өндөр дүнтэй нэхэмжлэлийн шаардлага
2. Хамгийн өндөр дүнтэй үүргийн гүйцэтгэлийг хангах аргаар баталгаажсан нэхэмжлэлийн шаардлага
3. Татварын өр төлбөр
4. Нийгмийн даатгалын өр төлбөр
5. Ажиллагсдын тэтгэврийн даатгалын өр төлбөр

Хуулийн 16 дугаар зүйлд зааснаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэхийн тулд тухайн ажиллагааг эхлүүлэх үндэслэл зайлшгүй байх шаардлагатай. Тус хуулийн 17 дугаар зүйлийн дагуу Хариуцагчийн төлбөрийн чадваргүй байдал нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх нийтлэг үндэслэл болдог. Мөн 17 дугаар зүйлийн 17.2-т зааснаар хариуцагч нь төлбөрийн үүргээ хугацаанд биелүүлэх боломжгүй болсон бол төлбөрийн чадваргүйд тооцох бөгөөд төлбөрийн үүргээ биелүүлэхгүй, үүргийн биелэлтийг зогсоосон байдлыг төлбөрийн чадваргүй байдал гэж нийтлэг байдлаар тодорхойлдог. Төлбөрийн чадваргүй байдлыг тус хуулийн 18,19 дүгээр зүйлүүдэд дараах байдлаар тодорхойлсон: (1) Төлбөрийн үүргээ биелүүлж чадахгүй байдалд орсон (pending insolvency) буюу хариуцагч нь одоо төлбөрийн чадваргүй биш боловч 24 сарын хугацаанд гүйцэтгэвэл зохих төлбөрийн үүргээ биелүүлж чадахгүй бодит нөхцөл байдал үүссэнийг ойлгоно. Энэ тохиолдолд хариуцагч өөрөө төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх хүсэлт гаргаж болно. (2) Хэт өрийн байдал (overindebtedness) буюу хариуцагчийн хөрөнгө нь төлбөл зохих үүргийг бүрэн биелүүлж чадахгүй байгаа нөхцөл байдлыг ойлгоно. Гэхдээ хариуцагч нь тухайн нөхцөл байдалд өөрийн үйл ажиллагааг 12 сарын хугацаанд тогтвортой үргэлжлүүлэх өндөр магадлалтай бол хэт өрийн байдал гэж үзэхгүй.

Хуулийн 26 дугаар зүйлд Хариуцагчийн хөрөнгө хүрэлцэхгүйгээс шалтгаалж төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэхээс татгалзах журмыг тодорхойлсон. Мөн зүйлийн 26.1-т зааснаар хэрэв Хариуцагчийн хөрөнгө нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардлыг төлөхөд хүрэлцэхгүй гэж шүүхээс үзвэл, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх хүсэлтээс татгалзана. Гэхдээ зардлын урьдчилгааг байршуулсан эсхүл зардлыг хойшлуулах хүсэлтийг шийдвэрлэсэн бол татгалзахгүй. Хүсэлтээс татгалзсан шийдвэрийг яаралтай нийтэд зарлана. Шүүхээс хүсэлтээс татгалзсан тохиолдолд, ХБНГУ-ын Иргэний процессын кодексын 882b-д зааснаар өртэй этгээдийн бүртгэлд Хариуцагчийн

⁴⁸ The Insolvency Code of Germany (Insolvenzordnung – InsO), 5 October 1994 (Federal Law Gazette I, p. 2866), as last amended by Article 2 of the Act of 7 May 2021 (Federal Law Gazette I p. 850)

бүртгэх тухай захирамж гарна. Мөн зүйлийн 26.4-ь зааснаар хариуцагч нь Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль болон Компанийн тухай хуулиар хүлээн үүргээ зөрчиж, санаатайгаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх хүсэлт гаргаагүй бол зардлын урьдчилгааг төлөх үүрэгтэй.

Хуулийн 27 дугаар зүйлд зааснаар **Шүүхээс төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх захирамж гарснаар хэрэг гүйцэтгэгч томилогдоно**. Харин шүүхээс мөн хуулийн 270 дугаар зүйлийн дагуу тус шүүгчийн захирамжид Хариуцагч өөрөө хөрөнгийг удирдах эрхийн талаар зохицуулсан бол Хариуцагч нь Хянан зохицуулагчийн хяналтын дор хөрөнгийг удирдаж, худалдан борлуулах эрхийг эдэлнэ. Мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т зааснаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх тухай захирамжид дараах мэдээллийг тодорхой тусгана:

1. Хариуцагч нь хуулийн этгээд бол нэр, хувь хүн бол овог, нэр, төрсөн он сар, бүртгэгдсэн шүүх, арилжааны бүртгэлийн дугаар, үйл ажиллагааны чиглэл, хаяг
2. Хэрэг гүйцэтгэгчийн овог, нэр, хаяг
3. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхэлсэн цаг, заагаагүй бол захирамж гарсан өдрийн үд дүнд 12:00 цагт ажиллагааг эхэлсэн гэж үзнэ.
4. Хэрэг гүйцэтгэгчийг томилоогүй бол шалтгаан, үндэслэлийг дурдана.
5. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны талаар интернэт нийтлэх журмын⁴⁹ дагуу хувийн мэдээлэл устах хугацааг заана.

Тус хуулийн 30 дугаар зүйлд зааснаар **Шүүхийн тамгын газар нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх захирамжийг нийтэд мэдээлэх** бөгөөд захирамжийг Хариуцагчийн бүх нэхэмжлэгчид болон хариуцагчид гардуулна.

Тус хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэхээс татгалзсан захирамжид Хүсэлт гаргагч нь, мөн төлбөрийн чадваргүйдлийг ажиллагааг эхлүүлсэн захирамжид Хариуцагч нь тус тус **дээд шатны шүүхэд захирамжийг хянуулахаар шууд гомдол (Immediate Appeal) гаргах эрхтэй**. Хэрэв төлбөрийн ажиллагааг эхлүүлэх тухай захирамжийг хүчингүй болгох тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон нөхцөлд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгоно.

В. БНСУ-ын зохицуулалт

БНСУ-ын Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай⁵⁰ хуулийн зорилго нь санхүүгийн хүндрэлд орсон өртэй Хариуцагчийн үйл ажиллагааг үр ашигтайгаар сэргээх, мөн нэхэмжлэгч, хариуцагч, хувьцаа эзэмшигчийн болон бусад сонирхол бүхий этгээдийн хоорондын харилцааг зохицуулах замаар Хариуцагчийн төлбөрийн үүргийн асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагааг сэргээх боломжгүй тохиолдолд хөрөнгийг шударгаар хуваарилахтай холбоотой харилцааг зохицуулна.

⁴⁹ The Ordinance on Publication on the Internet in Insolvency Proceedings (Verordnung zu öffentlichen Bekanntmachungen in Insolvenzverfahren im Internet) of 12 February 2002 (Federal Law Gazette I, p. 677), as last amended by Article 2 of the Act of 13 April 2007 (Federal Law Gazette I, p. 509).

⁵⁰ The Debtor Rehabilitation and bankruptcy act of the Republic of Korea, [Enforcement Date 01. Mar, 2023.] [Act No.19102, 27. Dec, 2022., Partial Amendment] <https://www.law.go.kr/engLsSc.do?menuId=1&subMenuId=21&tabMenuId=117&query=%ED%9A%8C%EC%83%9D#>

Тус хуулийн онцлог нь дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа, дампуурлын ажиллагааг тус тусад нь бүлэг болгон хуульчилсан бөгөөд шүүхэд дахин хөнгөжүүлэх хүсэлт, хялбаршуулсан журмаар шийдвэрлэвэл зохих дахин хөрөнгөжүүлэх хүсэлт, дампууруулах хүсэлт, хувь хүний дахин хөрөнгөжүүлэх хүсэлтийг тус тус шүүхэд гаргаж, шийдвэрлүүлэх боломжтой⁵¹ учраас дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа дуусгавар болсны үндсэн дээр хариуцагчийг дампуурсанд тооцож болно.⁵² Хариуцагчийн шүүхэд гаргасан дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх хүсэлтийн дагуу дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг баталснаас хойш дахин хөрөнгөжүүлэх болон хялбаршуулсан журмаар дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг зогсоох шийдвэр гарч, хүчин төгөлдөр болсон, эсхүл дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон, эсхүл дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө батлагдахаас өмнө дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг зогсоосон, эсхүл дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг батлахаас татгалзсан тохиолдолд хариуцагчийн хүсэлтээр эсхүл өөрийн санаачилгаар шүүхээс Хариуцагчийг дампуурсанд тооцно.⁵³

Хуулийн 294 дүгээр зүйлд зааснаар **Нэхэмжлэгч эсхүл Хариуцагч нь дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт шүүхэд гаргах эрхтэй** бөгөөд нэхэмжлэгч нь хүсэлт гаргах тохиолдолд нэхэмжлэлийн үндэслэл болон хариуцагчийг дампуурсанд тооцох нөхцөл байдлыг тайлбарлах үүрэгтэй.

Хуулийн 305 дугаар зүйлд заасны дагуу Хариуцагч нь төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд шүүх хүсэлтийн дагуу эсхүл өөрийн санаачилгаар дампуурлыг зарлана. Мөн зүйлийн 305.2-т зааснаар Хариуцагчаас төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг зогсоосон байдал нь төлбөр хийх чадваргүй болсон гэж үзэх урьдач нөхцөлд тооцогдоно.

Хуулийн этгээдийн хувьд, тус хуулийн 306 дугаар зүйлд зааснаар хэрэв хуулийн этгээдийн төлбөрийн үүрэг нь нийт хөрөнгөөс хэтэрсэн нөхцөлд хуулийн этгээдийг дампуурсанд тооцох үндэслэл болно. Гэхдээ мөн зүйлийн 306.2-т зааснаар хязгаарлагдмал болон хязгааргүй хариуцлагатай түншлэлийн үйл ажиллагаа явуулж явуулж буй хугацаанд хамаарахгүй.

Хуулийн 310 дугаар зүйлд зааснаар Дампуурлыг зарласан шийдвэрт он, сар, өдөр, цагийг тусгах бөгөөд дампуурлыг зарласан үеэс эхэлж дампуурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.⁵⁴

Хуулийн 316 дугаар зүйлд зааснаар Дампуурлын хүсэлттэй холбогдох шийдвэрт гомдол гаргах эрхтэй бөгөөд гомдол нь тухайн шийдвэрийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй. Мөн зүйлийн 316.4-т зааснаас гомдлын ажиллагаа нь тус хуулийг зөрчсөн эсхүл гомдол үндэслэлгүй гэж шүүхээс үзсэн бол давж заалдах шатны шүүх тухайн гомдлыг хэрэгсэхгүй болгоно. **Харин гомдол нь үндэслэлтэй гэж үзвэл давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, анхан шатны шүүх рүү буцаана.**

Харьцуулсан дүн шинжилгээ

51 The Debtor Rehabilitation and bankruptcy act of the Republic of Korea, Article 3.

52 The Debtor Rehabilitation and bankruptcy act of the Republic of Korea, Article 6

53 Ibid.

54 The Debtor Rehabilitation and bankruptcy act of the Republic of Korea, Article 311

Монгол Улсын дампуурлын маргааныг хянан шийдвэрлэж буй онцлог нь анхан шатны шүүхээс “Хариуцагчийг төлбөрийн чадваргүйд тооцох тухай” захирамж гаргаж, үргэлжлүүлэн хэрэг гүйцэтгэгчийн томилж, дампуурлын хуульд заасан холбогдох ажиллагаанууд явагдсаны үр дүнд шүүхээс хариуцагчийг дампуурсан тооцож, татан буулгах шийдвэрийг эсхүл хүсэлтийг хангахаас татгалзсан шийдвэрийг гаргадаг. Гэтэл тус анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах болон хяналтын журмаар хянаад, анхан шатны шүүх рүү буцааж буй үндэслэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан “төлбөрийн чадваргүйд тооцсон тухай” захирамж үндэслэлгүй буюу хариуцагчийн төлбөрийн чадваргүй эсэх тогтоогдохгүй байна гэсэн үндэслэлээр маргааныг дахин хянан шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүх рүү буцааж байна. Давж заалдах, хяналтын шатны шүүхийн хяналт тавьж буй шийдвэр нь анхан шатны шүүхийн шийдвэрээс гадна явцын дунд гарсан төлбөрийн чадвартай эсэхийг тогтоосон захирамж болж байна. Гэтэл тус захирамжийг гарснаас хойш тус захирамжид гомдол гаргаагүйн зэрэгцээ уг захирамжийн хүрээнд анхан шүүхээс татан буугдах эсэхийг тогтоох хүртэл маш урт хугацаанд хэрэг гүйцэтгэгчээс холбогдох ажиллагааг гүйцэтгэсэн нь угтаа ямар ч үр дагаваргүй, үргүй их цаг зарцуулсан ажил болж үлдэж байна.

ХБНГУ, БНСУ-ын зохицуулалтаас үзвэл, аль аль нь “Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх”, “Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэхээс татгалзах”, эсхүл “Төлбөрийн чадваргүй гэж үзэж, дампуурлын ажиллагааг эхлүүлэх” шүүгчийн захирамжийг хянуулахаар дээд шатны шүүхэд гомдол гаргах зохицуулалтыг хуулиар баталгаажуулсан. Дампуурлын маргааныг хянан шийдвэрлэх явцад гарч буй шүүгчийн захирамжид тухай бүрд дээд шатны шүүхэд гомдол гаргаж, хянуулах механизм нь Дампуурлын тухай хуульд тодорхой тусгагдсан байгааг харгалзан үзэх нь одоогийн манай улсад үүсэж асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой.

Хоёр. Хэрэг гүйцэтгэгчийн статус, чиг үүрэг

2.1. Дампуурлын тухай хууль дахь хэрэг гүйцэтгэгчийн статус, чиг үүрэг, түүний хэрэгжилт

Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу шүүх дампуурлын хэрэг үүсгэхдээ хэрэг гүйцэтгэгчийг түр томилж болдог. Мөн тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д зааснаар нэхэмжлэгчдийн анхны хурлаас санал болгосны дагуу хэрэг гүйцэтгэгчийг томилдог. Дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны үед хэрэг гүйцэтгэгчийн хяналт дор хариуцагч өөрөө эсвэл хэрэг гүйцэтгэгч дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулдаг бол /ДтХ 29.1/, дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагаа эхэлсэн үед татан буулгах ажиллагааг хэрэг гүйцэтгэгч зохион байгуулдаг. Ийнхүү дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх аль ч үе шатан “хэрэг гүйцэтгэгч” гэх субъект чухал үүрэг оролцоотой байхаар хуульчилсан.

Гэвч дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүр нь өөр өөр зорилготой тул тухайн үе шатанд гүйцэтгэх хэрэг гүйцэтгэгчийн чиг үүрэг өөр юм. Жишээлбэл, Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасан хэрэг гүйцэтгэгчийн хувьд хариуцагч хуулийн этгээдийг төлбөрийн чадвартай эсэхийг шүүх тогтооход дүгнэлт гаргаж өгөх чиг үүрэгтэйгээр оролцох юм. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хэрэг

гүйцэтгэгч нь түр хэрэг гүйцэтгэгчийг бодвол илүү өргөн хүрээнд бүрэн эрх эдэлдэг бол татан буулгах ажиллагааны үед хэрэг гүйцэтгэгч нь хариуцагчийн аж ахуй удирдах болон эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг шилжүүлэн авдаг. Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа дахь хэрэг гүйцэтгэгчийн чиг үүрэг нь илүү өндөр бизнес, санхүү, эдийн засгийн ур чадварыг шаарддаг. Учир нь Дампуурлын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д зааснаар төлөвлөгөөг биелүүлж байгаа хариуцагч орлого, зарлагын болон санхүүгийн бусад тайлан, мэдээг сар бүр хэрэг гүйцэтгэгчид гаргаж өгдөг бөгөөд хэрэг гүйцэтгэгч хариуцагчийн санхүүгийн тайлан, мэдээг улирал тутам нэхэмжлэгчдийн хурал /зөвлөл/-д танилцуулж, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэгтэй байдаг.

Гэтэл ийнхүү өөрөөр чиг үүрэгтэйгээр өөр өөр үе шатанд хамаарах, өөр өөр ур чадвар шаардлагатай этгээдүүдийг Дампуурлын тухай хуульд “хэрэг гүйцэтгэгч” гэсэн нэг л нэршлээр зохицуулах нь хууль хэрэглээний төөрөгдөлд оруулж байна.

Шүүхийн практик

Түр хэрэг хэрэг гүйцэтгэгчээс нь 13 дугаар зүйлд заасан хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлт гаргахыг шүүх даалгасан тухай шүүхийн шийдвэр

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 102/2022/05573/И дугаар магадлал⁵⁵-ын ХЯНАВАЛ хэсгийн 4-т “...Дампуурлын тухай хуулийн 13 дугаар зүйлд хэрэг гүйцэтгэгч нь шүүхээр батлагдсанаасаа хойш 20 хоногийн дотор хариуцагчийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, энэ тухайгаа шүүх, хариуцагч, нэхэмжлэгчид танилцуулахаар зохицуулжээ.

Гэтэл анхан шатны шүүх 2022 оны 12 сарын 07-ны өдөр Г ХХК-ийг түр хэрэг гүйцэтгэгчээр томилж, Дампуурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасан дүгнэлтийг хийж, танилцуулахыг түүнд даалгаж шийдвэрлэсэн алдаа гаргажээ.

Өөрөөр хэлбэл, хэрэг гүйцэтгэгчийн гаргах дүгнэлтийг түр хэрэг гүйцэтгэгчээр гаргуулан, улмаар уг дүгнэлтийг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгосон нь буруу болжээ” гэж дүгнэн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин шийдвэрлүүлэхээр тухайн шүүхэд нь хэргийг буцаасан.

2.2. Хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлт, түүний ач холбогдол

Дампуурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д зааснаар хэрэг гүйцэтгэгч нь шүүхээр батлагдсанаасаа хойш 20 хоногийн дотор хариуцагчийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, энэ тухайгаа шүүх, хариуцагч, нэхэмжлэгчид танилцуулах үүрэгтэй. Ийнхүү хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлттэй танилцсан шүүх, хариуцагч, нэхэмжлэгчдийн хувьд дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дунд хэрэгжүүлж болох үйлдлийн үндэслэл болж өгдөгөөрөө өндөр ач холбогдолтой. Жишээлбэл, нэхэмжлэгчдийн хувьд хариуцагчийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар шүүхэд хандах, хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар шүүхэд гомдол гаргах, дахин хөрөнгөжүүлэх хүсэлт

⁵⁵ https://shuukh.mn/single_case/28220?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1

өгөх эсэх, дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө боловсруулах гэх мэт холбогдох хууль тогтоомжид заасан эрхээ⁵⁶ хэрэгжүүлэх үндэслэл болдог.

Үүнээс гадна шүүхийн хувьд нийтлэг байдлаар шүүхийн шийдвэрийнхээ үндэслэлд хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлтийг дурдаж байна. Иймд хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлтэд дараах чухал агуулгыг тусгахаар хуульчилсан.

- 1) хариуцагчийн санхүү, эдийн засгийн тооцоо, түүний дүгнэлт
- 2) хариуцагчийн төлбөрийн чадваргүй болсон шалтгаан, онцлог;
- 3) удирдлагын үйл ажиллагааны талаархи дүгнэлт;
- 4) нэхэмжлэгчдийн хэсэг болон нэхэмжлэл тус бүрийн дүн;
- 5) хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл дампуурсанд тооцож татан буулгах талаархи санал;
- 6) шаардлагатай гэж үзсэн бусад мэдээ, баримт.

Харин хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлтийг үнэн зөв байлгах зорилгоор дараах механизмыг хуульчилж өгсөн.

- 1) Хариуцагчаас хараат бусаар нэхэмжлэгчдийн эрх ашгийг төлөөлүүлэх зорилгоор нэхэмжлэгчдийн хурлаар сонгож, шүүхэд санал болгодог.
- 2) Нэхэмжлэгчдийн хурлаас санал болгосон этгээдийг автоматаар томилох бус, шүүх Дампуурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан этгээдийн мэргэжил, ур чадвар, ашиг сонирхлын шаардлагыг хангасан эсэхийг нягтлан шалгасны үндсэн дээр баталдаг.
- 3) Дүгнэлт гаргах явцад хэрэг гүйцэтгэгчийн хүсэлтээр шүүх шинжээч томилж болдог.
- 4) Нэхэмжлэгчдийн хурлаар дамжуулан хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагааны талаар гомдол гаргадаг.
- 5) Хуурч мэхлэх, хайхрамжгүй хандах зэрэг хууль бус үйл ажиллагааны улмаас хариуцагчид ямар нэгэн хохирол учруулбал хэрэг гүйцэтгэгч уг хохирлыг биечлэн хариуцдаг.

Гэвч хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлт зөрүүтэй эсвэл үндэслэлгүй байгаа үйл баримтыг дампуурлын хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх хуралдаанаараа тогтоож байна. Энэ нь нэг талаас хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагааны талаар хэргийн оролцогчдын гомдол гаргах эрх хангагдахгүй байх, нөгөө талаас энэ үндэслэлээр хэргийг анхан шатны журмаар дахин хэлэлцүүлэхээр буцаах байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах нөхцөл болж байна.

Мөн хэрэг гүйцэтгэгч Дампуурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т зааснаар шүүх, хариуцагч, нэхэмжлэгчид танилцуулсны үр дүн гарахгүй байна. Дампуурах хуулийн этгээд байсан ч дахин хөрөнгөжүүлэх хуулийн этгээд байсан ч хариуцагчийн хөрөнгийн үнэ цэнийг хамгаалах, нэхэмжлэгчдийн эрх, ашгийг хамгаалах түргэн шуурхай шийдвэрлэх нь нэн чухал юм.

⁵⁶ Зөвхөн Дампуурлын тухай хууль биш, Иргэний хууль, Компанийн хууль гэх мэт холбогдох бүх хууль тогтоомжийг ойлгоно.

Хэрэг гүйцэтгэгчийн үндэслэлгүй дүгнэлт хийсэн тухай шүүхийн шийдвэр

Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 102/ШШ2024/02743 дугаар шийдвэр⁵⁷ийн ҮНДЭСЛЭХ хэсгийн 4-т “...Хэрэг гүйцэтгэгч А.Э... компани нь төлбөрийн чадваргүй болж бусдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байдалд хүрсэн гэж дүгнэж байна. “Э д н” ХХК-ийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт ирүүлээгүй тул татан буулгах үндэслэл бий болсон гэж үзэж хариуцагчийг татан буулгах санал оруулж байна гэжээ.”

Гэвч шүүхийн зүгээс мөн 11-т “... компани 2017 онд 1,895,794,000 төгрөгийн ашигтай ажилласан атлаа татварын өр 319,878,600 төгрөгийг ямар шалтгаанаар төлөөгүй болох нь тодорхойгүй, компанийн үндсэн хөрөнгө болох тээврийн хэрэгслүүдийн өнөөгийн бодит үнийг тогтоогдоогүй, энэ талаар хэрэг гүйцэтгэгч үндэслэл бүхий дүгнэлт гаргаагүй байх ба тухайн орлогоос хуулиар хүлээсэн албан татвар ногдох татвараа төлөөгүй талаар хүндэтгэн үзэх үндэслэл тогтоогдохгүй байна...” гэсэн дүгнэлт хийж, дампуурсанд тооцож, татан буулгах тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон.

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 210/МА2024/01336 дугаар магадлал⁵⁸ ын ХЯНАВАЛ хэсгийн 4.1-т “...Үүнээс шалтгаалж хүсэлт гаргаагчийн төлбөрийн чадваргүй болсон шалтгаан нөхцөл тогтоогдохгүй, энэ талаарх хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлт үндэслэл бүхий болоогүй гэх анхан шатны шүүхийн дүгнэлтийг буруутгахгүй...” гэж дүгнээд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Улсын дээд шүүхийн 001/ХТ2024/00237 дугаар тогтоол⁵⁹ ын ХЯНАВАЛ хэсгийн 12-т “...төлбөрийн чадваргүй болох гол үндэслэл болж буй 2017-2019 оны хөрс хуулалтын ажилтай холбоотой байгуулсан санхүүгийн түрээсийн гэрээ, тус гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, хөрс хуулалтын ажлын гэрээ, гэрээ хэрэгжсэн үйл явц, тухайн гэрээ дүгнэгдсэн эсэх талаарх холбогдох баримтууд болон эдгээр гэрээ, гэрээтэй холбоотой ажлын гүйцэтгэл, холбогдох баримт хэрэгт авагдаагүй байна.

Хэрэг гүйцэтгэгч дээрх гэрээнүүдтэй холбоотой дүгнэлт хийгээгүй байхад шүүх тодруулаагүй, нөхцөл байдал тодорхойгүй байгаа нь Дампуурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагавар үүсэх боломжтой эсэхийг дүгнэх боломжгүй юм” гэж дүгнээд шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан.

А. ХБНГУ-ын хэрэг гүйцэтгэгчид холбогдох зохицуулалт

1. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт хүлээж авснаас хойших түр хэрэг гүйцэтгэгчийн статус, чиг үүрэг

⁵⁷ https://shuukh.mn/single_case/146648?daterange=1997-01-01%20-%202025-03-21&id=1&court_cat=1&bb=1

⁵⁸ https://shuukh.mn/single_case/31084?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1

⁵⁹ https://shuukh.mn/single_case/10618?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1

Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа (Insolvency proceeding) эхлэхээс өмнө ХБНГУ-ын хувьд түр хэрэг гүйцэтгэгч (Provisional Insolvency administrator)-ыг томилдог.⁶⁰ Өөрөөр хэлбэл, Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт хүлээн авсан шүүх нь уг хүсэлтийг шийдвэрлэх хүртэлх хугацаанд түр арга хэмжээ авах шийдвэрүүдийг гаргаж болох бөгөөд түүний нэг нь тус хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 56 дугаар зүйлээс 56b, 58 дугаар зүйлээс 66 болон 269a дугаар зүйл тус тус үйлчлэх түр хэрэг гүйцэтгэгчийг томилж болно.(section 21).

Түр хэрэг гүйцэтгэгч нь дараах үүрэгтэй:

- 1) Хэрэв шүүхээс хариуцагчийн хөрөнгийг захиран зарцуулахыг бүхэлд нь хориглосон шийдвэр гаргасан бол хариуцагчийн хөрөнгийг удирдах, шилжүүлэх эрх нь түр хэрэг гүйцэтгэгчид шилжинэ. Энэ тохиолдолд түр хэрэг гүйцэтгэгч нь дараах үүргүүдийг хүлээнэ:
 - a. хариуцагчийн эд хөрөнгийг битүүмжлэх, хадгалах арга хэмжээ авах;
 - b. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг шүүх эхлүүлэх эсэх шийдвэр гаргах хүртэл бизнесийн явуулж буй үйл ажиллагааг үргэлжлүүлэх. Харин хэрэв бизнесийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх нь хариуцагч этгээдийн хөрөнгөд ноцтой хохирол учруулах бол шүүхийн зөвшөөрлөөр тухайн үйл ажиллагааг зогсоох.
 - c. Хариуцагчийн хөрөнгө нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардлыг хангасан эсэхийг шалгах. Мөн шүүх нь түр хэрэг гүйцэтгэгчид мэргэжилтний хувиар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх үндэслэл байгаа эсэх болон хариуцагчийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломж байгаа эсэх асуудлыг үнэлэх үүрэг өгч болно.
- (2) Хэрэв шүүх хариуцагчийн хөрөнгө захиран зарцуулах эрхэд бүхэлд нь хориг тавиагүй тохиолдолд түр хэрэг гүйцэтгэгчийн эрх, үүргийн хүрээг тусгайлан тогтооно.
- (3) Түр хэрэг гүйцэтгэгч нь хариуцагчийн бизнесийн байранд нэвтрэх, шалгалт хийх эрхтэй. Мөн хариуцагч нь нягтлан бодох бүртгэлийн баримт, бизнесийн бичиг баримтыг түр хэрэг гүйцэтгэгчид нээлттэй үзүүлэх үүрэгтэй. Мөн шаардлагатай мэдээллийг өгөх, түүнчлэн түр хэрэг гүйцэтгэгчийн үүргээ биелүүлэхэд хамтран ажиллах үүрэгтэй.

Энэ хүрээнд хариуцагчийн мэдээллийн ил тод байдал болон хамтран ажиллах үүргийг ХБНУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 97 дугаар зүйлд дараах байдлаар уульчилсан:

- (1) Хариуцагч нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаатай холбоотой бүх нөхцөл байдлыг шүүх, хэрэг гүйцэтгэгч, зээлдэгчдийн хороо, мөн шүүхийн шийдвэрийн дагуу зээлдэгчдийн хуралд ил тод болгох үүрэгтэй.
- (2) Хэрэг гүйцэтгэгчийг үүргээ биелүүлэх үйл ажиллагаанд идэвхтэйгээр хамтран ажиллах үүрэгтэй.
- (3) Үргэлж бэлэн байх, мөн эдгээр үүргийн биелэлтийг сааруулж болзошгүй аливаа үйлдлээс зайлсхийх ёстой.

⁶⁰ Section 22 legal status of provisional insolvency administrator of Insolvency Code of Germany.

Ийнхүү Төлбөрийн чадваргүйдлийн хуулиар хүлээсэн хэрэг гүйцэтгэгчтэй хамтран ажиллах үүргээ хариуцагч зөрчсөн тохиолдолд шүүх дуудан ирүүлж, мэдүүлэг авсаны дараа цагдан хорих арга хэмжээ авах бүрэн эрхтэй байдаг(section 98).

2. Хариуцагчийн удирдлагын эрх

Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлэхээс өмнө тодорхой шаардлага хангасан(22a(1)) хариуцагчийн хүсэлтээр шүүх урьдчилсан уулзалт хийж болох бөгөөд энэхүү уулзалтаар төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой бусад асуудлыг хэлэлцэхээс гадна түр хэрэг гүйцэтгэгч болон хянан зохицуулагч(insolvency monitor) хэнийг томилох болон хариуцагч өөрөө удирдлагаа хадгалах(Debtor-in-possession management) нөхцөлийг хэлэлцдэг(Section 10a). Өөрөөр хэлбэл, Section 21-д зааснаар хэрэг гүйцэтгэгч томилогдсоноор хуулийн этгээдийн удирдлагын үйл ажиллагааг явуулах бүрэн эрх хэрэг гүйцэтгэгчид шилжих зохицуулалт байгаа боловч урьдчилсан шүүхийн уулзалтаар тодорхой нөхцөл тавих замаар хариуцагч нь удирдлагын үйл ажиллагааг явуулах бүрэн эрхээ хадгалсан хэвээр байх боломжтой юм. Энэ нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг мэддэг этгээд бизнесийн үйл ажиллагаа тасралтгүй явуулах давуу талтайгаас гадна түр хэрэг гүйцэтгэгчийн талаар санал оруулах боломжийг хариуцагчид олгож байна.

Хуулийн этгээд нь төлбөрийн чадваргүй эсвэл хэт төлбөрт орсон(overindebtedness)⁶¹ нөхцөлд түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд⁶² нь төлбөрийн чадваргүй болсон өдрөөс хойш 3 долоо хоногийн дотор, хэт төлбөрт орсон өдрөөс хойш хамгийн ихдээ 6 долоо хоногийн дотор төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргах үүрэгтэй(Section 15a) байдаг бөгөөд зарчмын хувьд хуулийн этгээдийн удирдлагууд нь төлбөрийн чадваргүйдэл эсвэл хэт төлбөрт орсон нөхцөл байдал бүрдсэн цагаас хойш хуулийн этгээдийн нэрийн өмнөөс ямарч төлбөр хийх ёсгүй(Section 15b). Энэ нь төлбөрийн чадваргүйдэл болон хэт төлбөрт орсон нөхцөл бүрдсэн үед хийгдэх төлбөр, хугацаа хэтэрсэн үүргийн зохицуулалт нь компанийн удирдлага, төлөөлөх этгээдүүд ямар төлбөр хийх эрхтэй, аль нь хориотой, хэрхэн хариуцлага хүлээх талаар нарийвчлан зааснаар компанийн удирдлага төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны үед хөрөнгө завших, хууль бусаар төлбөр хийхээс сэргийлэх, нэхэмжлэгч нарын тэгш эрхийг хангах чухал зохицуулалт юм.

Гэхдээ бүх төлбөрийг хориглох нь бизнесийн хэвийн үйл ажиллагааны тасалдал, ажилчдын цалин, түрээс, нийгмийн шимтгэл гэх мэт зайлшгүй зардлуудыг хийх боломжгүй болгодог. Мөн төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зорилго нь бизнесийн үйл ажиллагааг нь шууд хаах биш боломжтой тохиолдолд сэргээх, хамгаалахад оршдог. Иймд хүсэлт гаргасан үеэс төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлэх хүртэл хугацааны хооронд хийгдсэн хариуцагчийн төлбөрүүд нь түр хэрэг гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр хийгдсэн тохиолдолд хариуцлагатай бөгөөд чин шударга менежер(care of a prudent and conscientious manager)-ийн анхаарал болгоомжтой байх үүрэгт нийцсэн гэж үзэж дээрх төлбөрт хамааруулдаггүй(Section 15b(4) last sentence). Нөгөөтэйгөөр түр хэрэг гүйцэтгэгчээс

⁶¹ Төлбөр хийх үүргээ биелүүлэхэд өртэй этгээдийн хөрөнгө хангалтгүй болсон тохиолдолд хэт төлбөрт орсон байдал (overindebtedness)-д тооцно. Гэвч бүх нөхцөл байдлыг харгалзан үзвэл тухайн аж ахуйн нэгж ирэх 12 сарын хугацаанд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх магадлал өндөр байвал, энэ нь хэт төлбөрт орсон гэж үзэгдэхгүй(section 19).

⁶² Үүнээс гадна хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд хувьцаа эзэмшигч нар тус үүргийг хүлээдэг.

зөвшөөрөл авах нь мэргэжлийн түвшинд шалгаж, зөвшөөрөл олгож байгаа гэдэг утгаараа ямар төрлийн зардал, төлбөрийг төлж болох талаар үндэслэлтэй шийдвэр гарах боломжтой бөгөөд төлбөрийн хяналт, ил тод байдал хангагдах боломж бүрдэх юм.

Түүнээс гадна түр хэрэг гүйцэтгэгч болон түр хэрэг гүйцэтгэгчийн хяналт дор хариуцагчийн бий болгосон аливаа татвар нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа нээгдсэнээс хойших хуваарилагдах хөрөнгөөс гаргах өр төлбөрт тооцогдоно(Section 55). Дараагийн чухал чиг үүрэг бол хариуцагч төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөө гаргах тохиолдолд туслалцаа, зөвлөгөө өгөх үүрэгтэй(section 284).

3. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлснээс хойших хэрэг гүйцэтгэгчийн статус, чиг үүрэг

Шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлсэн тохиолдолд хэрэг гүйцэтгэгчийг заавал томилдог. Өөрөөр хэлбэл, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлсэн шүүхийн шийдвэрт хэрэг гүйцэтгэгчийн нэр, хаягийг заавал тусгахаар заасан байдаг(section 27).

Түр хэрэг гүйцэтгэгч болон хэрэг гүйцэтгэгчид ижил шаардлага тавигддаг(section 56):

- 1) Хувь хүн
- 2) Тухайн хэрэгт тохиромжтой, бизнесийн туршлагатай
- 3) Хариуцагч болон нэхэмжлэгчдээс хараат бус(нэхэмжлэгч эсвэл хариуцагч хэрэг гүйцэтгэгчийг санал болох нь хараат бус байдал алдагдсаныг илэрхийлэхгүй)

Дээрхээс гадна нэхэмжлэгчдийн түр хороо нь хэрэг гүйцэтгэгчийн талаар мэргэжлийн болон бусад хувийн шаардлагын санал гаргах боломжийг шүүх олгох ёстой байдаг. Мөн энэхүү түр хороо нь 100 хувийн саналаар хэрэг гүйцэтгэгчийг дэвшүүлсэн бол шүүх тухайн хэрэгт уг хэрэг гүйцэтгэгч тохирохгүй гэж үзэхээс бусад тохиолдолд томилох үүрэгтэй. Харин нэхэмжлэгчдийн анхны хурлаас санал болгох замаар өөр хэрэг гүйцэтгэгчийг шүүхэд баталгаажуулж өмнөх хэрэг гүйцэтгэгчийг сольж болдог(57).

4. Хэрэг гүйцэтгэгчийн эрх, үүрэг

Шүүхийн өмнө хүлээх үүрэг- Хэрэг гүйцэтгэгч нь шүүхийн хяналт дор байх бөгөөд шүүх нь хэдийд ч хэрэг гүйцэтгэгчээс тодорхой мэдээлэл өгөх эсвэл төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны явц болон удирдлагын талаар тайлан гаргахыг шаардаж болно. Хэрэв хэрэг гүйцэтгэгч энэхүү үүргээ биелүүлээгүй бол шүүх анхааруулга өгсний дараа түүнийг захиргааны торгуульд оногдуулах боломжтой. Энэхүү албадлагын торгууль нь 25,000 еврогоос хэтрэхгүй байна(section 50).

Хариуцагчийн хөрөнгө зарцуулах эрх шилжих- төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхэлмэгц хариуцагчийн хөрөнгө захиран зарцуулах эрх нь хэрэг гүйцэтгэгчид шилждэг(section 3a(3)).

Холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх- Хариуцагчийн хуваарилагдах эд хөрөнгөтэй холбоотой бөгөөд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлэх өдрийн байдлаар хариуцагч нь нэхэмжлэгчээр оролцож буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэг гүйцэтгэгч нь нэгдэн оролцох эрхтэй(section 85). Харин төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлсэн өдрийн байдлаар хариуцагч нь хариуцагчаар

оролцож буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэг гүйцэтгэгч нь нэгдэн оролцох эсвэл дараах тохиолдолд нэхэмжлэгч нь нэхэмжлэлээ үргэлжлүүлж болно:

- 1) Хуваарилагдах хөрөнгөөс тодорхой эд хөрөнгийг тусгаарлан гаргуулах нэхэмжлэл
- 2) Давуу байдлаар хангагдах нэхэмжлэлийн тусгай шаардлагатай
- 3) Хуваарилагдах хөрөнгөөр хангагдах шаардлагатай нэхэмжлэл

Үүнээс гадна хэрэг гүйцэтгэгч нь тухайн нэхэмжлэлийг нэн даруй хүлээн зөвшөөрсөн бол нэхэмжлэгч тал нь тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой үүссэн зардлыг төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны нэхэмжлэгч болохын хувьд шаардах эрхтэй(section 86).

Шуудангийн илгээмжтэй танилцах эрх- Хариуцагчийг нэхэмжлэгчдэд хохирол учруулах эрсдэлтэй бөгөөд үүнийг мөрдөн шалгах эсвэл урьдчилан сэргийлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шүүх хариуцагч руу ирэх бүх шуудангийн илгээмжийг хэрэг гүйцэтгэгч рүү шилжүүлэх захирамж гаргах боломжтой бөгөөд ийнхүү шилжин ирсэн бүх шуудангийн илгээмжийг хэрэг гүйцэтгэгч нь нээн үзэх эрхтэй(section 99).

Хөдөлмөрийн харилцааны талаар эдлэх эрх- Хөдөлмөрийн гэрээний хугацаа болон гэрээ цуцлах үндэслэлээс үл хамааран хэрэг гүйцэтгэгч болон ажилтан нь хөдөлмөрийн гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй бөгөөд хэрэг гүйцэтгэгч хөдөлмөрийн гэрээг цуцалсан тохиолдолд ажилтан нь хугацаанаас нь өмнө цуцлагдсантай холбоотой нөхөн төлбөрийг төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны нэхэмжлэгчийн хувиар нэхэмжлэх эрхтэй(section 113).

Гэрээ, хэлцэл хүчингүй болгох эрх- Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлэхээс өмнө хийгдсэн, нэхэмжлэгчдийн ашиг сонирхолд харшилсан гэрээ, хэлцлийг хэрэг гүйцэтгэгч нь тус хуульд заасны дагуу хүчингүй болгож болно(section 129).

Хөрөнгийн талаар эдлэх эрх, үүрэг- төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа нээгдсэний дараа, хэрэг гүйцэтгэгч нь хуваарилагдах хөрөнгийн бүрэлдэхүүнд багтах бүх эд хөрөнгийг яаралтай хүлээн авч, захиран зарцуулах үүрэгтэй(section 148). Мөн хариуцагч нь Арилжааны хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу үйл ажиллагааныхаа нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, татварын тайлан өгөх үүргээс чөлөөлөгдөхгүй бөгөөд хэрэг гүйцэтгэгч нь тухайн хариуцагчийн хуваарилагдах хөрөнгийн хүрээнд (жишээлбэл, үл хөдлөх, тоног төхөөрөмж, мөнгө, өр авлага гэх мэт) нягтлан бодох, татварын тайлангийн үүргийг өөрөө хариуцаж биелүүлэх ёстой(section 155).

Хариуцагчийг үнэлэх үүрэг- хариуцагчийн үйл ажиллагааг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн үргэлжлүүлэх боломжийг үнэлж, төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөө боловсруулах боломж байгаа эсэхийг тодорхойлж, тус бүрийн хувилбар нь нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг хангахад хэрхэн нөлөөлөх талаар тайлбарлах үүрэгтэй(section 156).

Нэхэмжлэгчдийн өмнө хүлээх эрх, үүрэг- нэхэмжлэгч бүр төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаатай холбогдох шүүхийн шийдвэр, нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой бүх баримт материал болон шүүхэд ирүүлсэн бүх тайлангуудтай цаасан болон цахим хэлбэрээр танилцах боломжоор хангах үүрэгтэй(section 5). Нөгөөтэйгөөр нэхэмжлэгчдийн хорооны гишүүд нь хэрэг гүйцэтгэгчийн үүргийн биелэлтийг дэмжих болон хянах үүрэгтэй. Мөн

бизнесийн явцын талаарх мэдээллийг шаардаж, санхүүгийн баримт, бүртгэлийг үзэх, мөнгөн гүйлгээ болон бэлэн мөнгөний үлдэгдлийг шалгах эрхтэй(section 69).

Үүнээс гадна хэрэг гүйцэтгэгч нь нэхэмжлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах эрхтэй(section 75) бөгөөд нэхэмжлэгчдийн хурлын шийдвэр нэхэмжлэгчдийн нийтлэг ашиг сонирхолд харш байгаа тохиолдолд хэрэг гүйцэтгэгчийн хүсэлтээр шүүх тухайн тогтоолыг хүчингүй болгодог(section 78). Үүнээс гадна хэрэг гүйцэтгэгч нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаанд онцгой ач холбогдол бүхий буюу дараах асуудлаар гэрээ, хэлцэл байгуулах тохиолдолд нэхэмжлэгчдийн хороо(байгуулагдаагүй тохиолдолд нэхэмжлэгчдийн хурал)-оос зөвшөөрөл авах үүрэгтэй(section 160):

- 1) Аж ахуйн нэгж, салбар, бүх бараа нөөц, тодорхой үл хөдлөх хөрөнгийг шууд борлуулах эсвэл хариуцагчийн хувьцааг зарах, эсвэл давтамжтай орлого олох эрхийг шилжүүлэх гүйлгээ хийх
- 2) Хуваарилагдах хөрөнгөнд их хэмжээний дарамт үүсгэхүйц зээлийн гэрээ байгуулах
- 3) Өндөр үнийн дүн бүхий шүүхийн нэхэмжлэл гаргах, оролцох, татгалзах, эсвэл нэхэмжлэлийг өөрчлөх, хэлэлцэх, эвлэрэх

5. Хэрэг гүйцэтгэгчийг чөлөөлөх:

Хэрэг гүйцэтгэгчийг чөлөөлөх асуудлыг шүүх өөрийн санаачилгаар эсвэл дараах этгээдүүдийн хүсэлтийг дагуу шийдвэрлэж болно:

- 1) Хэрэг гүйцэтгэгч өөрөө,
- 2) Хариуцагч
- 3) Нэхэмжлэгчдийн түр хороо,
- 4) Нэхэмжлэгчдийн хурал
- 5) аль нэг нэхэмжлэгч.

6. Хэрэг гүйцэтгэгчийн хариуцлага:

Хэрэв хэрэг гүйцэтгэгч нь энэ хуульд заасан үүргээ зөрчсөн бол төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаанд оролцогч бүх талуудад учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй бөгөөд хариуцлагатай, чин шударга хэрэг гүйцэтгэгч болохын хувьд анхаарал болгоомжтой ажиллах үүрэгтэй(section 60). Мөн хэрэг гүйцэтгэгч нь гэрээ, хэлцлийн үндсэн дээр хуваарилагдах хөрөнгөд хамаарах шинэ өр үүсгэсэн бөгөөд уг өр төлбөрийг тухайн хөрөнгөөс бүрэн төлөх боломжгүй болсон бол хохирол учирсан давуу эрхтэй нэхэмжлэгч нарт нөхөн төлөх үүрэгтэй. Гэхдээ энэ хариуцлага нь тухайн хэрэг гүйцэтгэгч өрийг бий болгож байх үедээ хуваарилагдах хөрөнгийн дутагдлыг урьдчилан мэдэх боломжгүй байсан тохиолдолд хамаарахгүй(section 61). Мөн хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлэхийн өмнө эсхүл дараа нь хуваарилагдах хөрөнгө буурснаас үүдэн бүх нэхэмжлэгчидэд хохирол үүссэн тохиолдолд (нийтлэг хохирол) тэдний нөхөн төлбөр шаардах эрхийг зөвхөн шинээр томилогдсон хэрэг гүйцэтгэгч хэрэгжүүлэх боломжтой(section 92).

7. Төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх ажиллагаан дах хэрэг гүйцэтгэгчийн статус, чиг үүрэг

Хариуцагчийн төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөг нэхэмжлэгчдийн сүүлчийн хурлаас өмнө гаргаж өгөх эрхтэй(section 218). Харин нэхэмжлэгчдийн хурлаас төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөг боловсруулахыг шаардсан тохиолдолд хариуцагч эсвэл хэрэг гүйцэтгэгч нь уг төлөвлөгөөг боловсруулах үүрэгтэй бөгөөд хариуцагчаас шаардсан тохиолдолд хэрэг гүйцэтгэгч эсвэл хянан зохицуулагч нь зөвлөхийн үүрэг гүйцэтгэнэ(section 284).

Төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөний бүтцийн хэсэг(constructive part)-т тухайн төлөвлөгөөний ажиллагаанд оролцогч талуудын хэрэг гүйцэтгэгчийн хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ авах, тодорхой алдаа, дутагдлыг арилгах бүрэн эрхийг олгосон зохицуулалт тусгах боломжтой(section 221). Мөн хяналтын хугацаанд хариуцагч эсвэл хуулийн этгээдийн удирдлагын үйл ажиллагааг шилжүүлж авсан этгээд тодорхой гэрээ, хэлцэл хийхдээ хэрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөл авч байж хүчин төгөлдөр болохоор зааж болно(section 263).

Хэрэг эрхлэгч нь хяналт тавих/monitoring/ үүрэгтэй бөгөөд хяналтын хугацаанд жил бүр нэхэмжлэгчдийн хороонд (хэрэв байгуулагдсан бол) болон шүүхэд төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөний хэрэгжилт болон цаашдын төлөвийн талаар тайлан гаргаж өгөх үүрэгтэй. Энэхүү тайлагнах үүрэг нь нэхэмжлэгчдийн хороо болон шүүхийн зүгээс хүссэн үедээ тодорхой мэдээлэл эсвэл завсрын тайлан шаардах эрхэд нөлөөлөхгүй(section 261). Хэрэг гүйцэтгэгч нь хяналт хэрэгжүүлэх явцад нэхэмжлэлийн шаардлага хангагдахгүй эсвэл хангагдах боломжгүй болсоныг олж мэдсэн бол нэхэмжлэгчдийн хороо/эсвэл бүх нэхэмжлэгчид/ болон төлбөрийн шүүхэд шууд мэдэгдэх үүрэгтэй(section 262).

В. БНСУ-ын хэрэг гүйцэтгэгчид хамаарах зохицуулалт

1. Дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлсэн шийдвэр гарахаас өмнөх түр хэрэг гүйцэтгэгчийн чиг үүрэг

Шүүх хариуцагчийн хөрөнгөд яаралтай хамгаалалтын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх хүртэл хугацаанд түр хэрэг гүйцэтгэгчийг томилж болох бөгөөд хариуцагчийн удирдлагын эрх болон хөрөнгө захиран зарцуулах эрхийг зөвхөн түр хэрэг гүйцэтгэгч хэрэгжүүлнэ.

Түр хэрэг гүйцэтгэгч нь хэрэг гүйцэтгэгчийн нэгэн адил шүүх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд дараах аливаа үйлдлийг хийхдээ шүүхийн зөвшөөрөл авах бөгөөд шүүхийн зөвшөөрөлгүйгээр хийсэн дараах үйлдэл нь аливаа үйлдэл нь хүчин төгөлдөр бүс болно:

- 1) Хөрөнгө шилжүүлэх (захиран зарцуулах)
- 2) Хөрөнгө худалдан авах
- 3) Зээл авах болон ижил төстэй санхүүжилт
- 4) 119 дүгээр зүйл⁶³д заасны дагуу гэрээ цуцлах эсхүл дуусгавар болгох
- 5) Шүүхэд нэхэмжлэл гаргах
- 6) Эвлэрэх эсхүл арбитрын хэлэлцээр байгуулах

⁶³ Дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлэх үед хариуагч болон гэрээний нөгөө тал аль аль нь гэрээг бүрэн хэрэгжүүлж дуусаагүй байвал хэрэг гүйцэтгэгч нь гэрээнээс татгалзах эсвэл цуцлах болон өөрийн үүргээ гүйцэтгэж гэрээний нөгөө талыг үүргээ гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

- 7) Бүрэн эрхээсээ татгалзах
- 8) Олон нийтийн төлөө үүссэн өр төлбөр (нийтийн эрх ашгийн өр) эсхүл буцаан олголтын эрхийг хүлээн зөвшөөрөх
- 9) Бусад шүүхээс тогтоосон аливаа үйлдэл

Хэрэг гүйцэтгэгч нь дараах үйлдлийг шүүхийн зөвшөөрөлгүйгээр хийхийг хориглоно:

- 1) Хариуцагчийн бизнес эсхүл хөрөнгийг худалдан авах
- 2) Өөрийн бизнес эсхүл хөрөнгийг хариуцагчид шилжүүлэх
- 3) Өөртөө эсхүл гуравдагч этгээдийн төлөө хариуцагчтай ямар нэгэн арилжаа хийх

2. Дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлсэн шийдвэр гарсанаас хойш хэрэг гүйцэтгэгчийн чиг үүрэг

Шүүх нь хэрэг гүйцэтгэгчийн зөвлөл болон нэхэмжлэгчдийн зөвлөлийн саналыг харгалзан үүргийг гүйцэтгэхэд тохиромжтой этгээдийг хэрэг гүйцэтгэгчээр нэг эсвэл олон этгээдийг томилдог(article 74). Хэрэг гүйцэтгэгч нь үүргээ шүүхийн хяналт дор(article 81) шударгаар гүйцэтгэнэ(article 82). Хэрэг гүйцэтгэгч нь дээр дурдсан түр хэрэг гүйцэтгэгчийн гүйцэтгэх үүргийг гүйцэтгэхээс гадна дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

- 1) Шаардлагатай үед шүүхийн зөвшөөрлөөр хууль, менежментийн чиглэлээр мэргэшсэн зөвлөх томилж болно (article 77).
- 2) Хариуцагчийн хөрөнгөтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэг гүйцэтгэгч нь хэргийн тал болж оролцоно (article 78).
- 3) Мөн хариуцагчийн үйл ажиллагаа хөрөнгийн талаар тайлан шаардаж, бичиг баримт, эд хөрөнгийг шалгах эрхтэй (section 79).
- 4) Шүүхээс хэрэг гүйцэтгэгчид дамжуулсан хариуцагчийн шуудан илгээмжийг нээж үзэх эрхтэй (article 80).

3. Хэрэг гүйцэтгэгчийг чөлөөлөх

Хэрэг гүйцэтгэгч нь үндэслэл бүхий шалтгаантай тохиолдолд шүүхийн зөвшөөрлөөр чөлөөлөгдөнө. Мөн шүүх нь хохирол хүлээсэн этгээдийн хүсэлтээр эсвэл өөрийн санаачилгаар хэрэг гүйцэтгэгчийг чөлөөлж болно(article 83).

Харьцуулсан дүн шинжилгээ

Хариуцагчийн ил тод байх, хэрэг гүйцэтгэгчтэй хамтран ажиллах үүргийн тухайд:

Монгол улсын Дампуурлын тухай хуульд хариуцагчийн шаардлагатай баримт бичгийг гаргаж өгөх, хэрэг гүйцэтгэгчтэй хамтран ажиллах гэх мэт үүргүүдийг хуульчилж өгөөгүй. Харин тус хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д “хэрэг гүйцэтгэгчийн шийдвэрийг хариуцагч, нэхэмжлэгч бүр заавал биелүүлэх үүрэгтэй” гэж зохицуулсан байх бөгөөд энэ нь зөвхөн дампуурсанд тооцож татан буулгах ажиллагааг эхлүүлсэн шүүхийн шийдвэр гарсанаас хойш буюу хариуцагчийг татан буулгах ажиллагааны явцад хэрэг гүйцэтгэгчийн талаар хариуцагчийн хүлээх үүргийг хуульчилсан.

Гэвч дахин хөрөнгөжүүлэх эсвэл дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагааг эхлүүлэх хүртэл хэрэг гүйцэтгэгч болон түр хэрэг гүйцэтгэгчийн өмнө хариуцагчийн хүлээх үүргийг хуульчилж өгөөгүй. Энэ нь Дампуурлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хэрэг гүйцэтгэгчийн эрх, үүргээ хэрэгжүүлэхэд саад учрах нөхцлийг бүрдүүлж байна. Ялангуяа хариуцагчийн эд хөрөнгө, холбогдох баримт бичгийг хамгаалалтад авч, тооллого явуулах, үйл ажиллагаанд нь баримтын шалгалт хийх, шаардлагатай мэдээ баримтыг хариуцагчаас гаргуулан авах гэх мэт бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хариуцагч нь “гаргаж өгөх, хамтран ажиллах үүрэггүй” бөгөөд энэхүү “эс үйлдэхүйдээ хариуцлага хүлээдэггүй” нөхцөлд хэрэгжих боломжгүй байна.

Хөрөнгийн хамгаалалтын тухайд:

Монгол улсын Дампуурлын хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д түр хэрэг гүйцэтгэгчийн бүрэн эрхийг тодорхойлсон бөгөөд ингэхдээ дампуурлын хэрэг үүсгэснээс хойш 30 хоногийн дотор төлбөрийн чадваргүйдлийг тогтоож, түүнээс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэгчдийн анхны хурал хуралдаж, хэрэг гүйцэтгэгчийг шүүхэд санал болгоод, шүүх 5 хэрэг гүйцэтгэгчийг баталгаажуулах хүртэл дор хаяж 65 хоногийн турш хариуцагчийн удирдлагын үйл ажиллагаа болон төлбөрийн хяналтын талаар ямарч бүрэн эрхийг түр хэрэг гүйцэтгэгч эдлэхгүй байна.

Харин шүүхийн шийдвэрийн дагуу хариуцагчийн эд хөрөнгө битүүмжлэх, хамгаалалтад авах, тооллого явуулах зэрэг бүрэн эрх эдэлж байгаа нь хариуцагчийн бизнесийн үйл ажиллагааг бүрэн эсвэл хэсэгчлэн зогсоох эрсдэл байгаа боловч дахин хөрөнгөжүүлэх боломжтой бизнесийн хувьд уян хатан биш байна. Өөрөөр хэлбэл, зарчмын хувьд дампуурлын хэрэг үүсгэхэд хариуцагчийн өмчлөлд байсан буюу түүнийг татан буулгаж улсын бүртгэлээс хасах хүртэлх хугацаанд шинээр бий болсон өмчлөлийн зүйлс, тэдгээрээс бий болох ашиг, орлогыг хариуцагчийн хуваарилагдах эд хөрөнгөд хамруулдаг(ДтХ 17.1) энэ агуулгаараа дампуурлын хэрэг үүсгэснээс хойш “хэрэг гүйцэтгэгч”-ийг томилох хүртэлх завсрын хугацаанд эд хөрөнгийг хамгаалахын зэрэгцээ зайлшгүй төлөгдөх бизнесийн ердийн үйл ажиллагааг тасалдуулахгүй байх зорилготой төлбөрийг хэрхэн гүйцэтгэх талаар зохицуулалт байхгүй байна.

Мөн төлбөрийн чадваргүйдэлд хүрсэн, хэт төлбөрт орсон хариуцагч дампуурлын хэрэг үүсэхээс өмнө болон дараа ямар төлбөрийг гүйцэтгэж болох, ямар төлбөрийг гүйцэтгэсэн тохиолдолд хуулийн хариуцлага хүлээх талаар хэрэг гүйцэтгэгч ямар эрх, үүрэгтэй оролцох талаар тодорхой зохицуулалт байхгүй байна.

Шүүхийн шийдвэрээс үзвэл⁶⁴ нэхэмжлэгчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч “М” ХХК-ийн бүх хувьцааг эзэмшдэг толгой компани болох “Г П” НХК нь “М” -ийн дансанд байсан 200 000 ам долларыг Орос руу шилжүүлсэн үйлдлээрээ “М” ХХК-ийн хөрөнгөнд хохирол учруулсан. “М” ХХК-ийн хувьцаа эзэмшигч нь охин компаниа дампуурах нь зайлшгүй болсон үед энэ шилжүүлгийг хийсэн учраас “Г П” НХК-ийн үйлдлийг зөвтгөх боломжгүй...” дурдсан ч анхан болон давж заалдах шатны шүүх энэ талаар дүгнэлт

⁶⁴ https://shuukh.mn/single_case/4276?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=

хийгээгүй талаар хяналтын гомдолдоо дурдсан боловч хяналтын шатны шүүх ч мөн адил дүгнэлт хийгээгүй байна. Эндээс үзвэл төлбөрийн чадваргүй болсон үедээ толгой компанийн зээлийн гэрээний төлбөрт хөрөнгө шилжүүлсэн нь үндэслэлтэй байсан эсэх талаар практикт маргаан гарч байга боловч шүүхээс энэ талаар дүгнэлт хийхгүй байна.

Хариуцагч нь нэхэмжлэгч эсвэл хариуцагчаар оролцож байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэг гүйцэтгэгч хэрхэн оролцох талаар зохицуулаагүй, мөн хариуцагчийн ажилтны талаар хөдөлмөрийн харилцааны хүрээнд хэрэг гүйцэтгэгчийн эрх үүрэг зохицуулалтгүй. Мөн хариуцагчийн бусад харилцагчтай хийсэн хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээнүүдийг ямар тохиолдолд цуцлах, татгалзах эсхүл гэрээний үүргээ гүйцэтгээд үргэлжлүүлэх талаар хэрэг гүйцэтгэгчийн эдлэх эрх үүрэг тодорхойгүй. ХБНГУ болон БНСУ-ын хувьд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт эсхүл дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлэх хүсэлт ирүүлсэн үеэс хариуцагчийн хөрөнгийг хамгаалах зохицуулалтууд үйлчилдэг бөгөөд хариуцагчийн хөрөнгийг хэрэг гүйцэтгэгч тухайн үеэс багасгасан тохиолдолд хохирол нөхөн төлөх хариуцлага хүлээдэг. Иймд дээрх харилцаанд хэрэг гүйцэтгэгчийн эрх, үүргийг талаар тодорхой зохицуулалт тусгажээ.

Гурав. Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа

Монгол улсын хувьд дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргахгүй байх нь нийтлэх үзэгдэл бөгөөд 1997 онд Дампуурлын тухай хууль батлагдсанаас хойш “гарын таван хуруу”⁶⁵-нд багтах хэргүүд дахин хөрөнгөжүүлэхээр шийдвэрлэгдсэн байдаг. Ийнхүү Дампуурлын тухай хуулийн хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэхтэй холбогдсон зохицуулалт хэрэгжихгүй байхаа шалтгаан нь зохицуулалтын дараах асуудалтай холбоотой гэж үзэж байна.

3.1. Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх шүүхийн шийдвэрийн зохицуулалт дутмаг

Дампуурлын тухай хуульд дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа хэрхэн эхлэх талаар тодорхой зохицуулалт байхгүй. Хэдийгээр Дампуурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д хариуцагчийг дахин хөрөнгөжүүлж, үйл ажиллагааг нь цаашид үргэлжлүүлэх нь татан буулгаснаас нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг илүү хэмжээгээр хангах боломжтой гэж үзвэл хариуцагч өөрөө эсвэл хариуцагчаас нэхэмжилсэн нийт төлбөрийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг нэхэмжилж байгаа нэхэмжлэгчид эсвэл хэрэг гүйцэтгэгч нь хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх тухай хүсэлтийг түүнийг төлбөрийн чадваргүйд тооцсон өдрөөс хойш 60 хоногийн дотор шүүхэд гаргаж болохоор зохицуулсан. Өөрөөр хэлбэл, нэгэнт мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлтийн шаардлагыг хуульчилсан тул дахин хөрөнгөжүүлэх хүсэлт хүлээн авсан шүүх нь зайлшгүй энэхүү шаардлагад хүсэлт нийцсэн эсэхийг хянаж, хүсэлт хүлээн авах эсэхийг шийдвэрлэнэ.

⁶⁵ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Аж ахуйн нэгжийн дампуурал ба дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа”,

Хэрэв хүсэлт нь хуульд заасан шаардлага хангаж байгаа тохиолдолд шүүгч нь хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлсэнийг баталгаажуулсан шийдвэр гарах шаардлагатай юм. Энэ нь мөн дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг гаргаж өгөх хугацаатай холбогдох ёстой буюу хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргасан этгээд холбогдох төлөвлөгөөгөө шүүх тухайн ажиллагааг эхлүүлсэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон үеэс тодорхой хугацааны дотор боловсруулж, хүргүүлэх шаардлага бий болох юм.

Гэтэл одоогийн байгаа зохицуулалтаар дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлттэй танилцсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шүүхэд гаргаж өгөхөөр зохицуулсан байгаа нь логик дараалалгүй байна. Мөн хариуцагч эсвэл хэрэг гүйцэтгэгч хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэхээр хүсэлт гаргасан тохиолдолд нэхэмжлэгчид шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрх хангагдах ёстой. Эсвэл эсрэгээрээ нэхэмжлэгчид хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэхээр хүсэлт гаргасан тохиолдолд хариуцагч эсвэл хэрэг гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхээр хангагдах шаардлагатай болно.

Харьцуулсан судалгааны үүднээс авч үзэхэд, БНСУ-д хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлтийг хүлээн авсан шүүх нь нэгдүгээрт, шаардлагатай мэдээллийг дутуу бөглөсөн, тэмдэгтийн хураамж төлөөгүй, өргөдөл гаргах эрхгүй этгээдээс гаргасан зэрэг үндэслэл тогтоогдвол хүсэлтийг хүлээн авахаас татгалздаг, хоёрдугаарт, хэрэв дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны зардлыг урьдчилж төлөөгүй, санаатайгаар худал өргөдөл өгсөн эсвэл нийт нэхэмжлэгчдийн эрх ашигт нийцэхгүй байгаа нөхцөлд хүсэлтийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргадаг/Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хуулийн 42-р зүйл/.

Хэрэв хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт нь дээрх шаардлагыг хангаж байгаа тохиолдолд шүүх 1) хууль ёсны эсэх, 2) дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх үндэслэл байгаа эсэхийг нягталж дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх шийдвэр гаргадаг.⁶⁶ БНСУ-ын хувьд дампуурлын хэрэг үүсгэхгүйгээр шууд анхнаасаа хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлэх боломжтой байдаг тул хүсэлтийг зайлшгүй шийдвэрлэх нь чухал ач холбогдолтой юм.

Дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бие даасан байдлаар эхлүүлэх боломжтой байдлаар зохицуулах тохиолдолд дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг үндэслэлгүйгээр эхлүүлэхээс сэргийлэх зорилгоор “дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх үндэслэл”-ийг нотлох үүргийг хүсэлт гаргагчид оногдуулах шаардлага бий болдог. Мөн Хэрэв хүсэлт гаргагч нь нэхэмжлэгч, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч бол өөрийн эзэмшдэг хувьцааны хэмжээ эсвэл эзэлийн хэмжээг нотлох үүрэгтэй байдаг.

3.2. Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах эрх бүхий субъект

Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах эрх бүхий этгээдийг дараах байдлаар явцууруулсан нь хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг зөрчиж байна.

- 1) хариуцагч өөрөө;

⁶⁶ 박승두 and 안청현. "기업회생제도에 관한 한국과 미국의 비교연구" 법학논총 35, no.3 (2018), 261 면.

- 2) хариуцагчаас нэхэмжилсэн нийт төлбөрийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг нэхэмжилж байгаа нэхэмжлэгчид;
- 3) хэрэг гүйцэтгэгч.

Учир нь шүүхийн шийдвэрүүдээс үзвэл хариуцагчийн төлбөрийн чадваргүй болсон үндэслэл шалтгаан нь компанийн эрх бүхий албан тушаалтнуудын буруутай үйл ажиллагаа байна гээд дүгнэсэн байдаг бөгөөд энэ талаар шаардлага гаргах эрх бүхий этгээд нь хувьцаа эзэмшигч юм. Өөрөөр хэлбэл, компанийн эрх бүхий албан тушаалтанд Компанийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж болдог. Эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүйгээс компанид хохирол учирсан тохиолдолд тухайн эрх бүхий албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр зохицуулсан (КтХ 84.10, 84.6, 86.2) бөгөөд компани өөрөө эсхүл хувьцаа эзэмшигч шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг. Гэтэл хувьцаа эзэмшигч нь дампуурлын хэргийн оролцогч биш тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад аливаа хүсэлтээ шийдвэрлүүлэх боломжгүй юм. Ялангуяа, компаниа төлбөрийн чадваргүй болоход буруутай байсан эрх бүхий албан тушаалтнаас компанид учирсан хохирлоо нэхэмжлэх замаар өр болон хөрөнгийн харьцааг багасгах, дахин хөрөнгөжүүлэх хүсэлт өгөх боломжгүй үр дагаварт хүргэж байна.

Төлбөрийн чадваргүй болсон шалтгаан нь компанийн удирдлага буруутай байгаа тухай шүүхийн шийдвэр

Улсын Дээд шүүхийн 2018.10.18-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/01435 дугаар тогтоолд “...Орлого орсон байхад ... татвар төлөгч татвараа төлөөгүй нь хүсэлт гаргагч компанийн өөрийн удирдлагын буруутай үйл ажиллагаатай холбоотой, бусдаас шалтгаалаагүй байгаа нь хэрэгт авагдсан баримтаар тогтоогдсон, Татварын ерөнхий хуульд зааснаар татвар төлөгч нь татварыг төлөх үүрэгтэй, түүнчлэн шүүхийн шийдвэр биелэгдэх учиртай тул дээр дурдсан үндэслэлээр тухайн компанийг дампуурсанд тооцож, татан буулгаж, татвар төлөх үүрэгээс чөлөөлөх үндэслэлгүй...” гэж дүгнэсэн. Энэхүү дүгнэлтээс үзвэл, нэгдүгээрт, хариуцагч төлбөрийн чадваргүй, хоёрдугаарт, хариуцагчийн төлбөрийн чадваргүй байдалд тухайн компанийн удирдлага нь буруутай, гуравдугаарт, хэрэв шүүх компанийг дампуурсанд тооцоод шийдчихвэл татварын өрнөөс чөлөөлөгдөх магадлалтай гэж үзсэн тул хүсэлтийг хэрэгсэхгүй болгож байна.

Харьцуулсан судалгаа хийж үзвэл, дараах этгээдүүд дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргадаг байна:

Улс	Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах үндэслэл
БНСУ ⁶⁷	① Дараах нөхцөлийн аль нэгэнд хамаарах тохиолдолд хариуцагч шүүхэд дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх хүсэлт гаргах боломжтой.

⁶⁷ Article 34 of Debtor rehabilitation and bankruptcy act

	1) Бизнесийн үйл ажиллагааг ноцтойгоор доголдуулалгүйгээр төлбөр төлөх хугацаа нь болсон өрийг төлөх боломжгүй болсон тохиолдол. 2) Хариуцагч дампуурах нөхцөл бүрдэх эрсдэлтэй тохиолдол. ② Дээрх 1 дүгээр хэсгийн 2 дахь заалтад заасан тохиолдолд дараах ангиллын этгээдүүд дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх хүсэлт гаргах эрхтэй. 1) Хариуцагч хувьцаат компани эсхүл хязгаарлагдмал хариуцлагатай компани байвал: a. Хөрөнгийн 10-аас дээш хувьд дүйцэх хэмжээний нэхэмжлэлтэй нэхэмжлэгч. b. Хөрөнгийн 10-аас дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч буюу хөрөнгө оруулагч. 2) Хариуцагч хувьцаат компани эсхүл хязгаарлагдмал хариуцлагатай компани биш байвал: a. 50 сая төгрөгөөс дээш хэмжээний нэхэмжлэлтэй нэхэмжлэгч. b. Бүрэн хариуцлагатай, хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл болон бусад хуулийн этгээд эсхүл үүнтэй адилтгах этгээдийн нийт хөрөнгийн 10-аас дээш хувийг эзэмшдэг хувь нийлүүлэгч.
ХБНГУ ⁶⁸	Дампуурлын ажиллагааг зөвхөн бичгээр гаргасан хүсэлтийн үндсэн дээр эхлүүлнэ. Ийм хүсэлтийг нэхэмжлэгч болон хариуцагч гаргаж болно. Хариуцагч хүсэлтдээ нэхэмжлэгчдийн жагсаалт болон тэдний нэхэмжлэлийн хэмжээг хавсаргах үүрэгтэй. Хэрэв хариуцагч үйл ажиллагаагаа зогсоогоогүй байгаа бол жагсаалтад дараах мэдээллийг тодорхой заах шаардлагатай: 1) Хамгийн өндөр дүнтэй нэхэмжлэлүүд, 2) Хамгийн өндөр дүнтэй барьцаатай нэхэмжлэлүүд, 3) Татварын албаны нэхэмжлэлүүд, 4) Нийгмийн даатгалын байгууллагуудын нэхэмжлэлүүд, 5) Ажилчдын тэтгэврийн схемээс үүссэн нэхэмжлэлүүд. Ийм тохиолдолд хариуцагч нь тайлан балансын нийт дүн, борлуулалтын орлого, өмнөх жилийн ажилчдын дундаж тоог мөн зааж өгөх ёстой.

3.3. Дахин хөрөнгөжүүлэх хүсэлтэд тавигдах шаардлага

Дампуурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Дахин хөрөнгөжүүлэх хүсэлтэд хариуцагчийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх санхүү, удирдлагын болон бусад боломж, тэдгээрийн тооцоо, өөрчлөн байгуулагдсан аж ахуйн нэгжийн хэтийн төлөвийн талаар тусгана” гэж дахин хөрөнгөжүүлэх хүсэлтэд тавигдах шаардлагыг зохицуулсан байдаг. Гэвч хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа нь дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дунд нэг үе шат болгон зохицуулсан байдгаас

⁶⁸ Section 13 of Insolvency code

дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад үе шат нь дахин хөрөнгөжүүлэх хүсэлт хүлээж авах урьдчилсан нөхцөл болох юм.

Тодруулбал, Дампуурлын тухай хуулийн дампуурлын хэрэг үүсгэх тухай 2 дугаар бүлэгт зохицуулсны дагуу дампуурсанд тооцуулах хүсэлт хүлээн авсан шүүгч нь (1) дампуурлын хэрэг үүсгэх, (2) төлбөрийн чадвартай болох эсэх захирамжийг гаргадаг. Шүүгч дампуурлын хэрэг үүсгэсний хойш 30 хоногийн дотор төлбөрийн чадвартай болох эсэхийг шалгаж, “*төлбөрийн чадвартай*” эсхүл “*төлбөрийн чадваргүй*” болсныг тогтоох шийдвэр гаргадаг.бөгөөд энэ үеэс хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт өгөх хугацааг тоолж эхэлдэг.

Дампуурлын тухай хуулиар компанийг дампуурсанд тооцож, татан буулгахад нэгдүгээрт, төлбөрийн чадваргүй байх/ДтХ 5.3/ хоёрдугаарт, дахин хөрөнгөжүүлэхгүйгээр шийдвэрлэгдсэн эсхүл боломжгүй болсон/ДтХ 33.1/ хоёр урьдчилсан нөхцөлийг шаарддаг. Эхний нөхцөл буюу төлбөрийн чадвартай эсэхийг нэхэмжлэл, хүсэлтийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шүүх тогтоодог бөгөөд энэхүү захирамжаар хуулийн этгээдийг дампуурсанд тооцдоггүй. Компанийг төлбөрийн чадваргүй болохыг тогтоосноос хойш шүүх дампуурсанд тооцож, татан буулгах хүртэл хамгийн багадаа 60 хоног буюу хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт хүлээн авах хугацаа тоолдог бөгөөд хамгийн ихдээ 130 хоног⁶⁹ байдаг. Үүний дараа хоёр дахь нөхцөл хангагдаагүй тохиолдолд шүүх хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах тухай шийдвэр гаргадаг.

Тодруулбал, дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны хувьд дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагаа эхлэх урьдчилсан нөхцөлийн хувьд хуульчлагдсан. Энэ хүрээнд зөвхөн дампуурлын хэрэг үүссэн хэргийн хувьд шүүх 1) дахин хөрөнгөжүүлэх хүсэлт ирсэн эсэх 2) хүсэлт ирсэн ч дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг шүүхэд ирүүлсэн эсэх 3) төлөвлөгөө ирүүлсэн ч шүүх баталсан эсэх 4) шүүх төлөвлөгөөг баталсан ч төлөвлөгөө хэрэгжүүлэх боломжгүй болсон эсэхийг тогтоох юм.

Иймд хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах урьдчилсан нөхцөл нь дараах байдлаар томъёологдож байна:

- 1) Дампуурлын хэрэг үүсгэх нэхэмжлэл, хүсэлт нь Дампуурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийг хангасан байх;
- 2) Дампуурлын хэргийг үүсгэсэн захирамж гарсан байх;
- 3) Хариуцагчийн төлбөрийн чадваргүй болохыг тогтоосон шүүгчийн захирамж хүчин төгөлдөр болсон байх ;
- 4) Төлбөрийн чадваргүйд тооцсон өдрөөс хойш 60 хоног өнгөрөөгүй байх;
- 5) Дампуурлын тухай хуулийн 23.2-т заасан хүсэлтэд тавигдах шаардлагыг хангасан байх.

Дүн шинжилгээ

⁶⁹ 1. Дахин хөрөнгөжүүлэх хүсэлтийг 60 хоног хүлээнэ/ДтХ 23.1/.
2. Хүсэлт өгсөн этгээд хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлттэй танилцсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө батална.
3. Дээрх хугацаанаас хойш 20 хоногийн дотор төлөвлөгөөг хэлэлцэх хурал хийнэ/ДтХ 26.1/.
4. Төлөвлөгөө хэлэлцсэнээс хойш 20 хоногийн дотор шүүх батлах эсэх шийдвэр гаргана/ДтХ 28.1/.

Дээрх байдлаар дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатууд нь дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах урьдчилсан нөхцөл байхаар зохицуулсны үр дагавар нь практикт хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх Дампуурлын эрх зүйн зохицуулалт хэрэгжихгүй байхад хүргэж байна. Энэ нь нэгдүгээрт, хариуцагчийн сэргэх боломжгүй санхүүгийн нөхцөл байдлаас үүдэлтэй, хоёрдугаарт, дахин хөрөнгөжих механизмын бизнес эрхлэгч ашиглах боломжгүй байдалд хүргэж байна.

Сэргэх боломжгүй санхүүгийн байдал

Шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд өр болон эздийн өмчийн харьцаа хэт өндөр байгаа нь нийтлэг байна. Жишээлбэл, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 184/2024/03943/И дугаар шийдвэр ⁷⁰ -ийн ҮНДЭСЛЭХ хэсэгт “ХХК нь өөрийн хөрөнгийн 1,248.3 хувьтай тэнцэх хэмжээний өр төлбөртэй, компанийн үйл ажиллагааг удирдах менежмент дутагдаж, татварын өр төлбөр ихсэж 2018 он гэхэд 125,048,952 төгрөгийг татварын өрийг төлж чадаагүйгээс хэвийн үйл ажиллах явуулах боломжгүй болсон”⁷¹ гэж дүгнэсэн байдаг.

Мөн шүүхийн шийдвэрүүдэд нэхэмжлэлээр гэхээсээ илүүтэйгээр хариуцагчийн хүсэлтээр дампуурлын хэрэг үүсдэг жишиг нийтлэг байна. Ингэхдээ бодит байдалд төлбөрийн үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаандаа гүйцэтгэх чадамжгүй болсон буюу төлбөрийн чадваргүй болсоноо мэдсэнээс хойш эсвэл тийнхүү эрсдэл бий болохыг мэдсэнээс хойш хэт олон жил өнгөрсний дараа хариуцагч хуулийн этгээдийг төлөөлөн дамдуурсанд тооцож, татан буулгуулах хүсэлт шүүхэд гаргаж байна. Энэ нь төлбөрийн чадваргүйдэл бодитоор бий болсон эсвэл бий болох эрсдэлд байгаа хариуцагчийн эрх бүхий албан тушаалтанд шүүхэд хандах үүрэг оногдуулаагүйгээс үүдэлтэй байна. Жишээлбэл, Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 102/2023/02694/И дугаар шийдвэрийн хариуцагчийн тайлбараас үзвэл “2010 оноос эхлэн компанийн үйл ажиллагаанд доголдол үүсэж төлбөрийн чадвар алдагдан компанийг дахин хөрөнгөжүүлэх боломжгүй болж ихээхэн хэмжээний алдагдал бий болсон тул хөрөнгө оруулагч нараас хүлээн авсан хөрөнгө оруулалтыг эргүүлэн төлж чадахгүй болж өр төлбөр үүсэх зэрэг санхүүгийн хүндрэлүүд үүссэн” гэх боловч ийнхүү төлбөрийн чадваргүй болсоноосоо хойш 13 жилийн дараа компанийн нийт хөрөнгө 11,528 төгрөг, өр төлбөр 351,408,367₮ -т хүрсэний дараа 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр “ЖЖ” ХХК нь дампуурсанд тооцож, татан буулгуулах хүсэлтийг шүүхэд гаргасан.

ХБНГУ-ын жишээнээс авч үзвэл хуулийн этгээд нь төлбөрийн чадваргүй эсвэл хэт төлбөрт орсон (overindebtedness)⁷² нөхцөлд түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд⁷³ нь төлбөрийн чадваргүй болсон өдрөөс хойш 3 долоо хоногийн дотор, хэт төлбөрт орсон өдрөөс хойш хамгийн ихдээ 6 долоо хоногийн дотор төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргах үүрэгтэй(Section 15a) байдаг учраас олон жил өр

⁷⁰ https://shuukh.mn/single_case/166055?daterange=1997-01-01%20-%202025-03-21&id=1&court_cat=1&bb=1

⁷² Төлбөр хийх үүргээ биелүүлэхэд өртэй этгээдийн хөрөнгө хангалтгүй болсон тохиолдолд хэт төлбөрт орсон байдал (overindebtedness)-д тооцно. Гэвч бүх нөхцөл байдлыг харгалзан үзвэл тухайн аж ахуйн нэгж ирэх 12 сарын хугацаанд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх магадлал өндөр байвал, энэ нь хэт төлбөрт орсон гэж үзэгдэхгүй(section 19).

⁷³ Үүнээс гадна хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд хувьцаа эзэмшигч нар тус үүргийг хүлээдэг.

төлбөр улам нэмэгдүүлэхээс урьдчилан сэргийлдэг. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч нар хариуцагч хөрөнгөө хэт багасгахаас өмнө нэхэмжлэлийн шаардлагаа хангуулах боломж бүрдэх юм. Үүнээс гадна хэт өрөнд орохоос өмнө шүүхэд хандах боломжийг нээх нь өр болон өөрийн хөрөнгийн харьцаа дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлэх зөв баланс дээр байх үед ажиллагааг эхлүүлэх боломжтой болно.

Дахин хөрөнгөжих механизмыг бизнес эрхлэгч ашиглах боломжгүй байдал

Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т зааснаар Дампуурлын хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор шүүх нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулж, 30 хоногийн дотор хариуцагчийг төлбөрийн чадвартай болох эсэхийг тогтоох бөгөөд үүнээс хойш 7 хоногийн дотор шүүх энэ тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлдэг. Энэхүү ажиллагааны зорилго нь нэг талаар төлбөрийн чадваргүй хуулийн этгээдээс авлагатай нэхэмжлэгч нарт мэдээлэх, нөгөө талаар хариуцагчийн харилцагч нарт мэдэгдэж хохирлын хэмжээг бага байлгах явдал юм. Гэтэл төлбөрийн чадваргүй болохыг шүүх тогтоож, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж, дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгааг олон нийт мэдсэнээр тухайн бизнес эрхлэгчийн маш их нэр хүнд унадаг. Энэ тогтолцоо оршиж байгаа нөхцөлд бизнес эрхлэгч нь дампуурлын хэрэг үүсгүүлэх замаар дахин хөрөнгөжих боломж байгаа гэдэгт итгэхэд бэрх байж болно. Иймд бизнес эрхлэгчид Дампуурлын тухай хуульд заасан хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх механизмыг ашиглах боломжгүй нөхцөлд байна гэж үзэж байна. Хэрэв дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бие даасан байдлаар эхлүүлэх боломжтой байдлаар зохицуулах тохиолдолд дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг үндэслэлгүйгээр эхлүүлэхээс сэргийлэх зорилгоор “дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх үндэслэл”-ийг нотлох үүргийг хүсэлт гаргагчид оногдуулах шаардлага бий болдог.

Харьцуулсан судалгааны үүднээс БНСУ-ын хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх зохицуулалтыг авч үзвэл Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд зааснаар хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд нэр, хаягаас гадна дараах зүйлийг заавал тусгахыг шаарддаг. Үүнд:

- 1) Хүсэлтийн зорилго, агуулга;
- 2) Дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх болсон шалтгаан;
- 3) Хариуцагчийн бизнесийн зорилго болон үйл ажиллагааны байдал;
- 4) Хариуцагчийн гаргасан хувьцаа эсвэл хөрөнгө оруулалтын нийт тоо хэмжээ, хөрөнгийн хэмжээ, актив, пассив болон бусад санхүүгийн байдал;
- 5) Хариуцагчийн эд хөрөнгөтэй холбоотой өөр процесс эсвэл шийдвэрлэгдсэн асуудал (хүсэлт гаргагч мэдэж байгаа тохиолдолд);
- 6) Хэрэв хүсэлт гаргагч дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөний талаар саналтай бол уг саналыг тусгах.
- 7) Хэрэв нэхэмжлэгч дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх хүсэлт гаргавал, түүний эзэмшиж буй зээлийн хэмжээ болон үүссэн шалтгаан;
- 8) Хэрэв хувьцаа эзэмшигч буюу хөрөнгө оруулагч дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх хүсэлт гаргавал түүний эзэмшиж буй хувьцаа эсвэл хөрөнгө оруулалтын тоо хэмжээ эсвэл үнийн дүн.

Дээрх зохицуулалтаас үзвэл, хүсэлт гаргагчаас харьцангуй ерөнхий мэдээллийг шаардаж байна. Энэ нь нэхэмжлэгчдийн хувьд нэхэмжлэлдээ хавсаргах боломжгүй хариуцагч хуулийн этгээдийн нарийн мэдээлэл байх бөгөөд хариуцагчийн хувьд дампуурлын хэрэг үүсгэх тухай хүсэлт гаргахдаа ч бүрдүүлэхэд хүндрэлтэй баримт бичгүүд байх бөгөөд нэхэмжлэл, хүсэлтийг шүүх хүлээж авахгүй байх, татгалзах магадлалыг өндөрсгөж байна. Шүүхийн шийдвэрийн ХЯНАВАЛ хэсгийн 2-т “Дампуурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д зааснаар дампуурлын хэрэг үүсгэх тухай хариуцагчийн хүсэлтэд сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан тэнцэл, өмчлөлдөө байгаа, эсхүл итгэмжлэн өмчилсөн эд хөрөнгийн жагсаалт, тэдгээрийн үнэлгээний талаарх санал, нэхэмжлэгчдийн нэр, хаяг, нэхэмжлэгч тус бүрийн авлага буюу гаргуулах төлбөрийн хэмжээ, хариуцагчид төлбөртэй этгээдийн нэр, хаяг, төлбөрийн тухай мэдээллийг хавсаргасан байхыг шаарддаг... ХХК-ийн өр төлбөрийн хэмжээг хэрэгт авагдсан баримтын хэмжээнд тогтоох боломжгүй, хүсэлтийг хангах үндэслэлгүй байх тул анхан шатны шүүх хүсэлтийг хэрэгсэхгүй болгохдоо Дампуурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4 дэх хэсэгт заасныг зөрчөөгүй байна” гэж дээрх шаардлагыг хангаагүй үндэслэлээр хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

3.4. Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт хүлээн авсан шүүхийн ажиллагаа

Манай улсын хувьд дахин хөрөнгөжүүлэх хүсэлт ирсэнтэй холбоотой дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэлэлцэх батлах үе шатанд хариуцагч хуулийн этгээдээс нэмэлт нотлох баримт шаардах, мэдүүлэг авах гэх мэт шүүхийн мөрдөн шалгах чиг үүргийг зохицуулсан зохицуулалт байхгүй байна. Жишээ нь БНСУ-ын хувьд шүүх нь нэхэмжлэгч, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд хариуцагчаас санхүүгийн байдал болон удирдлагын талаарх мэдээлэл гаргаж өгөхийг шаардаж болдог(Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хууль 34 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг). Энэ нь нэг талаас шүүх шийдвэр гаргахад шаардлагатай нотлох барим, мэдээллийг авах боломжийг олгохоос гадна хүсэлт гаргагч нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, нэхэмжлэгчийн зүгээс шүүхэд хүсэлт гаргах замаар хариуцагч хуулийн этгээдээс нотлох баримт гаргуулах боломж юм. Мөн тус хуулийн 41 дүгээр зүйлд зааснаар дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд шүүх нь хариуцагч эсвэл түүний төлөөлөгчөөс мэдүүлэг, тайлбар(questioning) авах үүрэгтэй байдаг. Гэхдээ хэрэв хариуцагч буюу түүний төлөөлөгч гадаадад оршин суудаг бөгөөд тэднийг мэдүүлэг, тайлбар авах ажиллагаанд оруулах нь дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг хэт удаашруулах эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд эсвэл хариуцагч буюу түүний төлөөлөгчийн байршил тодорхойгүй тохиолдолд шүүх мэдүүлэг, тайлбарыг авахгүй байж болдог.

А. ХБНГУ-ын хуулийн этгээдийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, сэргээхэд чиглэсэн зохицуулалт

1. Төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөнд хамаарах зохицуулалт

ХБНГУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа нь хариуцагчийн хөрөнгийг зарж борлуулах, үүнээс олсон

орлогыг хуваарилах эсвэл аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хэвээр хадгалах зорилгоор төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөө/insolvency plan/-ний хүрээнд зохицуулалт хийх замаар нэхэмжлэгчдийн нийтлэг эрх ашгийг хангахад чиглэгдэнэ. Үүний үр дүнд өр төлбөртэй шударга этгээдэд үлдэгдэл өрөөс чөлөөлөгдөх боломжийг олгодог. Иймд төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөнд хөрөнгийг бэлэн мөнгө болгох болон хуваарилах нь заавал байх шаардлагагүй бөгөөд уг төлөвлөгөөний хүрээнд хөрөнгийг зарж борлуулах (Liquidation), төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг шилжүүлэн аван шинэчлэх (takeover rehabilitation), эсвэл нь дахин хөрөнгөжүүлэх (corporate rehabilitation) зэрэг хувилбарууд багтдаг.

Нэхэмжлэгчид нь татан буулгах (liquidation) болон дахин хөрөнгөжүүлэх журамд заасны дагуу борлуулалтын орлогоос төлбөрөө авдаг бол компанийг худалдан авсан тохиолдолд бизнесийн үйл ажиллагааны ашгаас төлбөр барагдуулдаг.⁷⁴ Өөрөөр хэлбэл, хөрөнгийг захиран зарцуулах эрх нь олон төрөлтэй байдаг тул төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөний загвар ч мөн адил олон янз байна. Иймээс дампуурлын төлөвлөгөөний зорилгоос хамааран дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө, аж ахуй нэгжийг худалдах төлөвлөгөө (takeover plan), татан буулгах төлөвлөгөө (liquidation) гэх мэт төрөлд хуваагддаг.

Энэ утгаараа, Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 217 дугаар зүйлд төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөний зарчмыг тодорхойлохдоо “энэ хуульд заасан журмыг үл харгалзан давуу байдлаар хангагдах тусгай шаардлага бүхий нэхэмжлэгчид болон бусад нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлага хангагдах дараалал, хуваарилагдах хөрөнгийг мөнгөн хөрөнгө рүү хувиргах, мөнгөн хөрөнгийг хуваарилах төлөвлөгөө, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны журам, уг ажиллагаа дуусгавар болсоны дараах хариуцагчийн хариуцлагыг тусгасан төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөө хэрэгжүүлж болно. Хариуцагч нь хуулийн этгээд байгаа тохиолдолд хувьцаа эзэмшлийн эрх болон гишүүнчлэлийн эрхийг мөн төлөвлөгөөнд багтааж болно” гэж хариуцагч татан талуудын тохиролцооны чөлөөт байдлыг олгосон.

2. Төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөө гаргах эрх бүхий субъект

ХБНУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн хуулийн 156 дугаар зүйлд зааснаар хариуцагчийн үйл ажиллагааг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн үргэлжлүүлэх боломжийг үнэлж, төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөө боловсруулах боломж байгаа эсэхийг зааж, тус бүрийн хувилбар нь нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг хангахад хэрхэн нөлөөлөх талаар тайлбарлах үүрэгтэй.

Хариуцагчийн төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөг хариуцагч эсвэл хэрэг гүйцэтгэгч нь нэхэмжлэгчдийн сүүлчийн хурлаас өмнө гаргаж өгөх эрхтэй (section 218). Харин нэхэмжлэгчдийн хурлаас төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөг боловсруулахыг шаардсан тохиолдолд хариуцагч эсвэл хэрэг гүйцэтгэгч нь уг төлөвлөгөөг боловсруулах үүрэгтэй бөгөөд хариуцагчаас шаардсан тохиолдолд хэрэг гүйцэтгэгч эсвэл хянан зохицуулагч нь уг төлөвлөгөө боловсруулахад зөвлөхийн үүрэг гүйцэтгэнэ (section 284).

⁷⁴이상영. "유럽 기업회생법제의 특색과 시사점" 비교사법 14, no.2 (2007), 381 면.

3. Төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөний бүтэц

Төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөө нь тодорхойлох (тунхаглал)/ declaratory/ хэсэг болон бүрдүүлбэр/ constructive/ хэсгээс бүрдэх бөгөөд уг төлөвлөгөөнд тус хуулийн 229 болон 230 дугаар зүйлд заасан хавсралтуудыг хавсаргах ёстой(section 219).

Тодорхойлох(тунхаглал)/declaratory/ хэсэг нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхэлснээс хойш хэрэгжүүлсэн эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээнүүдийг тайлбарлаж, ажиллагаанд оролцогч талуудын эрхийг бий болгох үндэс суурийг хэрхэн бүрдүүлж байгааг тодорхойлно. Мөн энэ хэсэг нь төлөвлөгөөг батлах шийдвэр гаргах эсэхийг шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх журам, оролцогч талууд болон шүүхийн зүгээс шаардагдах үндэслэл, төлөвлөгөөний үр дагаварт хамаарах бүх мэдээллийг агуулсан байх ёстой. Ялангуяа, төлөвлөгөө нь нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлага хүлээгдэж буй хэмжээгээр хангахад хэрхэн нөлөөлөхийг харьцуулсан тооцоолол орсон байхыг шаарддаг. Хэрэв төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөө нь хуулийн этгээдийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхээр тусгасан бол, төлөвлөгөөгүй тохиолдолд ч мөн тухайн компани үйл ажиллагаагаа үргэлжлүүлнэ гэж үзэх нь ерөнхий зарчим юм. Гэвч, хэрэв тухайн компанийн худалдах эсвэл өөр ямар нэг хэлбэрээр бизнесийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломжгүй гэж үзвэл энэ зарчим хамаарахгүй.

Үүнээс гадна, төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөө нь компанийн нэгдлийн хүрээнд гуравдагч этгээдийн баталгаатай холбоотой нэхэмжлэгчдийн эрхэд хөндлөнгөөс нөлөөлж байгаа бол баталгаа гаргасан хамаарал бүхий компанийн нөхцөл байдал болон төлөвлөгөөний уг компанид үзүүлэх нөлөөллийг мөн адил тодорхой тусгасан байх ёстой(section 220).

Төлбөрийн чадваргүйдлийн бүрдүүлбэр/constructive/ хэсэг нь уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажиллагаанд оролцогч талуудын эрх зүйн байдлыг хэрхэн өөрчлөхийг зохицуулдаг. Мөн хэрэг гүйцэтгэгчид төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах болон алдаа, дутагдал гарсан тохиолдолд засах эрхийг олгох боломжтой(section 221).

4. Төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөг татгалзах(section 231)

Шүүх нь төлөвлөгөө гарснаас хойш 2 долоо хоногийн дотор шийдвэр гаргах ёстой бөгөөд дараах тохиолдолд шүүх нь төлөвлөгөөг татгалзана:

- 1) Төлөвлөгөө гаргах эрх болон түүний агуулгатай холбоотой зохицуулалт, ялангуяа групп үүсгэхтэй холбоотой заалтуудыг зөрчсөн бөгөөд төлөвлөгөө гаргасан этгээд тус зөрчлийг засч чадахгүй эсвэл шүүхээс тогтоосон зохистой хугацаанд засаагүй.
- 2) Хариуцагчаас гаргасан төлөвлөгөөг уг ажиллагаанд оролцогч талууд хүлээн зөвшөөрөх магадлал бараг байхгүй эсвэл шүүхээр батлагдах боломжгүй нь илт байгаа тохиолдол.
- 3) Хариуцагчийн гаргасан төлөвлөгөөний бүтцийн хэсэгт заасан эрх болон нэхэмжлэл хангах нөхцөлүүд нь бодитоор хэрэгжих боломжгүй.

Мөн хариуцагч өмнө нь төлөвлөгөө гаргасан бөгөөд дараах аль нэг тохиолдолд хамаарч байвал дахин гаргасан төлөвлөгөөг татгалзана:

- Ажиллагаанд оролцогч талууд уг төлөвлөгөөг татгалзсан,
- Шүүхээр батлагдаагүй,
- Хэлэлцүүлгийн хурал зарлагдсаны дараа хариуцагч буцаан татсан бол,
- зээлдүүлэгчдийн хороо (байгуулагдсан бол)-ны зөвшөөрлөөр хэрэг гүйцэтгэгч хүсэлт гаргасан тохиолдол.

Төлөвлөгөө гаргасан этгээд нь төлөвлөгөөг хүчингүй болгосон шийдвэрт нэн даруй давж заалдах эрхтэй.

5. Төлөвлөгөөнд санал авах, батлах

Хэрэв төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөг хүчингүй болгоогүй бол шүүх нь дараах этгээдүүдэд уг төлөвлөгөөг илгээж санал авах үүрэгтэй. Ялангуяа нэхэмжлэлийн шаардлага хангахтай холбоотой харьцуулсан тооцоололд хамаарах санал чухалд тооцогдоно(section 232):

- 1) Зээлдүүлэгчдийн хороо (байгуулагдсан бол), ажилтнуудын зөвлөл, удирдах ажилтны төлөөлөл
- 2) Хэрэв төлөвлөгөөг хэрэг гүйцэтгэгч гаргасан бол хариуцагч,
- 3) Хэрэв төлөвлөгөөг хариуцагч гаргасан бол хэрэг гүйцэтгэгч

Мөн шүүх нь хариуцагчтай холбогдолтой үйлдвэр, худалдаа, гар урлал эсвэл хөдөө аж ахуйн салбарын албан ёсны төлөөлөгч байгууллага болон бусад мэргэжлийн байгууллагуудад санал гаргах боломж олгож болдог. Шүүх нь санал өгөх хугацааг тогтоох ёстой бөгөөд энэ хугацаа нь зарчмын хувьд 2 долоо хоногоос хэтрэх ёсгүй. Мөн төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөг хүчингүй болгох эсэх шийдвэрийг гаргахаасаа өмнө дээрх этгээдүүдээс санал авч болдог. Шүүх нь төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөг хэлэлцэх болон ажиллагаанд оролцогч талуудын санал өгөх эрхийг хангасны дараа нь төлөвлөгөөнд санал хураах хурал товлонго(section 235).

Төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөг нэхэмжлэгчдийн зүгээс батлахын тулд групп тус бүрт дараах хоёр нөхцөлийг зэрэг хангах ёстой:

1. Санал өгөх эрхтэй нэхэмжлэгчдийн олонх нь төлөвлөгөөг дэмжсэн байх,
2. Төлөвлөгөөг дэмжсэн нэхэмжлэгчдийн нийт шаардлагын дүн нь санал өгөх эрхтэй бүх зээлдүүлэгчдийн нийт шаардлагын дүнгийн тал хэмжээнээс их байх.

Төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөө нь уг ажиллагаанд оролцогч талуудын зөвшөөрөл, хариуцагчийн зөвшөөрлийг авсны дараа шүүхийн баталгаажуулна(248). Төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөг баталсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон даруйд төлөвлөгөөний бүрдэл хэсэгт туссан үр дагавар нь ажиллагаанд оролцогч бүх талуудад заавал биелэгдэх үр дагавар үүсгэнэ(section 254).

В. БНСУ-ын хуулийн этгээдийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, сэргээхэд чиглэсэн зохицуулалт

БНСУ-ын хувьд хуулийн этгээдийн дахин хөрөнгөжүүлэх үйл явцад шүүгчийн оролцоо өндөр байдаг. Энэ нь ердийн шүүгчийн ажлаас тэс өөр шинж чанартай байдаг. Жишээлбэл, эдгээр ажилд хэрэг гүйцэтгэгчийн зөвшөөрлийн өргөдлийг хянан, “баталгаажуулах” ажил, компанийн нөхцөл байдлын талаар тогтмол тайлан хүлээн авах ажил, нягтлан бодох бүртгэлийн аудиторын шалгалтын тайлан, нэхэмжлэгчдийн гомдлыг хүлээн авч, дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө зохистой эсэхийг хянах, зээлийн шалгалтын тайланг хэрэг гүйцэтгэгчтэй хамтран хянах, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгч зэрэг холбогдох талуудтай уулзаж, санал сонсох, нэгдэн нийлэх, худалдан авах үйл явцад зөвлөх компанийг сонгох эсвэл ямар төрлийн нэгдэн нийлэх, худалдан авах арга хамгийн тохиромжтой вэ, өрсөлдөөнийг хэрхэн өдөөж болохыг хянах ажил зэрэг багтана.⁷⁵

1. Дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх хүсэлт өгөх эрх бүхий субъект

Хариуцагчийн дахин хөрөнгөжүүлэлт ба дампуурлын тухай хуулийн 34 дүгээр зүйл нь дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлэх хүсэлтийг гаргах эрх бүхий этгээд болон шаардлагыг тодорхойлсон байдаг. Зарчмын хувьд дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг хариуцагч өөрөө хүсэлт гаргаж эхлүүлдэг бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

- 1) Төлбөрийн хугацаа нь болсон өрийг төлөх боломжгүй болсон, эсхүл
- 2) Дампуурлын нөхцөл үүсэх бодит эрсдэл байгаа.

Үүнээс гадна дараах этгээдүүдэд мөн хүсэлт гаргах эрхийг хуулиар олгосон:

- 1) Хариуцагч нь хувьцаат компани эсвэл хязгаарлагдмал хариуцлагатай компани байвал:
 - Хувь нийлүүлсэн хөрөнгийн 10 ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй зээлдүүлэгч эсвэл хувьцаа эсвэл хувь оролцооны 10 ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч/гишүүн
- 2) Хариуцагч нь бусад төрлийн хуулийн этгээд буюу түүнтэй адилтгах субъект байвал:
 - 50 сая воноос дээш хэмжээний өрийн шаардлага бүхий зээлдүүлэгч, эсхүл
 - Нийт хөрөнгө оруулалтын 10 ба түүнээс дээш хувийн хувь эзэмшигч(article 34)

2. Нотлох үүрэг

Дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргаж буй этгээд нь дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлэх үндэслэл болсон баримт, нөхцөл байдлыг нотлох үүрэгтэй. Хэрэв зээлдүүлэгч, хувьцаа эзэмшигч эсвэл гишүүн нь дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргах тохиолдолд өөрийн эзэмшиж буй өрийн хэмжээ, эсвэл хувьцаа/хувь эзэмшлийн тоо, хэмжээ зэргийг мөн адил нотлох шаардлагатай(article 38). Дараах аль нэг

⁷⁵ 이연갑. "기업회생절차에서 법원의 역할에 대한 입법론적 검토" 법학연구 28, no.1 (2017), 361.

нөхцөлд шүүх нь дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлэх хүсэлтийг хэрэгсэхгүй болгоно. Энэ тохиолдолд удирдлагын хорооны санал бодлыг сонсох шаардлагатай:

- 1) Дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны зардлыг урьдчилан төлөөгүй бол
- 2) Дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлэх хүсэлт нь хуурмаг, шударга бус бол
- 3) Дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа нь нийт зээлдүүлэгчдийн ашиг сонирхолд нийцэхгүй гэж үзвэл(article 42)

3. Хөрөнгийн хамгаалалт

Хуулийн этгээдийг дахин хөрөнгөжүүлэх зорилгод хүрэхийн тулд хариуцагчийн хөрөнгийг хамгаалах нь зайлшгүй шаардлагатай. Иймд Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хуульд дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлэх тухай хүсэлт гаргасны дараа, эхлүүлэх шийдвэр гарах хүртэл оролцогч талуудын хүсэлтийн дагуу шүүх хөрөнгө хамгаалах арга хэмжээ (article 43(2)) болон хамгаалалтыг хариуцсан багийг(article 43(3))-ийг томилдог.

Мөн шүүх нь бие даасан ажиллагааг зогсоох тухай захирамж (article 44)-аар дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны зорилго хангалттай хэмжээнд биелэгдэхгүй байх эрсдэлтэй онцгой нөхцөл байдал тогтоогдсон тохиолдолд холбогдох этгээдийн хүсэлтээр эсвэл шүүхийн санаачилгаар дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны нэхэмжлэл болон барьцаат нэхэмжлэлд үндэслэсэн албадан гүйцэтгэл зэрэг үйл ажиллагааг хориглох (article 45) боломжтой.

4. Дахин хөрөнгөжүүлэх шүүхийн шийдвэр, түүний үр дагавар

БНСУ-ын Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу хариуцагч нь дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд шүүх нь тухайн хүсэлт гаргасан өдрөөс хойш 1 сарын дотор дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх эсэх шийдвэрийг гаргах ёстой байдаг. Дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх шийдвэрт тухайн шийдвэрийг гаргасан он, сар, өдөр, цагийг заавал тусгах бөгөөд шийдвэр нь гаргасан цаг мөчөөс эхлэн хүчин төгөлдөр болдог. Шүүх нь дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлэх шийдвэр гаргахтай зэрэгцэн, хэрэг гүйцэтгэгчдийн хороо(The Custodial Committee)⁷⁶ болон нэхэмжлэгчдийн зөвлөлөөс санал авч, нэг буюу хэд хэдэн хэрэг эрхлэгч((Custodian)-ийг томилдог(article 50).

Дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг эхлүүлэх шүүхийн шийдвэр гармагц хариуцагчийн удирдлагын үйл ажиллагаа явуулах болон эд хөрөнгийг захиран зарцуулах эрх нь хэрэг гүйцэтгэгчид шилжинэ(article 56). Дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхэлсэн цагаас эхлэн уг ажиллагаа дуусах хүртэл, хариуцагч нь дараах үйлдлүүдийг уг ажиллагааны хүрээнд хийгээгүй тохиолдолд хэрэгжүүлэх эрхгүй:

- 1) Хувь нийлүүлсэн хөрөнгө эсвэл хөрөнгө оруулалтын хэмжээг бууруулах

⁷⁶ Хариуцагчийн дахин хөрөнгөжүүлэлт болон дампуурлын тухай хуульд заасан журмыг зөв, шуурхай явуулахын туалд Улсын дээд шүүх нь шүүхийн дэргэд хэрэг гүйцэтгэгчийн хороог байгуулдаг(article 15).

- 2) Хувь оролцооны эрх эзэмшигчийг шинээр элсүүлэх, шинэ хувьцаа эсвэл бонд гаргах
- 3) Хувь нийлүүлсэн хөрөнгө буюу хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх
- 4) Хувьцааг багц хэлбэрээр солих буюу шилжүүлэх
- 5) Нэгдэх, хуваагдах эсвэл хуулийн хэлбэрээ өөрчлөх
- 6) Компанийг татан буулгах эсвэл үйл ажиллагааг үргэлжлүүлэх
- 7) Ашиг, хүүгийн ноогдол тараах

Мөн дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлэх шүүхийн шийдвэр гарснаар уг ажиллагааны бодит хэрэгжилтийг хангах зорилгоор тодорхой хууль зүйн үр дагаврууд үүснэ. Нэгдүгээрт, дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны хүрээнээс гадуур шинэчилсэн дампуурлын эсвэл дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны хүсэлт гаргах, дахин хөрөнгөжүүлэх ажиллаганы нэхэмжлэл болон барьцаат нэхэмжлэлийг үндэслэсэн албадан гүйцэтгэл хийх, давуу эрхгүй татварын өр дээр үндэслэсэн албадан хураах ажиллагаа зэргийг хийхийг бүрэн хориглох бөгөөд хоёрдугаарт, аль хэдийн хэрэгжиж байсан дампуурлын ажиллагаа болон дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны нэхэмжлэл, барьцаат нэхэмжлэлийг үндэслэсэн албадан гүйцэтгэл хийх, татварын албадан хураалт хийх үйл ажиллагаа автоматаар зогсоно. Гуравдугаарт, тодорхой хугацаанд буюу "Татварын албадан хураалтын тухай хууль" болон "Орон нутгийн татварын тухай хууль"-ийн дагуух албадан хураалт ч мөн түр хугацаанд хориглогддог(article 58).

5. Санхүүгийн шинжээчийн үүрэг, оролцоо

Шүүх шаардлагатай гэж үзвэл зээлдүүлэгчдийн зөвлөл болон хэрэг гүйцэтгэгчийн хорооны саналыг үндэслэн нэг буюу хэд хэдэн хянан шалгагч(Inspector) томилж болдогбөгөөд хянан шалгагч нь мөрдөн шалгалт хийхэд шаардлагатай мэдлэг, туршлагатай, тухайн дахин хөрөнгөжүүлэлтийн ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилгүй этгээдээс томилогдоно(article 87). Шүүх хянан шалгагч томилсон тохиолдолд нэн даруй дахин хөрөнгөжүүлэх хариуцагчийн хөрөнгийг үнэлэх, хөрөнгийн жагсаалт болон тайлан баланс гаргах, хяналт шалгалтын тайланг гаргах үүргийг тус тус хүлээнэ(article 87(3)). Дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхэлсний дараа, зээл олгох гэж буй этгээд нь өр төлбөр, хөрөнгө болон бусад санхүүгийн байдалтай холбоотой мэдээлэл хүссэн тохиолдолд шүүх уг мэдээллийг үндэслэлтэй буюу компанийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд шаардлагатай гэж үзвэл хянан шалгагчаар холбогдох асуудлыг тогтоолгож, хяналт шалгалтын үр дүнг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн тухайн хүсэлт гаргасан этгээдэд хүргүүлэх боломжтой байдаг(article 87(6)).

Дөрөв. Дампуурлын ажиллагаа дуусгавар болох үндэслэл

Монгол Улсын Дампуурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т зааснаар шүүх дараах үндэслэлээр хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргана:

1. Хуулийн 23.1-д заасан этгээд дахин хөрөнгөжүүлэх тухай хүсэлтийг шүүхэд ирүүлээгүй;
2. Шүүх төлөвлөгөөг батлаагүй, эсхүл төлөвлөгөөг шүүхэд ирүүлээгүй
3. Төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй болсон.

Шүүхээс дээр дурдсан үндэслэлээр хариуцагчийн дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 хоногийн дотор шүүх энэ тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ. Мөн хуулийн 38.1-т зааснаар хариуцагчийг татан буулгах тухай шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг шүүхийн хяналт, оролцоогүйгээр явуулах эсэхийг нэхэмжлэгчдийн хурлаас шийдвэрлэдэг журамтай.

А. ХБНГУ-ын зохицуулалт

ХБНГУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуульд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгох хэд хэдэн зохицуулалтыг дараах байдлаар зохицуулсан.

1. Нэхэмжлэгчдийн шаардлагыг хангах замаар дампуурлын ажиллагааг дуусгавар болгох

Хуулийн 187 дугаар зүйлд зааснаар Нэхэмжлэгчдийн төлбөрийг барагдуулах ажиллагаа нь ерөнхий хяналтын хурлын дараах эхлэх бөгөөд нэхэмжлэгчдийн хурлаар эцсийн хуваарилалтыг зөвшөөрч,⁷⁷ хийсэн тохиолдолд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгоно.

Тус хуулийн 197 дугаар зүйлд зааснаар Шүүх нь эцсийн хуваарилалтыг зөвшөөрвөл сүүлийн хурлын товыг зарлана. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ:

- Сүүлийн санхүүгийн тайлан
- Бүртгэлтэй холбоотой эсэргүүцэл
- Дампуурлын хөрөнгийн бүрэлдэхүүнд багтаж байгаа боловч бодит хөрвүүлэлтэд тохирохгүй эд зүйлсийн талаарх шийдвэрийн Нэхэмжлэгчид гаргана.

Хурлын товыг нийтэд зарласан өдрөөс хурал болох хүртэлх хугацаа нь 1 сараас багагүй, 2 сараас ихгүй байна. Мөн хуулийн 200 дугаар зүйлд зааснаар Эцсийн хуваарилалт биелэгдсэний дараа шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэр гаргана. Тус шийдвэр түүний үндэслэлийг нийтэд зарлана.

2. Хөрөнгө хүрэлцээгүйгээс шалтгаалсан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсоох

Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхэлсний дараа уг ажиллагааны зардлыг нөхөхөд төлбөрийн чадваргүйдлийн хөрөнгө хүрэлцэхгүй нь тогтоогдвол, төлбөрийн чадваргүйдлийн шүүх уг ажиллагааг зогсох шийдвэр гаргах эрхтэй. Хуульд заасан журмын дагуу төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсоох хүсэлтийг нийтэд зарлана. Хэргийн оролцогчид нь тус шийдвэрт давж заалдах журмаар гомдол гаргах эрхтэй.

3. Төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөг баталснаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа дуусгавар болох

⁷⁷ Insolvency Code of Germany, Article 197-200

Шүүх нь хуулийн 258 дугаар зүйлд зааснаар төлбөрийн чадваргүйдлийн төлөвлөгөөг батлагдсан даруйд төлөвлөгөөнд өөрөөр заагаагүй бол, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгох шийдвэр гаргах бүрэн эрхтэй. Уг шийдвэрт ажиллагааг дуусгах огноог заана. Энэ огноо нь ердийн тохиолдолд шийдвэр гаргаснаас хойш хамгийн багадаа хоёр хоногийн дараа байна. Тус шийдвэрийг болон төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгах шалтгааныг нийтэд мэдээлнэ.

В. БНСУ-ын зохицуулалт⁷⁸

БНСУ-ын Дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хуулийн 317 дугаар зүйлд зааснаар Хариуцагчийн хөрөнгө нь дампуурлын ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй гэж үзвэл шүүхээс тухайн этгээдийг дампуурсанд тооцож, дампуурлын ажиллагааг зогсоох шийдвэр гаргана.

Мөн зүйлийн 317.2-т заасны дагуу дампуурсанд тооцсон, дампуурлын ажиллагааг зогсоосон шийдвэрүүдийн товч агуулга, мөн шийдвэр гаргасан үндэслэлийг хураангуй нийтэд зарлана. Тус шийдвэрт гомдол гаргах эрхтэй боловч гомдол гаргасан нь шийдвэрийн гүйцэтгэлийг түдгэлзүүлэх үндэслэлгүй болохгүй бөгөөд дампуурлын зогсоох шийдвэр хүчин төгөлдөр болсноор холбогдох захиргааны байгууллагад мэдэгдэнэ.⁷⁹ Шүүх нь хариуцагчийн хүсэлтээр дараах тохиолдолд дампуурлын ажиллагааг зогсоох шийдвэр гаргаж болно:

- a. Нэхэмжлэлийн тайлан гаргах хугацаанд бүх дампуурлын ажиллагааны нэхэмжлэгч нартай тохиролцож, гэрээ байгуулсан.
- b. Гэрээ байгуулах нөхцөлд, бусад нэхэмжлэгч нартай тохиролцож, тэдний зөвшөөрөлтэйгөөр барьцаа хөрөнгө хүлээн авсан.⁸⁰

Шүүхээс гарсан дампуурлын зогсоох тухай хүсэлтийн товч агуулгыг нийтэд зарлаж, холбогдох баримтыг сонирхсон этгээд үзэх боломжтой байдлаар хадгална.⁸¹ Мөн хуулийн 545 дугаар зүйлд заасны дагуу хэрэв хөрөнгө нь дампуурлын ажиллагааны зардлыг төлөх боломжгүй гэж шүүх үзвэл, хэрэг гүйцэтгэгчийн хүсэлт эсхүл шүүгч өөрийн санаачилгаар дампуурлыг зогсоох шийдвэр гаргана.

Дээр дурдсан дампуурлын зогсоох шийдвэрийн товч агуулгыг нийтэд зарлах бөгөөд хэргийн оролцогчдоос гомдол гаргах эрхтэй. Хуулийн 549 дүгээр зүйлд зааснаар 549.1-т зааснаар Хариуцагчийн хөрөнгө хэмжээ 500 сая воноос бага гэж шүүх үзвэл, шүүх нь дампуурлыг зарлахтай дампуурлын ажиллагааг хэрэгжүүлнэ. Хялбаршуулсан дампуурлын ажиллагааны үр дүнд гарсан шийдвэрийг олон нийтэд мэдээлнэ.

78 The Debtor Rehabilitation and bankruptcy act of the Republic of Korea, [Enforcement Date 01. Mar, 2023.] [Act No.19102, 27. Dec, 2022., Partial Amendment]
<https://www.law.go.kr/engLsSc.do?menuId=1&subMenuId=21&tabMenuId=117&query=%ED%9A%8C%EC%83%9D#>

⁷⁹ The Debtor Rehabilitation and bankruptcy act of the Republic of Korea, Article 317.4, 317.5, 313-315

⁸⁰ The Debtor Rehabilitation and bankruptcy act of the Republic of Korea, Article 538

⁸¹ The Debtor Rehabilitation and bankruptcy act of the Republic of Korea, Article 542

Дүн шинжилгээ

Зохицуулалтын агуулгыг харьцуулж үзвэл, Монгол Улсын Дампуурлын тухай хуульд дампуурсанд тооцож, татан буулгах хүсэлтийг хангах, хэрэгсэхгүй болгох талаар шийдвэр гаргах хувилбаруудыг шууд зохицуулсан бөгөөд илүү хязгаарлагдмал агуулгатай. ХБНГУ, БНСУ-ын шийдвэрийг үзвэл, хүсэлт хангахгүйгээр, дампуурлын ажиллагааг дуусгавар болгох, хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагааг сэргээх, татан буулгахгүй, үргэлжлүүлэх ажиллах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах замаар дампуурлын ажиллагааг дуусгавар болгох үндэслэлүүдийг тухайлан дурдсан байгааг анхаарч үзэх нь зүйтэй байна.